



ШУДАРГА ЁС,
ХӨГЖИЛ
ДЭВШИЛД



БОДЛОГЫН ШИЙДЭЛ

ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-2025 судалгааны тайлан

Улаанбаатар хот, 2025 он

ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-2025 судалгааны тайлан

Захиалагч: Авлигатай тэмцэх газар
Гүйцэтгэгч: “Бодлогын шийдэл” ТББ

Судалгааны мэдээллийг ашиглахтай холбоотой бүх эрхийг “Авлигатай тэмцэх газар” эзэмшинэ. Тайланд дурдагдаж буй үр дүнг АТГ-аас хараат бус байдлаар гүйцэтгэсэн бөгөөд “Бодлогын шийдэл” ТББ-аас явуулсан судалгаанд оролцогчдын үнэлгээний үр дүнд үндэслэгдсэн болно.

СУДАЛГААНЫ БАГ:

Судалгааны багийн ахлагч: Доктор Ж.Баттулга

Тайлан боловсруулсан: Доктор П.Буяннэмэх

Мэдээлэл цуглуулалтын баг:

Г.Оюун-Эрдэнэ
Ж.Сувдаа
А.Энхтуяа
О.Балжин
З.Сайнжаргал
Л.Баярцэцэг
Б.Гантөмөр
И.Батхишиг
Б.Нарантуяа
Л.Мишээл
Г.Бадамцэцэг
Д.Итгэлмаа
н.Баяртуяа
н.Номундарь
Н.Эрдэнэцэцэг

АГУУЛГА

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	i
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	iii
ТАЛАРХАЛ	iv
ХУРААНГУЙ	1
БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	3
1.1 Шударга байдлын үнэлгээний судалгааны аргачлал	3
1.2 Судалгааны хамрах хүрээ	6
1.3 Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт	6
БҮЛЭГ II. ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ҮР ДҮН.....	8
2.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	8
2.2 Шударга байдлын үнэлгээний ерөнхий үр дүн.....	9
2.3 ШБҮ-ээр хамгийн бага үнэлгээтэй байгууллагуудын үр дүн	31
БҮЛЭГ III. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ	57
3.1 Монгол улс дах авлигын өнөөгийн нөхцөл байдал	57
3.2 Монгол улс дах авлига хамгийн их тархсан институц.....	58
3.3 Монгол улс дах авлигын шалтгаан.....	59
3.4 Авлигыг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай ажлын чиглэл	60
3.5 Монгол улс дах авлигын түвшин ирэх 2 жилд хэрхэн өөрчлөгдөх талаар төсөөлөл	61
3.6 Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр дүн.....	62
ДҮГНЭЛТ	64
ЗӨВЛӨМЖ, САНАЛ	69
ХАВСРАЛТУУД	70

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. 1-5 ХҮРТЭЛ ХЭМЖЭЭС БҮХИЙ ХАРИУЛТЫГ ШБУ-НИЙ 0-100 ОНООНД ШИЛЖҮҮЛЭХ .	5
ХҮСНЭГТ 2. ГАДААД ШУДАРГА БАЙДЛЫН ХУВЬД ДАВТАМЖ, ҮНИЙН ДҮНГ ОНООЖУУЛАХ	5
ХҮСНЭГТ 3. ГАДААД ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	8
ХҮСНЭГТ 4. ДОТООД ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНД ХАМРАГДСАН ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	8
ХҮСНЭГТ 5. БОДЛОГОД ОРОЛЦОГЧДЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНД ХАМРАГДСАН БОДЛОГОД ОРОЛЦОГЧ, ШИНЖЭЭЧДИЙН МЭДЭЭЛЭЛ	9
ХҮСНЭГТ 6. ШБУ-НИЙ БҮРЭЛДЭХҮҮН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨРЛӨӨР, 2025 ОН	13
ХҮСНЭГТ 7. ШБУ-ЭЭР ХАМГИЙН ӨНДӨР БОЛОН ХАМГИЙН БАГА ОНООТОЙ БАЙГУУЛЛАГУУД .	14
ХҮСНЭГТ 8. ЯАМДЫН ГШБУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ҮНЭЛГЭЭ, ӨӨРЧЛӨЛТ	16
ХҮСНЭГТ 9. ЯАМДЫН ДШБУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ҮНЭЛГЭЭ, ӨӨРЧЛӨЛТ	17
ХҮСНЭГТ 10. ЯАМДЫН БОУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ҮНЭЛГЭЭ, ӨӨРЧЛӨЛТ	17
ХҮСНЭГТ 11. АГЕНТЛАГУУДЫН ГШБУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ҮНЭЛГЭЭ, ӨӨРЧЛӨЛТ	20
ХҮСНЭГТ 12. АГЕНТЛАГУУДЫН ДШБУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ҮНЭЛГЭЭ, ӨӨРЧЛӨЛТ	20
ХҮСНЭГТ 13. АГЕНТЛАГУУДЫН БОУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ҮНЭЛГЭЭ, ӨӨРЧЛӨЛТ	21
ХҮСНЭГТ 14. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-УУДЫН ГШБУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ҮНЭЛГЭЭ, ӨӨРЧЛӨЛТ	24
ХҮСНЭГТ 15. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-УУДЫН ДШБУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ҮНЭЛГЭЭ, ӨӨРЧЛӨЛТ	25
ХҮСНЭГТ 16. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-УУДЫН БОУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ҮНЭЛГЭЭ, ӨӨРЧЛӨЛТ	25
ХҮСНЭГТ 17. ДҮҮРГИЙН ЗДТГ-УУДЫН ГШБУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ҮНЭЛГЭЭ, ӨӨРЧЛӨЛТ	29
ХҮСНЭГТ 18. ДҮҮРГИЙН ЗДТГ-УУДЫН ДШБУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ҮНЭЛГЭЭ, ӨӨРЧЛӨЛТ	30
ХҮСНЭГТ 19. ДҮҮРГИЙН ЗДТГ-УУДЫН БОУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ҮНЭЛГЭЭ, ӨӨРЧЛӨЛТ .	30
ХҮСНЭГТ 20. БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ШБУ БА ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	32
ХҮСНЭГТ 21. ДОРНОД АЙМГИЙН ЗДТГ-ЫН ШБУ БА ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	34
ХҮСНЭГТ 22. ХОВД АЙМГИЙН ЗДТГ-ЫН ШБУ БА ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	37
ХҮСНЭГТ 23. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ШБУ БА ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	39
ХҮСНЭГТ 24. МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ШБУ БА ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	42
ХҮСНЭГТ 25. БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ШБУ, ТҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	44
ХҮСНЭГТ 26. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ШБУ, ТҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	46
ХҮСНЭГТ 27. АРХАНГАЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ШБУ, ТҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	49
ХҮСНЭГТ 28. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗДТГ-ЫН ШБУ, ТҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ ...	51
ХҮСНЭГТ 29. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ШБУ, ТҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	54
ХҮСНЭГТ 30. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛИЙН ТӨСӨӨЛӨЛ, СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ТӨРЛӨӨР	58
ХҮСНЭГТ 31. МОНГОЛ УЛСАД АВЛИГА ХАМГИЙН ИХ ТАРХСАН ИНСТИТУТ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР, 2025 ОНЫ ЭРЭМБЭЭР, НИЙТ ОРОЛЦОГЧДООР, ХУВИЙН ЖИНГЭЭР	58
ХҮСНЭГТ 32. МОНГОЛ УЛСАД АВЛИГА ХАМГИЙН ИХ ТАРХСАН ИНСТИТУТ, ОРОЛЦОГЧДЫН ТӨРЛӨӨР	58
ХҮСНЭГТ 33. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ҮНДСЭН ШАЛТГААН, СУДАЛГААНД НИЙТ ОРОЛЦОГЧДЫН ХАРИУЛТААР	60
ХҮСНЭГТ 34. АВЛИГЫГ БУУРУУЛАХ, АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙХ ШААРДЛАГАТАЙ АЖЛЫН ЧИГЛЭЛ	61
ХҮСНЭГТ 35. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ТҮВШНИЙ ИРЭХ 2 ЖИЛИЙН ТӨСӨӨЛӨЛ, СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ТӨРЛӨӨР	62

ХҮСНЭГТ 36. АТГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ОРОЛЦОГЧДЫН ТӨРЛӨӨР	63
ЗУРАГ 1: ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙН ЗАГВАР	3
ЗУРАГ 2. ТҮҮВРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ.....	6
ЗУРАГ 3. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	7
ЗУРАГ 4. ШБҮ, БҮРЭЛДЭХҮҮН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ОНОО, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР	9
ЗУРАГ 5. ГШБҮ, ДШБҮ, БОУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ, 2024 ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН	10
ЗУРАГ 6. ШБҮ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ҮНЭЛГЭЭ, 2025 ОН	11
ЗУРАГ 7. ШБҮ, БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР, 2021 – 2025 ОН	12
ЗУРАГ 8. ШБҮ-НИЙ БҮРЭЛДЭХҮҮН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ӨӨРЧЛӨЛТ, БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР	13
ЗУРАГ 9. ШБҮ ХАМГИЙН ИХ ӨӨРЧЛӨЛТТЭЙ БАЙГУУЛЛАГУУД, ӨӨРЧЛӨЛТ, ОНООГООР	15
ЗУРАГ 10. ЯАМДЫН ШБҮ, 2015 – 2025 ОН	16
ЗУРАГ 11. ЯАМДЫН ШБҮ, 2024 БА 2025 ОНЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ, 2025 ОНЫ ЭРЭМБЭЭР..	18
ЗУРАГ 12. АГЕНТЛАГУУДЫН ШБҮ, 2015 – 2025 ОН.....	19
ЗУРАГ 13. АГЕНТЛАГУУДЫН ШБҮ, 2024 БА 2025 ОНЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ, 2025 ОНЫ ЭРЭМБЭЭР	23
ЗУРАГ 14. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-УУДЫН ШБҮ, 2015-2025 ОН.....	24
ЗУРАГ 15. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-УУДЫН ШБҮ, 2024 БА 2025 ОНЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ, 2025 ОНЫ ЭРЭМБЭЭР.....	27
ЗУРАГ 16. ДҮҮРГҮҮДИЙН ШБҮ, 2022 – 2025	28
ЗУРАГ 17. ДҮҮРГИЙН ЗДТГ-УУДЫН ШБҮ, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН ҮНЭЛГЭЭ, 2022-2025 ОН	29
ЗУРАГ 18. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-УУДЫН ШБҮ, 2024 БА 2025 ОНЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ, 2025 ОНЫ ЭРЭМБЭЭР.....	31
ЗУРАГ 19. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР	57
ЗУРАГ 20. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ТҮВШИН ИРЭХ 2 ЖИЛД ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДӨХ ТАЛААР ТӨСӨӨЛӨЛ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР	62
ЗУРАГ 21. АТГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТӨСӨӨЛӨЛ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР	63

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АТГ	Авлигатай тэмцэх газар
БОҮ	Бодлогод оролцогч, шинжээчдийн үнэлгээ
ГШБҮ	Гадаад шударга байдлын үнэлгээ
ДШБҮ	Дотоод шударга байдлын үнэлгээ
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ШБҮ	Шударга байдлын үнэлгээ
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан
ТАХ	Төрийн албан хаагч

ТАЛАРХАЛ

“Шударга байдлын үнэлгээ - 2025” судалгааны ажлыг зохион байгуулахад санхүүжилт олгож судалгааны арга зүйн зөвлөгөө өгсөн “Авлигатай тэмцэх газар”-ын хамт олонд, мөн судалгааны тоон мэдээлэл цуглуулахад хамтран ажилласан төрийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнууд, судалгааны тоон мэдээлэл цуглуулалтад хамтран ажилласан байгууллага, хувь хүмүүст талархлаа илэрхийлье

ХУРААНГУЙ

Шударга байдлын үнэлгээний (ШБҮ) судалгааг төрийн байгууллагуудын шударга байдлын түвшин, авлигын эрсдэлт хүчин зүйлсийг үнэлэх, тухайн байгууллагын шударга байдлыг бэхжүүлэх идэвх, санаачилгыг дэмжих зорилгоор Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг ба энэ оны судалгаа нь 9 дэх удаагийн судалгаа болж байна.

ШБҮ нь төрийн үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгжийн үнэлгээ буюу гадаад шударга байдлын үнэлгээ (ГШБҮ), төрийн байгууллагын албан хаагчдын үнэлгээ буюу дотоод шударга байдлын үнэлгээ (ДШБҮ) болон тухайн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой бодлогод оролцогч, шинжээчдээс авах үнэлгээ буюу бодлогод оролцогчдын үнэлгээ (БОУ) гэсэн гурван бүрэлдэхүүнээр тодорхойлогддог. ШБҮ-ний судалгааны хүрээнд дээрх бүрэлдэхүүн тус бүрээр тусдаа нарийвчилсан тайлан гаргадаг бөгөөд энэхүү тайлан нь нийт ШБҮ-ний үр дүнг танилцуулах нэгдсэн тайлан болно.

2025 оны төрийн байгууллагуудын шударга байдлын судалгааг “Бодлогын шийдэл” ТББ 2025 оны 05 сарын 20-оос 2025 оны 07 сарын 20-ны хооронд нийт 2 сарын хугацаанд амжилттай зохион байгууллаа. “Шударга байдлын үнэлгээ-2025” судалгаанд төрийн 81 байгууллагаар үйлчлүүлсэн 10840 иргэд, ААН-ийн төлөөлөл, 2660 төрийн албан хаагчдын төлөөлөл, 1530 бодлогод, оролцогч, шинжээчид хамрагдсан ба мэдээлэл цуглуулалтыг Улаанбаатар хот болон 21 аймаг даяар зохион байгуулсан. Төрийн гүйцэтгэх эрх мэдлийн 81 байгууллагад 16 яам, 34 агентлаг, 21 аймгийн ЗДТГ, нийслэл, дүүргийн 10 ЗДТГ багтаж байна.

2025 оны төрийн байгууллагуудын дундаж ШБҮ нь 74.9 болж, өмнөх онтой харьцуулахад 2.3 оноогоор өссөн. ШБҮ-ний бүрэлдэхүүн болох ГШБҮ 1.6 оноогоор, ДШБҮ 0.8 оноогоор, БОУ 4.5 оноогоор тус тус өссөнөөр ШБҮ-ний дундаж оноог нэмэгдүүлжээ. Бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн 2025 оны үнэлгээ нь ГШБҮ 70.7, ДШБҮ 82.4 ба БОУ 71.7 гэсэн үр дүнтэй байна.

ШБҮ бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийг үнэлэхэд 16 дэд үзүүлэлтийг ашигладаг ба үүнээс 13 үзүүлэлтийн үнэлгээ өсөж, 2 үзүүлэлтийнх буурсан бол 1 үзүүлэлт өөрчлөлтгүй гарсан байна. Хэдийгээр ийнхүү өсөлттэй үзүүлэлт олон боловч хангалтгүй үнэлгээтэй буюу сайжруулах шаардлагатай хүчин зүйлүүд цөөнгүй байна. Хамгийн бага үнэлгээтэй байгаа дэд үзүүлэлтүүдэд авлигыг хянах механизм (БОУ) 51.8, ил тод байдал (ГШБҮ) 59.7, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (БОУ) 64.8 (БОУ-ний Хавсралт 2-ын УАТХ-ийн дундаж 65.3 гэж гарч байна), авлигын талаарх төсөөлөл (ГШБҮ) 65.6, хариуцлагатай байдал (ГШБҮ) 67.0, авлигын эсрэг тогтолцоо (ДШБҮ) 69.5 зэрэг багтаж байна. Өмнөх оны судалгаанд дээрх 6 үзүүлэлт мөн энэ дарааллаараа хамгийн бага үнэлгээг авсан байжээ. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагын холбоотой талууд нь ил тод ба хариуцлагатай байдлыг, авлигыг хянах механизм буюу авлигын эсрэг тогтолцоо, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл гэсэн зүйлсийг хангалтгүй гэж үзсэн хэвээр байна.

Төрийн байгууллагуудын төрлөөр ШБҮ-ний гүйцэтгэлийг харвал яамдын ШБҮ 0.8 оноогоор буурч 73.5 дүнтэй, агентлагуудын үнэлгээ 3 оноогоор өсөж, 77.3 гэсэн дүнтэй, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ 3.3 оноогоор өсөж, 72.3 гэсэн үнэлгээг тус тус үзүүлсэн. ШБҮ-ний өөрчлөлтөд аймаг, нийслэлийн ЗДТГ их нөлөөтэй байгаа ч ерөнхий шударга байдлын түвшинд хамгийн бага үнэлгээтэй оролцогч хэвээр байна.

Нийслэлийн 9 дүүргийн ШБҮ-г тусад нь нэгтгэн тайлагнасан ба Дундаж ШБҮ нь өмнөх оноос 4.4 оноогоор өсөж, 76.5 хүрсэн ба бусад төрийн байгууллагуудын дундаж ШБҮ 74.9-ээс дээш үнэлгээтэй байгаа юм. Өмнөх онтой харьцуулахад ГШБҮ ба БОҮ нь харгалзан 8.1 ба 7.0 оноогоор өсөж, ДШБҮ нь 1.8 оноогоор буурсан. 9 дүүргийн ШБҮ бүгд өмнөх оноос өссөн байлаа.

Шударга байдал зөрчигдөх болсон шалтгааныг энэ онд эргээд цалин хөлс бага, амьжиргааны түвшин доогуур зэрэг үзүүлэлт тэргүүлж эхэлсэн ба хувь хүний хандлага, шунал ёс зүй, хүн суртал их байдал, төрийн албан дахь улс төрийн намуудын нөлөөлөл зэрэг шалтгаанууд тэргүүн эгнээнд хадгалагдсан хэвээр байна. Нөгөө талаас шударга байдлыг бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд нэн тэргүүнд хийх шаардлагатай байгаа ажлын чиглэлийг авлига ашиг сонирхлын талаар болон хуулийн мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх гэж тодорхойлсон нь өмнөх онуудад онцолдог цалин хангамжийг нэмэгдүүлэх гэсэн хариултаас ялгаатай байлаа. Үргэлжлээд цалин хангамжийг нэмэгдүүлэх, ил тод байдлыг хангах, хяналтыг сайжруулах зэрэг хариултууд олон давтамжтай хэвээр байна.


2025 оны энэхүү судалгааны тайлангийн эхний бүлэгт судалгааны аргазүй, хамрах хүрээг танилцуулсан. Хоёрдугаар бүлэгт, ШБҮ-ний судалгааны үр дүн, түүнийг бүрэлдэхүүн үзүүлэлтээр болон байгууллагын төрлүүдээр задлан харуулсан болно. Гуравдугаар бүлэгт Монгол Улс дахь авлигын шалтгаан, нөхцөл, хандлагын талаарх асуултуудын үр дүнг тайлагнав. ШБҮ-ний судалгааны үр дүнг хэрэглэгчид нь энэхүү тайлангаас нийт ШБҮ-ний үр дүнг, байгууллагуудын төрлүүдээр шинжилсэн дүгнэлтийг, хавсралтын хамт ашиглах боломжтой бол ГШБҮ, ДШБҮ ба БОҮ-ний тайлангаас хамаарах дэд үзүүлэлт, нэгж асуулт бүрээр дэлгэрэнгүй үр дүн өөрчлөлтийг харж, дүгнэлт хийж, шийдвэр гаргавал зохино.

БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 Шударга байдлын үнэлгээний судалгааны аргачлал

Шударга байдлын үнэлгээний судалгааг АТГ-ын даргын 2015 оны 12 сарын 10-ны өдрийн А/129 тушаалын I хавсралтаар батлагдсан “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Энэхүү аргачлалын дагуу шударга байдлын үнэлгээ нь дараах загвараар тодорхойлогддог (Схем 1).

Зураг 1: Шударга байдлын үнэлгээний арга зүйн загвар



Эх үүсвэр: Шударга байдлын үнэлгээний аргачлал, АТГ, 2015

Шударга байдлын үнэлгээ нь гадаад шударга байдал, дотоод шударга байдал болон бодлогод оролцогчдын үнэлгээнээс бүрддэг бөгөөд гадаад шударга байдлын үнэлгээ нь төрийн байгууллагаар үйлчлүүлэн үйлчилгээ авсан иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудын өгч буй үнэлгээгээр тодорхойлогддог. Шударга байдлын үнэлгээ нь 0-100 хүртэлх оноогоор үнэлэгдэнэ (шударга байдал~100 бол хамгийн шударга байдлыг илэрхийлнэ).

Гадаад шударга байдлыг дараах аргачлалын дагуу тооцно.

$$E_i = (A_i + B_i + C_i)/3$$

E_i - i-р байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ

A_i - авлигын индексийн оноо

B_i - ил тод байдлын индексийн оноо

C_i - хариуцлагатай байдлын оноо

Дотоод шударга байдлыг дараах аргачлалын дагуу тооцно.

$$I_i = (A_i + B_i)/2$$

I_i - i -р байгууллагын дотоод шударга байдлын үнэлгээ

A_i –Соёлын индексийн оноо

B_i – Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын оноо

Бодлогод оролцогчдын үнэлгээг дараах аргачлалын дагуу тооцно.

$$P_i = \frac{A_i + B_i + C_i}{3}$$

P_i - i -р байгууллагын бодлогод оролцогчдын үнэлгээ

A_i - авлигын талаарх төсөөллийн оноо

B_i - авлигын хяналтын оноо

C_i - авлигын хяналтын бодит тохиолдлын тоо

Авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээг төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээгээр илэрхийлнэ. Үүнийг K_i тэмдэглэнэ. (АТГ-ын даргын 2015 оны 09 сарын 01-ний өдрийн А/88 тушаалын дагуу тооцно.)

Шударга байдлын үнэлгээг дараах аргачлалын дагуу тооцно.

$$ШБҮ_i = (E_i + I_i + P_i + K_i)/4$$

ШБҮ $_i$ - i -р байгууллагын шударга байдлын үнэлгээ

E_i - i -р байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ

I_i - i -р байгууллагын дотоод шударга байдлын үнэлгээ

P_i - i -р байгууллагын бодлогод оролцогчдын үнэлгээ

K_i - авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ

Шударга байдлын үнэлгээний судалгаанд ашиглагдаж буй асуулт бүрийг үнэлгээнд үзүүлэлт болгон хамруулахдаа дараах 2 аргын ашиглалаа. Үүнд:

- Хариулагчийн хувийн үнэлгээнд үндэслэн оноожуулах эсвэл
- Байгууллагын үнэлгээнд үндэслэн оноожуулах

Хариулагчийн хувийн үнэлгээнд үндэслэн оноожуулахдаа 1-5 хүртэл хэмжээс бүхий Лайкертын хэмжээс бүхий хариултыг шударга байдлын үнэлгээний 0-100 хүртэлх хэмжээст шилжүүлэх ба дараах загварыг баримтална. Хэрвээ тухайн хариулт эерэг утгатай бол 100, сөрөг утгатай бол 0 оноог өгнө.

Хүснэгт 1. 1-5 хүртэл хэмжээс бүхий хариултыг ШБҮ-ний 0-100 оноонд шилжүүлэх

Хариулт	5 оноо	Шилжүүлэх оноо
Ихээхэн түгээмэл	1	0 эсвэл 100
Түгээмэл	2	25 эсвэл 75
Дунд зэрэг	3	50
Бага зэрэг	4	75 эсвэл 25
Огт байхгүй	5	100 эсвэл 0

Үзүүлэлтийн дундаж оноог тооцохдоо тухайн байгууллагын судалгаанд оролцсон хүмүүсийн хариулсан онооны байдалд нь үндэслэн байгууллагын дундаж оноог тооцно. Дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$\text{Үзүүлэлтийн дундаж оноо} = \frac{\text{Тухайн үзүүлэлтийн нийт онооны нийлбэр}}{\text{Тухайн байгууллагын судалгаанд хамрагдсан хүний тоо}}$$

Байгууллагын үнэлгээнд үндэслэн оноожуулах: Хариулагчийн хувийн үнэлгээгээр тооцох боломжгүй, давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтийн үнэлгээг гаргахдаа бусад байгууллагатай харьцуулах замаар буюу байгууллагын ерөнхий үнэлгээгээр тооцно.

Давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтийг оноожуулах: Байгууллага бүрийн давтамж (үнийн дүн) бүхий үзүүлэлтийг оноожуулахдаа тухайн хариултын интервалыг нэг үнэлгээнд шилжүүлэх шаардлагатай ба дараах байдлаар шилжүүлнэ.

Хүснэгт 2. Гадаад шударга байдлын хувьд давтамж, үнийн дүнг оноожуулах

Хариулт	Давтамж	Шилжүүлэх оноо
Албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр өгөх (шууд болон шууд бус байдлаар бэлэг өгөх) хандив, бусад санхүүгийн тусалцаа өгөх байдлыг оноожуулах	1 удаа	1
	2 удаа	2
	3 удаа	3
	4 — 5 удаа	4.5
	6-7 удаа	6.5
	8-9 удаа	8.5
	10-аас дээш удаа	10
Албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр өгөх (шууд болон шууд бус байдлаар бэлэг өгөх) хандив, бусад санхүүгийн тусалцаа өгөх байдлыг үнийн дүнг оноожуулах	20000 ₮	20
	21000-50000₮	35.5
	51000-100000₮	77.5
	101000-300000₮	205
	301000-500000	405
	501000-1000000₮	755
	1.1 сая-2 сая ₮	1550
	2.1-5 сая ₮	3550
	5.1-10 сая ₮	7550
	10.1 сая ₮-өөс дээш	10100

Давтамж (үнийн дүн) бүхий үзүүлэлтийн дунджийг тооцох: Тухайн байгууллагын давтамж (үнийн дүн)-ийн онооны нийлбэрт үндэслэн тухайн байгууллагын судалгаанд хамрагдсан нэг хүнд ногдох давтамж (үнийн дүн)-ийн онооны дунджийг дараах томъёогоор тооцно.

$$\text{Тухайн байгууллагын нэг хүнд ногдох давтамж (үнийн дүн)} = \frac{\text{Тухайн байгууллагын давтамж (үнийн дүн) – ийн онооны нийлбэр}}{\text{Тухайн байгууллагын судалгаанд хамрагдсан хүний тоо}}$$

Давтамж (үнийн дүн) бүхий үзүүлэлтийг оноожуулах: Давтамж, үнийн дүнгийн дунджид үндэслэн бусад байгууллагатай жиших замаар байгууллагын давтамж, үнийн

дүн бүхий үзүүлэлтийг оноожуулах бөгөөд дараах томъёогоор тооцно.

$$\text{Давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтийн оноо} = 100 * \left(1 - \frac{\text{тухайн байгууллагын давтамж (үнийн дүн) - ийн дундаж}}{UCP}\right)$$

UCP нь бүх байгууллагын давтамж (үнийн дүн)-ийн дунджаас тооцсон өсөн нэмэгдэх гамма тархалтын 95%-тай тэнцүү утга буюу тухайн жилд хамгийн өндөр давтамж (үнийн дүн) бүхий байгууллагын дундаж

1.2 Судалгааны хамрах хүрээ

“Шударга байдлын үнэлгээ - 2024” судалгаанд 16 яам, 34 агентлаг, 21 аймгийн ЗДТГ, Нийслэл, дүүргийн ЗДТГ- 10 нийт 81 байгууллагын 10840 иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл, 2660 төрийн албан хаагчид, 1530 бодлогод оролцогч, шинжээчдээс судалгааны тоон мэдээллийг цуглууллаа. Түүврийн хэмжээг дараах схемээр харуулав.

Зураг 2. Түүврийн хамрах хүрээ, түүврийн хэмжээ




Үүнд: Яамдаар үйлчлүүлж байгаа иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл, албан хаагчид, бодлогод оролцогч, шинжээчид нийт 2900 иргэдээс, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагаар үйлчлүүлж байгаа иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл, албан хаагчид, бодлогод оролцогч, шинжээчид нийт 5460 иргэд, аймаг, нийслэлийн ЗДТГ-аар үйлчлүүлж байгаа иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл, албан хаагчид, бодлогод оролцогч, шинжээчид нийт 5100 иргэд, дүүргийн ЗДТГ-аар үйлчлүүлж байгаа иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл, албан хаагчид нийт 1570 иргэд, нийт **15030** иргэдийг судалгаанд хамрууллаа (Түүврийн дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу).

1.3 Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт

Судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг 2025 оны 05 сарын 20-оос 2025 оны 07 сарын 20-ны хооронд нийт 2 сарын хугацаанд амжилттай зохион байгууллаа. Мэдээлэл цуглуулалтын ажилд Улаанбаатар хот болон 21 аймгийн хэмжээнд нийт 6 багийн 30 хүн ажилласан.

Судалгааны багийн гишүүн нь судалгаа хэрхэн авах талаарх аргазүйн сургалтад хамрагдаж, мэдээлэл цуглуулах ажлыг талбар дээр нь гүйцэтгэн ажилласан болно. Мөн бид судалгааны тоон мэдээлэл цуглуулалтын үйл явцыг тухайн төрийн байгууллагаар одоо цаг үед үйлчлүүлж буй иргэд, ААН болон өмнө үйлчлүүлсэн иргэд, ААН, тухайн

байгууллагын бодлого боловсруулах үйл явцад оролцсон шинжээчидтэй холбогдон мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэлээ. Асуулгын хуудсыг онлайн хэлбэрт шилжүүлэн, тухайн байгууллагын вэбсайт болон тухайн байгууллагын ЭБАТ-аас өмнө үйлчлүүлсэн иргэд, ААН-ийн холбогдох утасны дугаар, мэйл хаяг зэрэг мэдээллийг авч холбогдох зэрэг аргуудыг ашиглалаа.



Зураг 3. Мэдээлэл цуглуулах багийн зохион байгуулалт

БҮЛЭГ II. ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ҮР ДҮН

2.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

“Шударга байдлын үнэлгээ - 2025” судалгаанд нийт 15030 иргэд хамрагдсан ба үүнээс үүнээс 10840 нь гадаад шударга байдлын үнэлгээнд, 2660 нь дотоод шударга байдлын үнэлгээнд, 1530 нь бодлогод оролцогчдын үнэлгээнд тус тус хамрагдлаа.

Гадаад шударга байдлын үнэлгээнд хамрагдсан иргэдийн ерөнхий мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа. Гадаад шударга байдлын үнэлгээний судалгаанд хамрагдсан оролцогчдын 89.6 хувь нь иргэд, хувь хүн байсан бол, 10.4 хувь нь аж ахуй нэгж байгууллагаа төлөөлөн төрийн байгууллагуудаар үйлчлүүлсэн иргэд байв.

Хүснэгт 3. Гадаад шударга байдлын үнэлгээний судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Ангилал	Үзүүлэлт	Оролцогчдын тоо	Эзлэх хувь
Төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ хэнийг төлөөлсөн бэ?	Хувь хүн	9712	89.6%
	Аж ахуйн нэгж, байгууллага	1128	10.4%
Судалгаанд оролцогчдын нас	20 хүртэл	340	3.1%
	20-29	1802	16.6%
	30-39	3360	31%
	40-49	3026	27.9%
	50-59	1559	14.4%
	60-аас дээш	753	6.9%
Судалгаанд оролцогчдын хүйс	Эрэгтэй	4998	46.1%
	Эмэгтэй	5842	53.9%
Нийт		10840	

Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр авч үзвэл, 3.1 хувийг 20 хүртэл насны иргэд, 16.6 хувийг 20-29 насны иргэд, 31 хувийг 30-39 насны иргэд, 27.9 хувь нь 40-49 насны иргэд, 14.4 хувь нь 50-59 насны иргэд, 6.9 хувь 60-аас дээш насны иргэд эзэлж байна. Харин судалгаанд оролцогчдын хүйсийн байдлыг авч үзвэл, 46.1 хувь нь эрэгтэй, 53.9 хувь нь эмэгтэй хүмүүс хамрагджээ.

Дотоод шударга байдлын үнэлгээнд хамрагдсан албан хаагчдын 24.8 хувь нь төрийн захиргааны төв байгууллага буюу яам, 39.8 хувь нь төрийн захиргааны байгууллага буюу агентлаг, 26.7 хувь нь аймаг нийслэлийн ЗДТГ, 8.6 хувь нь дүүргүүдийн ЗДТГ-ын төлөөлөл байв. Судалгаанд оролцсон албан хаагчдын дийлэнх буюу 45 хувийг 5 хүртэлх жил албан хаасан ажилтнууд бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Дотоод шударга байдлын үнэлгээний судалгаанд хамрагдсан оролцогчдын ерөнхий мэдээлэл

№	Байгууллагад ажилласан жил	Түүвэрт эзлэх хувь
1	20-с дээш жил	10%
2	10-20 жил	22%
3	5-10 жил	23%
4	5 хүртэл жил	45%

Бодлогод оролцогчдын үнэлгээнд хамрагдсан шинжээчдийн төлөөлж буй хүрээг авч үзвэл судалгаанд оролцогчдын 33.2 хувь нь төрийн албан хаагч, 24.4 хувь нь төрийн бус байгууллага, 15.7 хувь нь хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, 7.1 хувь нь эрдэмтэн, судлаач, 2.2 хувь нь бодлого боловсруулагч, 3.3 хувь нь хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, 4.2 хувь нь аудитор, хяналтын ажилтан, 9.9 хувь нь

бусад салбарыг тус тус төлөөлж байна.

Хүснэгт 5. Бодлогод оролцогчдын үнэлгээний судалгаанд хамрагдсан бодлогод оролцогч, шинжээчдийн мэдээлэл


№	Шинжээчийн төлөөлж буй хүрээ	Оролцогчдын тоо	Эзлэх хувь
1	Төрийн албан хаагч	508	33.2%
2	Төрийн бус байгууллага	374	24.4%
3	Хувийн хэвшил, холбоодын төлөөлөл	240	15.7%
4	Эрдэмтэн, судлаач	108	7.1%
5	Бодлого боловсруулагч	33	2.2%
6	Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч	50	3.3%
7	Аудитор, хяналтын ажилтан	65	4.2%
8	Бусад	152	9.9%
Нийт дүн		1530	100.0%

2.2 Шударга байдлын үнэлгээний ерөнхий үр дүн

“Шударга байдлын үнэлгээ – 2025” судалгаанд өмнөх онтой адил төрийн 16 яам, 34 агентлаг, 21 аймгийн ЗДТГ, нийслэлийн ЗДТГ хамрагдсан¹. Энэ онд дээрх төрийн байгууллагуудын дундаж ШБҮ нь 74.9 буюу өмнөх оноос 2.3 оноогоор өссөн байна. Энэхүү үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг нэгдүгээрт, түүний бүрэлдэхүүн үзүүлэлтээр, хоёрдугаарт төрийн байгууллагуудын үр дүнгээр тус тус задлан харъя.

2025 онд ГШБҮ нь 70.7, ДШБҮ нь 82.4, БОҮ нь 71.7 гэсэн оноогоор тус тус үнэлэгдсэн. Энэ нь өмнөх оноос харгалзан 1.6, 0.8 ба 4.5 оноогоор өссөн үзүүлэлт бөгөөд БОҮ-ний өөрчлөлт хамгийн их нөлөөлсөн нь харагдаж байна. Дараах зургаас харахад БОҮ-ээс бусад үнэлгээний үзүүлэлтүүд 2021-2023 онуудад өсөж, 2024 онд бууран, энэ онд дахин өссөн байна. Харин БОҮ-ний үр дүн сүүлийн 5 жилд өсөлт, бууралт ээлжилсэн байдалтай байна.

Зураг 4. ШБҮ, бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн оноо, сүүлийн 5 жилээр




Өмнөх онуудтай адил төрийн албан хаагчид байгууллагынхаа шударга байдлыг бусад хоёр субъектээс илүү өндрөөр үнэлсэн хэвээр байна. Иргэд ба бодлогод оролцогчдын үнэлгээ ойролцоо үр дүнг үзүүлжээ. Цаашлаад эдгээр бүрэлдэхүүн үзүүлэлтийг гаргагч 16 дэд

¹ Нийслэлийн 9 дүүргийн ШБҮ-г тусад нь дүгнэн, тайлагнасан болно.

үзүүлэлтийн үнэлгээ, өөрчлөлтөөс ШБҮ-д нөлөөлсөн гол хүчин зүйлсийг харъя.

Зураг 5. ГШБҮ, ДШБҮ, БОҮ-ний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт, 2024 онтой харьцуулсан үр дүн




Тайлбар: ГШБҮ ба ДШБҮ-ний дэд индексүүдийг ногоон дэвсгэрээр тодруулав. Эдгээр нь өөрсдийн хамаарах дэд үзүүлэлтүүдийн дунджаар тооцогддог. Энд, ҮШГБИ – Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс товчлол болно.

Дээрх дүрслэлээс харахад 16 дэд үзүүлэлтээс 3 нь үзүүлэлт л бууралттай байжээ. Хэдийгээр албан хаагчдын үнэлгээ бусад субъектүүдээс өндөр байдаг ч сөрөг өөрчлөлттэй үзүүлэлтүүд ДШБҮ-ний үед ажиглагдсан байна. Энэ онд бодлогод оролцогчид төрийн байгууллагын авлигын талаарх төсөөлөл (7.7↑), удирдлагын хүсэл эрмэлзэл (4.9↑), авлигын бодит тохиолдол (3.7↑) зэрэг дэд үзүүлэлтүүдийг өмнөх оноос илүү үнэлжээ. Харин ГШБҮ-ээс авлигын талаарх төсөөллийн дэд үзүүлэлт 3.3 оноогоор өссөн нь дараагийн их нөлөөтэй хүчин зүйл болжээ.

Дэд үзүүлэлтүүдийн 2025 оны үнэлгээг Зураг 6-т харууллаа. Хэдийгээр БОҮ-ний авлигын талаарх төсөөлөл хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн ч энэ оны үнэлгээ нь 76.6 байна. Хамгийн бага үнэлгээтэй байгаа дэд үзүүлэлтүүдэд авлигыг хянах механизм (БОҮ) 51.8, ил тод байдал (ГШБҮ) 59.7, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (БОҮ) 64.8, авлигын талаарх төсөөлөл (ГШБҮ) 65.6, хариуцлагатай байдал (ГШБҮ) 67.0, авлигын эсрэг тогтолцоо (ДШБҮ) 69.5 зэрэг багтаж байна. Өмнөх оны судалгаанд дээрх 6 үзүүлэлт мөн энэ дарааллаараа хамгийн бага үнэлгээг авсан байжээ. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагын холбоотой талууд нь ил тод ба хариуцлагатай байдлыг, авлигыг хянах механизм буюу авлигын эсрэг тогтолцоог, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг хангалтгүй гэж үзсэн хэвээр байна².

² Энд, БОҮ-ний авлигыг хянах механизм ба ДШБҮ-ний авлигын эсрэг тогтолцооны асуултууд агуулгын хувьд ойролцоо байдаг. Мөн ДШБҮ-ний удирдлагын хүсэл эрмэлзэл дэд үзүүлэлт нь жил бүрийн судалгаанд ДШБҮ-дээ бага дүнтэй үзүүлэлтийн нэг байсаар байгаа нь бодлогод оролцогчдын удирдлагын хүсэл эрмэлзэлд өгч буй үнэлгээний хандлагатай адил байгаа юм.

Зураг 6. ШБҮ-ний дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ, 2025 он



Хамгийн өндөр үнэлгээтэй үзүүлэлтүүдэд ДШБҮ-ний гадаад орчин дахь авлигатай тэмцэх хүсэл (99.1), хүний нөөцийн шударга байдал (96.4), төсвийн зарцуулалтын шударга байдал (92.2), мөн БОҮ-ний авлигын бодит тохиолдол (93.7) зэрэг багтаж байна. Мөн 80-аас дээш үнэлгээ авсан дэд үзүүлэлтүүдийн ихэнх нь авлигын шинжтэй үйлдэл гаргасан эсэхтэй холбоотой асуултуудтай уялдсан байна. Энэ төрлийн асуултын хувьд тохиолдол харьцангуй цөөн гардаг, илэрсэн ч төдийлөн олон нийтэд ил болж тогтоогддоггүй, түүнчлэн оролцогчид болгоомжилсны улмаас “үгүй” гэж хариулах нь түгээмэл байдаг зэрэг шалтгааны улмаас үнэлгээ харьцангуй өндөр гарах хандлагатай байна.

ШБҮ-ний гурван бүрэлдэхүүнд багтах 16 дэд үзүүлэлтийг нийт 63 асуултаар үнэлсэн бөгөөд эдгээрийн дэлгэрэнгүй үр дүн, өөрчлөлтийг Хавсралт 2-д үзүүлэв³.

Хамгийн бага үнэлгээтэй үзүүлэлт нь БОҮ-ний авлигыг хянах механизм байв. Тодруулбал, бодлогод оролцогчид “дотоод хяналтын механизмаар авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог” болон “авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалдаг” гэсэн асуултуудад дунджаар харгалзан 46.1 ба 47.2 оноо өгсөн байна. Харин төрийн үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөл “үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх ил тод байдал” болон “төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал”-ыг дунджаар харгалзан 60.6 ба 58.9 оноогоор үнэлжээ.

Хамгийн их өсөлттэй дэд үзүүлэлт нь бодлогод оролцогчдын авлигын талаарх төсөөлөл байв. Тус бүлгийн есөн асуултаас найм нь 7 болон түүнээс дээш онооны өсөлттэй гарсан бол “алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, эсхүл шан харамж шаардах” гэсэн асуулт 5.8 оноогоор нэмэгдсэн ч 55.0 оноогоор үнэлэгдэж, тухайн дэд үзүүлэлтийн хүрээнд хамгийн бага үнэлгээтэй хэвээр байна.


Хавсралт 3-д байгууллагын төрөл бүрээр нэгж асуултуудын дундаж үнэлгээг харуулсан. Ингэхэд тодорхой хэдэн асуултууд дээр бүх төрлийн төрийн байгууллагуудын бүлгийн дундаж үнэлгээ адилхан бага үр дүнтэй байна. Энэ нь эдгээр зүйлсийг судалгаанд

³ ГШБҮ – 20 нэгж асуулт, ДШБҮ – 27 нэгж асуулт, БОҮ – 16 нэгж асуултаар дундаж үнэлгээг тооцдог. Үүнд, шалтгаан, шийдлийг тодруулах нээлттэй асуултыг оруулаагүй болно.

оролцогчид хангалтгүй гэж нийтлэгээр дүгнэж байгааг илэрхийлнэ.

Төрийн байгууллагуудын дундаж ШБҮ-д байгууллагын төрлүүдийн үнэлгээ ямар нөлөөтэй байсныг дүгнэе. Энэ онд агентлагийн ШБҮ 3 оноогоор өсөж, хамгийн өндөр үнэлгээтэй буюу 77.3 гэж үнэлэгдсэн байна. Хамгийн өндөр өсөлтийг аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дундаж ШБҮ буюу 3.3 оноогоор нэмэгдэж 72.3 үнэлгээтэй байна. Харин яамдын ШБҮ 0.8 оноогоор буурсан үр дүн үзүүлжээ. Хэдийгээр аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ өссөн ч бусад төрлийн байгууллагаас бага үнэлгээтэй хэвээр байна.

Зураг 7. ШБҮ, байгууллагын төрлөөр, 2021 – 2025 он



Байгууллагын төрлүүдийн дундаж ШБҮ-ний өөрчлөлтөд ямар байгууллагууд голчлон нөлөөлснийг авч үзвэл яамдаас:

- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (14.0↑),
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (10.0↓),
- Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (8.4↓)
- Эрүүл мэндийн яам (8.0↓)
- Хууль зүй, дотоод хэргийн яам (7.6↓) гэсэн үнэлгээний өөрчлөлтүүд нөлөөлжээ.

Агентлагуудаас:

- Үндэсний геологийн алба (24.2↑)
- Боловсролын ерөнхий газар (15.3↑),
- Ашигт малтмал, газрын тосны газар (10.4↑)
- Онцгой байдлын ерөнхий газар (12.2↑)
- Цаг уур, орчны шинжилгээний газар (12.8↑)
- Төрийн худалдан авах ажиллагааны газар (12.1↑)
- Жижиг, дунд үйлдвэрийн газар (12.3↓)
- Мал эмнэлгийн ерөнхий газар (10.3↓)

Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудаас:

- Увс аймгийн ЗДТГ (12.4↑),
- Хөвсгөл аймгийн ЗДТГ (11.3↑),
- Говьсүмбэр аймгийн ЗДТГ (10.9↑),
- Сэлэнгэ аймгийн ЗДТГ (10.8↑) зэрэг байгууллагууд хамгийн их өөрчлөлтийг үзүүлсэн байна.

Хавсралт 4-д байгууллага бүрээр 2025 оны ШБҮ, ДШБҮ, ГШБҮ, БОҮ ба өмнөх онтой харьцуулсан өөрчлөлтийг харуулав.


Цаашлаад төрийн байгууллагын төрлүүд нь ШБҮ-ний бүрэлдэхүүн бүрээр ямар үр дүн үзүүлснийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 6. ШБҮ-ний бүрэлдэхүүн үзүүлэлтүүд, төрийн байгууллагуудын төрлөөр, 2025 он

	ГШБҮ	ДШБҮ	БОҮ	ШБҮ
Яам	68.6	82.3	69.5	73.5
Агентлаг	76.0	82.1	73.9	77.3
Аймаг, нийслэлийн ЗДТГ	63.9	83.0	70.1	72.3

Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ДШБҮ хамгийн өндөр дүнтэй байгаа бол ГШБҮ ба БОҮ-гээр агентлагууд илүү үнэлэгдсэн байна. Тэгвэл яамд нь БОҮ-ний хамгийн бага үр дүнг үзүүлж, аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд ГШБҮ-ний бага дүнг тус тус харуулсан байна. Тэгвэл 3 бүрэлдэхүүн үзүүлэлт нь байгууллын төрөл бүрээр өмнөх оноос хэрхэн өөрчлөгдсөнийг харъя.

Зураг 8. ШБҮ-ний бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн үнэлгээний өөрчлөлт, байгууллагын төрлөөр



Дээрхээс харахад дундаж ГШБҮ зөвхөн агентлагуудын хувьд 4.5 оноогоор нэмэгдсэн бол яамдын дундаж үнэлгээ 3.2-оор буурч, аймаг нийслэлийн ЗДТГ-ын хувьд бараг өөрчлөлтгүй байна. ДШБҮ-г харвал яам ба агентлагуудад төдийлөн өөрчлөлтгүй, аймаг, нийслэлийн ЗДТГ-уудад өсөлттэй. Харин БОҮ бүх төрлийн байгууллагын дундаж тооцооллоор өсөлттэй байна.

2025 онд ШБҮ-ний судалгаанд хамрагдсан 72 байгууллагыг эрэмбэлэн харвал 37 байгууллагын үнэлгээ нь ерөнхий дундаж үзүүлэлт 74.9-ээс дээгүүр байна. Нийт 40 байгууллагын үнэлгээ өсөж, 24 байгууллагынх буурсан бол 8 байгууллагын үнэлгээ төдийлөн өөрчлөлтгүй гарчээ. Хамгийн өндөр үнэлгээ авсан 10 байгууллагын 9 нь агентлаг, нэг нь яам байна. Тухайлбал, өмнөх жил эхний 10 эрэмбэд 4 яам, 5 агентлаг, 1 аймгийн ЗДТГ жагсаж байжээ.

Энэ онд Оюуны өмчийн газар болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар өмнөх онтой адил эхний эрэмбүүдэд хэвээр байна. Харин Боловсролын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Төрийн худалдан авах ажиллагааны газруудын үнэлгээ хоёр оронтой өсөлтийг үзүүлж, олон байраар урагшилсан үр дүнтэй байна. Хавсралт 3. ШБҮ-ний нэгж

асуултууд, байгууллагын төрлөөр, 2025 он

ГШБҮ	Ил тод байдал		Хариуцлагатай байдал		Авлигын талаарх төсөөлөл						Авлигын шууд				
	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A11.1	A11.2	A12	A12.1
Ерөнхий	60.6	58.9	66.6	67.5	69.0	61.8	62.8	65.7	65.6	68.7	93.1	73.0	82.9	94.7	69.6
Яам	58.1	58.5	64.5	64.4	65.3	59.8	60.7	63.3	63.8	65.8	92.1	69.6	76.0	93.9	65.9
Агентлаг	65.3	62.7	71.9	72.2	74.8	68.2	68.5	70.9	70.6	73.2	96.5	88.2	87.5	97.2	84.6
Аймаг, нийслэлийн	54.9	53.1	59.8	62.4	62.8	53.3	55.6	59.2	59.1	63.6	88.5	52.0	80.9	91.4	49.2
Дүүргийн ЗДТГ	62.5	59.6	70.0	68.8	70.7	65.6	66.1	69.9	69.7	70.8	95.7	85.1	85.2	97.4	81.5

ДШБҮ	Албан бус хэм хэмжээ						Авлигын эсрэг тогтолцоо			Хүний нөөц					T
	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A11.1	A11.2	A13	A14
Ерөнхий	76.1	76.9	77.4	78.2	87.8	93.3	68.2	74.1	66.1	91.8	99.3	95.6	96.7	98.8	86.0
Яам	75.9	75.4	77.1	77.3	87.7	92.8	68.9	73.8	67.6	91.4	98.8	85.9	97.5	98.9	84.3
Агентлаг	75.0	75.9	77.2	77.6	87.0	92.9	67.2	74.3	65.8	92.6	99.4	98.1	97.2	98.8	87.4
Аймаг, нийслэлийн	77.9	79.4	78.0	79.6	89.0	94.4	69.4	74.2	65.6	90.7	99.5	98.6	95.3	98.6	85.0
Дүүргийн ЗДТГ	75.0	75.1	73.0	76.5	86.8	93.9	69.7	74.6	66.1	94.5	99.3	97.5	100.0	97.8	83.8

ДШБҮ	Үүрэг даалгаврын шударга байдал				Гадаад орчин дахь авлигатай тэмцэх		Удирдлагын хүсэл эрмэлзэл		
	A17	A18	A19	A19.1	A20	A21	A22	A23	A24
Ерөнхий	72.1	83.3	95.0	92.5	99.6	98.6	73.0	72.4	72.9
Яам	70.2	82.3	95.0	93.6	99.8	98.6	73.3	73.0	71.6
Агентлаг	71.4	83.8	94.4	91.6	99.5	98.6	72.8	72.2	73.4
Аймаг, нийслэлийн	74.6	83.3	96.0	93.0	99.8	98.7	73.2	72.4	73.1
Дүүргийн ЗДТГ	72.5	80.8	95.9	90.5	98.9	99.3	72.5	71.0	72.9

БОҮ	Авлигын талаарх төсөөлөл									Авлигын хяналт			Авлигын бодит тохиолдол		Удирдлагын хүсэл эрмэлзэл
	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A12	A13	A14	A15
Ерөнхий	76.1	80.3	77.9	78.4	81.5	80.4	79.9	54.9	80	46.1	47.2	62.1	94.2	93.2	65
Яам	73.3	77.0	75.6	73.9	77.7	75.6	76.8	57.0	75.3	42.3	43.2	60.0	95.7	92.9	61.4
Агентлаг	79.5	83.3	82.5	82.3	84.8	83.4	82.9	55.9	82.6	48.9	51.2	65.4	94.9	94.2	66.2
Аймаг, нийслэлийн	73.0	78.1	72.5	75.5	79.1	79.2	77.4	51.9	79.3	44.6	44.1	58.5	92.2	91.8	65.6
Дүүргийн ЗДТГ	72.3	74.7	73.8	77.9	82.4	83.2	79.0	59.5	79.7	48.8	48.6	62.3	94.2	95.6	68.1

Тайлбар: багаас их рүү улаанаас ногооноор тодрууллаа.

Хавсралт 4-өөс төрийн байгууллагуудын бүрэлдэхүүн үзүүлэлтийн үнэлгээ ба өөрчлөлтийг харж болох бол Хавсралт 5-аас 16 дэд үзүүлэлтийн үр дүн, өөрчлөлттэй танилцан дүгнэх боломжтой.

Хүснэгт 7. ШБҮ-ээр хамгийн өндөр болон хамгийн бага оноотой байгууллагууд

№	Байгууллагын нэр	2024 оны эрэмбэ	2024 оны үнэлгээ	2025 оны үнэлгээ	Үнэлгээний өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй					
1	Оюуны өмчийн газар	1	85.9	92.2	6.3
2	Боловсролын ерөнхий газар	47	70.9	86.2	15.3
3	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	13	78.6	84.1	5.5
4	Онцгой байдлын ерөнхий газар	43	71.5	83.7	12.2
5	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	24	76.1	83.4	7.3
6	Батлан хамгаалах яам	22	76.8	82.8	6
7	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	5	81.7	82.4	0.7
8	Архивын ерөнхий газар	37	73.2	82	8.8
9	Монополын эсрэг газар	26	75.2	81.6	6.4
10	Төрийн худалдан авах ажиллагааны газар	52	69.5	81.6	12.1
Хамгийн бага үнэлгээтэй					
63	Дархан-Уул аймгийн ЗДТГ	55	68.9	67.7	-1.2

64	Баянхонгор аймгийн ЗДТГ	65	62.3	67.4	5.1
65	Архангай аймгийн ЗДТГ	45	71.2	66.4	-4.8
66	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	61	67.3	65.2	-2.1
67	Байгал орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	27	74.7	64.7	-10.0
68	Мал эмнэлгийн ерөнхий газар	31	74.1	63.8	-10.3
69	Эрүүл мэндийн яам	46	71.2	63.2	-8.0
70	Ховд аймгийн ЗДТГ	68	60.5	62.6	2.1
71	Дорнод аймгийн ЗДТГ	67	60.5	62.5	2.0
72	Боловсролын яам	64	64.0	60.2	-3.8

Энэ оны судалгаанд шударга байдлын үнэлгээний сүүлийн 10 эрэмбэд 6 аймгийн ЗДТГ, 3 яам, нэг агентлаг орсон байна. Эдгээрээс Байгал орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газар, Архангай аймгийн ЗДТГ ба Эрүүл мэндийн яам нэлээд олон байр ухарсан байгаа бол Баян-Өлгий, Баянхонгор, Ховд, Дорнод аймгийн ЗДТГ-ууд ба Боловсролын яам нь өмнөх онд ч сүүлийн байруудад хамаарч байсан байна. Энэхүү доод эрэмбийн байгууллагуудын үнэлгээний дэлгэрэнгүйг 2.3 дэд бүлгээс харна уу.

Өмнөх оны үр дүнтэй харьцуулахад хамгийн их эерэг ба сөрөг өөрчлөлттэй 20 байгууллагын мэдээллийг дараах зурагт харууллаа.

Зураг 9. ШБҮ хамгийн их өөрчлөлттэй байгууллагууд, өөрчлөлт, оноогоор



ШБҮ нь хамгийн ихээр өссөн Үндэсний геологийн алба нь өмнөх онд 56.7 оноотойгоор хамгийн бага үнэлгээг авч байсан бол энэ онд ДШБҮ нь 12.4, ГШБҮ 28.7, БОҮ 31.6 оноогоор тус тус өсөж энэ онд эрэмбийн 12-т орсон байна. Хамгийн их өсөлттэй байгууллагуудаас Боловсролын ерөнхий газар, Төрийн худалдан авах ажиллагааны газрууд эхний 10 эрэмбийн байгууллагад багтаж байгааг өмнөх


Хүснэгт 7-т онцолсон билээ.

Жижиг, дунд үйлдвэрийн газар өмнөх онд эрэмбийн 3 дугаарт байсан бол энэ онд ДШБҮ 8.5 оноогоор, ГШБҮ нь 12.5 оноогоор, БОҮ 15.7 оноогоор тус тус буурч 50-р эрэмбэд жагсаж байна. Мал эмнэлгийн ерөнхий газар, Байгал орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам, Эрүүл мэндийн яам зэрэг байгууллагууд 8-10 оноогоор үнэлгээ буурч өмнө дурдсанчлан эрэмбийн сүүлийн жагсаалтад багтсан байна.

2.2.1 Яамдын ШБҮ-ний үр дүн

2025 оны ШБҮ-нд өмнөх онтой адил 16 яам хамрагдсан ба ШБҮ нь 73.5 буюу өмнөх оноос 0.8 оноогоор буурсан. Өмнөх гурван удаагийн судалгаанд яамдын ШБҮ нь нийт төрийн байгууллагын дунджаас өндөр байсан бол энэ оны дундаж үнэлгээнээс 1.4 оноогоор бага байна.

Зураг 10. Яамдын ШБҮ, 2015 – 2025 он



Өмнөх Зураг 8-д харуулсанчлан яамдын ГШБҮ 3.2, ДШБҮ 0.2 оноогоор тус тус буурч, БОҮ нь 0.9 оноогоор өссөн нь энэ оны үр дүнд нөлөөлжээ. Эдгээрийг цаашид дэд үзүүлэлт бүрээр задлан тодруулъя. Хавсралт 3-д төрийн байгууллагуудын төрлөөр нэгж асуулт бүрийн дундаж үнэлгээг задлан харуулсан.

ГШБҮ-ний хувьд хамгийн их бууралттай нь авлигын шууд тохиолдол (7.2↓) ба ил тод байдал (4.0↓) зэрэг үзүүлэлтүүд байгаа бол хамгийн бага үнэлгээтэй нь ил тод байдал (58.3), авлигын талаарх төсөөлөл (63.1), хариуцлагатай байдлын (64.5) үзүүлэлтүүд байна. Эдгээр 3 үзүүлэлт өмнөх онд ч мөн адил хамгийн бага үнэлгээтэй байна.

Хүснэгт 8. Яамдын ГШБҮ-ний дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ, өөрчлөлт

	Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын эрсдэлийн индекс	Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс	ГШБҮ
2024	62.3	65.8	64.0	64.5	86.8	87.5	79.6	71.8
2025	58.3	64.5	61.4	63.1	79.6	84.8	75.8	68.6
Өөрчлөлт	-4.0	-1.3	-2.6	-1.4	-7.2	-2.7	-3.8	-3.2

Яамдын ГШБҮ-г үнэлэхэд ашиглаж буй 20 нэгж асуултын үнэлгээ ба өөрчлөлтийг “Судалгааны тайлан 1: Төрийн байгууллагын шударга байдлын талаар үйлчлүүлэгчдээс авах судалгааны тайлан”-аас дэлгэрэнгүй харна уу. Энэ хэсэгт дүгнэхэд яамдын ГШБҮ-ний А1-А10 асуултуудын дундаж нь бүгд 70-аас доош буюу 58-66-ийн хооронд үнэлгээтэй байна. Өөрөөр хэлбэл, ил тод байдал, хариуцлагатай байдал ба яамдын авлигын талаар төсөөлөлд иргэд, ААНБ-ын төлөөлөл хангалтгүй үнэлгээ өгсөн байна (Хавсралт 3-аас харна уу)

Яамдын ДШБҮ нь өөрчлөлт бага, хамгийн их бууралттай үзүүлэлт нь хүний нөөцийн шударга байдал (2.7↓) байгаа бол авлигын эсрэг тогтолцоо (70.1) ба удирдлагын хүсэл эрмэлзэл (72.6) гэсэн үзүүлэлтүүд хамгийн бага үнэлгээтэй. Энэхүү үр дүн өмнөх жилтэй ижил байна.

Хүснэгт 9. Яамдын ДШБҮ-ний дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ, өөрчлөлт

	Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Соёлын индекс	Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	ДШБҮ
2024	81.0	70.2	75.6	97.2	94.0	86.7	99.3	71.2	89.7	82.6
2025	81.0	70.1	75.6	94.5	93.2	85.2	99.2	72.6	89.0	82.3
Өөрчлөлт	0.0	-0.1	0.0	-2.7	-0.8	-1.4	-0.2	1.5	-0.7	-0.4

ДШБҮ-г тооцоход 27 нэгж асуултыг ашигладаг ба эдгээрээс “А9. Танай байгууллагад авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрэлдсэн гэдэгтэй та санал нийлэх үү?” асуултад 67.6 оноо, “А7. Танай байгууллага авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан гэдэгтэй та санал нийлэх үү?” асуултад 68.9 оноог яамдын алба хаагчид өгсөн байгаа нь ДШБҮ-ний хамгийн бага үнэлгээ бүхий асуултууд байна (Хавсралт 3-д яамдын дунджаар). Яам тус бүрээр ДШБҮ-ний нэгж асуултуудын үнэлгээ ба өөрчлөлтийг “Судалгааны тайлан 2: Төрийн байгууллагын шударга байдлын талаар алба хаагчдаас авах судалгааны тайлан”-аас дэлгэрэнгүй харна уу.

БОҮ-ний дэд үзүүлэлтээс авлигын талаарх төсөөлөл 3.9 оноогоор өссөн нь хамгийн их өөрчлөлт байгаа бол бусад үзүүлэлтүүд өөрчлөлт бага байна. Онцлох зүйл нь авлигыг хянах механизм дэд үзүүлэлт хамгийн бага буюу 48.5 үнэлгээтэй байгаа нь яамдын нийт ШБҮ-ний үзүүлэлтүүдээс хамгийн бага нь байна.


Хүснэгт 10. Яамдын БОҮ-ний дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ, өөрчлөлт

	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	БОҮ
2024	69.7	48.9	92.4	62.5	68.4
2025	73.6	48.5	94.3	61.7	69.5
Өөрчлөлт	3.9	-0.4	1.9	-0.8	1.1

БОҮ-ний 16 нэгж асуултаас “А.10 дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог гэдэгтэй санал нийлэх үү” асуултад 42.3 оноо, “А11. Авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэгчийг бүрэн хамгаалсан гэдэгтэй санал нийлэх үү” асуултад 43.1 оноог тус тус өгсөн нь бага үнэлгээтэй асуултууд байна (Хавсралт 3). Яам бүрийн БОҮ-ний нэгж асуултууд, түүний өөрчлөлтийг “Судалгааны тайлан 3: Төрийн байгууллагын шударга байдлын талаар бодлогод оролцогч, шинжээчдийн судалгааны тайлан”-аас дэлгэрэнгүй харна уу.

ШБҮ-ний үр дүнг яамдаар жагсааж харвал өмнөх онтой харьцуулахад 8 яамны үнэлгээ буурч, 5 яамны үнэлгээ өссөн ба 3 яамны үнэлгээ төдийлөн өөрчлөлтгүй байна (Хавсралт 4). Энэ оны судалгаанд Батлан хамгаалах яам (6.0↑) тэргүүлсэн бол өмнөх оны тэргүүлэгч Хууль зүй, дотоод хэргийн яамны ШБҮ 7.6 оноогоор буурч яамдын 8 дугаар эрэмбэд байна. Хамгийн бага үнэлгээг Боловсролын яам (3.8↓) үзүүлсэн бол Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам 14 онооны өсөлтөөр өмнөх оны сүүлийн эрэмбээс энэ онд 10 дахь эрэмбэд байна.

Зураг 11. Яамдын ШБҮ, 2024 ба 2025 оныг харьцуулсан байдал, 2025 оны эрэмбээр



Өмнөх онтой харьцуулахад хамгийн их өөрчлөлттэй яамдад:

- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (14.0↑),
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (10.0↓),
- Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (8.4↓)
- Эрүүл мэндийн яам (8.0↓)
- Хууль зүй, дотоод хэргийн яам (7.6↓)
- Сангийн яам (7.4↑) зэрэг байгууллага хамаарч байна.

Хамгийн их өсөлттэй Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хувьд өмнөх онд хамгийн бага оноо авч байжээ. Энэ оны өсөлтийг бий болгоход БОУ ба ГШБҮ нь харгалзан 25.6 ба 15.7 оноогоор тус тус өссөн нь нөлөөлжээ. Үүнд, нэгдүгээрт бодлогод оролцогч, шинжээчид нь авлигын бодит тохиолдол (48.5↑), авлигын талаарх төсөөлөл (27.7↑), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (18.8↑), авлигыг хянах механизм (7.1↑) дэд үзүүлэлтүүдийг өмнөх оноос илүү өндрөөр үнэлжээ. Хоёрдугаарт, тус ямаар үйлчлүүлэгч иргэд, ААНБ-ын төлөөлөл нь тухайн байгууллагын ил тод байдал (16.3↑), хариуцлагатай байдал (23.5↑), авлигын талаарх төсөөлөл (18.4↑), авлигын шууд тохиолдол (9.3↑), авлигын шууд бус

тохиолдол (7.0↑) тус тус өсөж үнэлэгдсэн нь нөлөөлсөн байна (Хавсралт 5). Хэдийгээр ийнхүү өндөр өсөлттэй боловч БОУ-ний дундаж нь 71.0, ГШБҮ-ний дундаж нь 67.9 буюу хангалттай түвшинд хүрээгүй хэвээр байна.


Харин хамгийн их бууралттай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны БОУ нь 24.2 оноогоор буурч 46.3 гэсэн үнэлгээтэй байгаа нь анхаарал татахаар байна. Үүнд, авлигын талаарх төсөөлөл 46.8 (27.6↓), авлигыг хянах механизм 36.8 (16.6↓), авлигын бодит тохиолдол 65.4 (22.6↓), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 36.0 (30.2↓) гэсэн маш бага оноог авсан нь нөлөөлжээ. Бодлогод оролцогчид үзэхдээ тухайн яаманд авлига түгээмэл (39.0), дотоод хяналтын механизм авлигыг илрүүлж, хариуцлага тооцох явдал (34.0), мэдээлэгчийг хамгаалсан байдал (38.0), урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг (39.0) тус тус хангалтгүй гэж дүгнэжээ.

Яам тус бүрийн ГШБҮ, ДШБҮ ба БОУ-ний нэгж асуултуудын үнэлгээ ба өөрчлөлт, дүгнэлтийг харгалзах тайлангуудаас дэлгэрэнгүй харна уу. Хамгийн бага үнэлгээтэй хоёр яамны дэлгэрэнгүйг 2.3 дэд хэсэгт танилцууллаа.

2.2.2 Агентлагуудын ШБҮ-ний үр дүн

Энэ удаагийн ШБҮ-ний судалгаанд өмнөх оны адил 34 агентлаг хамрагдсан ба дундаж үнэлгээ 77.3 буюу 3 онооны өсөлттэй байна. ШБҮ-ний бүх оны судалгаанд агентлагийн дундаж ШБҮ хамгийн өндөр үнэлгээтэй байсаар ирсэн⁴. Өмнөх Зураг 8-д харснаар агентлагуудын дундаж ГШБҮ, ДШБҮ ба БОУ нь харгалзан 4.5, 0.5 ба 4.0 оноогоор тус тус өмнөх оноос өсөлттэй байна.

Зураг 12. Агентлагуудын ШБҮ, 2015 – 2025 он



Агентлагуудын дундаж үнэлгээний үр дүнг бүрэлдэхүүн үнэлгээгээр задлан харъя. ГШБҮ-ний бүх дэд үзүүлэлтүүдийн дундаж үнэлгээ өмнөх оноос өссөн ба хариуцлагатай байдал (6.3↑), авлигын талаарх төсөөлөл (6.1↑) өндөр өсөлттэй үзүүлэлтүүд байна. Хэдийгээр өмнөх оноос өсөлттэй байгаа нь эерэг үр дүн ч цаашид үнэлгээг нэмэгдүүлэх шаардлагатай үзүүлэлтүүд байсаар байна.

⁴ 2023 ба 2024 оны судалгаанд яамдын ба агентлагуудын дундаж ШБҮ тэнцүү байсан байна.

Хүснэгт 11. Агентлагуудын ГШБҮ-ний дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ, өөрчлөлт

	Ил тод байдал	Хариуцлага тай байдал	Авлигын эрсдэлийн индекс	Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс	ГШБҮ
2024	59.4	65.8	62.6	64.9	88.8	87.8	80.5	71.5
2025	64.0	72.1	68.1	71.0	90.9	90.0	84.0	76.0
Өөрчлөлт	4.6	6.3	5.5	6.1	2.1	2.2	3.5	4.5

Хавсралт 3-аас харахад нийт төрийн байгууллагуудтай адил хүний нөөц, үйл ажиллагааны ил тод байдал (А1), төсөв-санхүү, худалдан авалтын ил тод байдал (А2), ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг (А6), бусдад хууль бусаар давуу байдал олгогдог (А7) зэрэг үзүүлэлтүүд агентлагуудын хувьд хамгийн бага үнэлгээтэй байна. ГШБҮ-ний 20 нэгж асуултын үнэлгээ, өөрчлөлтийг агентлаг бүрээр “Судалгааны тайлан 1: Төрийн байгууллагын шударга байдлын талаар үйлчлүүлэгчдээс авах судалгааны тайлан”-аас дэлгэрэнгүй харна уу.

ДШБҮ агентлагуудын хувьд мөн өөрчлөлтгүй буюу 0.5 онооны өсөлттэй байна. Хангалтгүй үнэлгээтэй үзүүлэлтүүд нь авлигын эсрэг тогтолцоо (69.1) ба удирдлагын хүсэл эрмэлзэл (72.8) зэрэг байна. Энэхүү үр дүн өмнөх жилийн агентлагуудын дундаж үр дүнтэй болон энэ оны яамдын дундаж үнэлгээний үр дүнтэй адил байна.

Хүснэгт 12. Агентлагуудын ДШБҮ-ний дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ, өөрчлөлт

	Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Соёлын индекс	Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүрэг шударгаар гүйцэтгэх байдлын индекс	ДШБҮ
2024	80.9	67.6	74.3	95.7	92.3	86.8	98.5	71.1	88.9	81.6
2025	80.9	69.1	75.0	97.2	91.2	85.3	99.0	72.8	89.1	82.1
Өөрчлөлт	0.0	1.4	0.7	1.6	-1.1	-1.5	0.6	1.6	0.2	0.5

ДШБҮ-ний нэгж асуултуудаас “А9. Танай байгууллагад авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрэлдсэн гэдэгтэй та санал нийлэх үү?” асуултад 65.8 оноо, “А7. Танай байгууллага авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан гэдэгтэй та санал нийлэх үү?” асуултад 67.2 оноог агентлагуудын алба хаагчид өгсөн байгаа нь ДШБҮ-ний хамгийн бага үнэлгээ бүхий асуултууд байна (Хавсралт 3). Агентлаг бүрээр ДШБҮ-ний нэгж асуултуудын үнэлгээ ба өөрчлөлтийг “Судалгааны тайлан 2: Төрийн байгууллагын шударга байдлын талаар алба хаагчдаас авах судалгааны тайлан”-аас дэлгэрэнгүй харна уу.

БОҮ-ний бүх дэд үзүүлэлт өсөлттэй, үүнээс авлигын талаарх төсөөлөл 7.7 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 4.6 оноогоор тус тус өссөн нь энэ бүлэг үнэлгээнд хамгийн өндөр өөрчлөлт байна. Өмнөх яамдтай адил авлигыг хянах механизм дэд үзүүлэлт нь ШБҮ-ний 16 дэд үзүүлэлтүүд дундаа хамгийн бага үнэлгээтэй байна.

Хүснэгт 13. Агентлагуудын БОУ-ний дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ, өөрчлөлт

	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	БОУ
2024	72.0	52.6	93.3	61.4	69.8
2025	79.7	55.2	94.6	66.0	73.8
Өөрчлөлт	7.7	2.5	1.2	4.6	4.0

Хавсралт 3-аас харахад БОУ-ний 16 нэгж асуултаас “А.10 дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог гэдэгтэй санал нийлэх үү” асуултад 48.9 оноо, “А11. Авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэгчийг бүрэн хамгаалсан гэдэгтэй санал нийлэх үү” асуултад 51.2 оноо, “А8. Төрийн үйлчилгээг үзүүлэхдээ бусдаас шан харамж авсан эсхүл өгсөн гэдэгтэй санал нийлэх үү” асуултад 55.9 оноог тус тус өгсөн нь бага үнэлгээтэй асуултууд байна. Агентлаг бүрийн БОУ-ний нэгж асуултууд, түүний өөрчлөлтийг “Судалгааны тайлан 3: Төрийн байгууллагын шударга байдлын талаар бодлогод оролцогч, шинжээчдийн судалгааны тайлан”-аас дэлгэрэнгүй харна уу.

Агентлагуудын ШБҮ-ний үр дүнг жагсааж харвал өмнөх онтой харьцуулахад 22 агентлагийн үнэлгээ өсөж, 8 агентлагийн үнэлгээ буурсан ба 4 байгууллагын үнэлгээ өөрчлөлтгүй байна. Оюуны өмчийн газар нийт төрийн байгууллагуудын эхний эрэмбэд жагссан ба өмнөх онд мөн ийнхүү үр дүнг үзүүлсэн байна. Агентлагуудын жагсаалтын эхний 9 эрэмбийн байгууллага нь нийт төрийн байгууллагуудын ШБҮ-ний жагсаалтад мөн тэргүүлсэн байгааг өмнөх

Хүснэгт 7-т онцолсон байгаа. Түүнчлэн Боловсролын ерөнхий газар (15.3↑), Онцгой байдлын ерөнхий газар (12.2↑), Төрийн худалдан авах ажиллагааны газар (12.1↑) зэрэг байгууллагууд энэ оны судалгаанд хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн байгаа.

Агентлагуудаас хамгийн бага үнэлгээг Мал эмнэлгийн ерөнхий газар (10.3↓) үзүүлсэн бол Үндэсний геологийн алба 24.2 онооны өсөлтөөр өмнөх оны сүүлийн эрэмбээс энэ онд 11 дэх эрэмбэд байна.

Өмнөх онтой харьцуулахад хамгийн их өөрчлөлттэй агентлагууд нь:


- Үндэсний геологийн алба (24.2↑)
- Боловсролын ерөнхий газар (15.3↑),
- Ашигт малтмал, газрын тосны газар (10.4↑)
- Онцгой байдлын ерөнхий газар (12.2↑)
- Цаг уур, орчны шинжилгээний газар (12.8↑)
- Төрийн худалдан авах ажиллагааны газар (12.1↑)
- Жижиг, дунд үйлдвэрийн газар (12.3↓)
- Мал эмнэлгийн ерөнхий газар (10.3↓) зэрэг байгууллага хамаарч байна.

Хамгийн их өсөлттэй Үндэсний геологийн албаны хувьд өмнөх онд хамгийн бага оноог авч байжээ. Энэ нь өмнөх хэсэгт яамдын ШБҮ-ний үр дүнтэй адил байна. Өөрөөр хэлбэл, өмнөх онд тухайн байгууллагын бүлэгтээ хамгийн бага оноо авсан байгууллагууд энэ онд хамгийн өндөр өсөлтийг бүлэгтээ үзүүлсэн байна.

Үндэсний геологийн албаны хувьд өсөлт бий болоход ГШБҮ, ДШБҮ ба БОУ нь харгалзан 28.7, 12.4 ба 31.7 оноогоор тус тус өссөн нь нөлөөлжээ. Үүнд, нэгдүгээрт, тус албаар үйлчлүүлэгч иргэд, ААНБ-ын төлөөлөл нь тухайн байгууллагын ил тод байдал (26.6↑), хариуцлагатай байдал (22.3↑), авлигын талаарх төсөөлөл (22.7↑), авлигын шууд тохиолдол (38.5↑), авлигын шууд бус тохиолдол (38.0↑) зэрэг үзүүлэлтүүдийг илүү

үнэлсэн нь нөлөөлсөн байна. Хэдийгээр өндөр өсөлтүүд үзүүлсэн байгаа ч ил тод байдал 67.2, авлигын талаарх төсөөлөл 66.3, хариуцлагатай байдал 70.4 буюу сайжруулах шаардлагатай түвшинд хэвээр байна. Хоёрдугаарт, бодлогод оролцогч, шинжээчид нь авлигын бодит тохиолдол (42.0↑), авлигын талаарх төсөөлөл (42.1↑), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (27.6↑), авлигыг хянах механизм (14.6↑) дэд үзүүлэлтүүдийг өмнөх оноос илүү өндрөөр үнэлжээ. Авлигыг хянах механизм 62.5 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 73.6 оноогоор үнэлэгдсэн байгааг харин анхаарах хэрэгтэй.

Зураг 13. Агентлагуудын ШБҮ, 2024 ба 2025 оныг харьцуулсан байдал, 2025 оны эрэмбээр



Агентлагуудаас Жижиг, дунд үйлдвэрийн газар хамгийн их бууралтыг үзүүлсэн байна. Энэхүү өөрчлөлтийг задалбал ГШБҮ ба БОУ харгалзан 12.6 ба 15.7 оноогоор, ДШБҮ 8.5 оноогоор тус тус буурсан байна. Төрийн үйлчилгээ авсан иргэд, ААНБ-ын төлөөлөл нь тус байгууллагын авлигын талаарх төсөөлөл (22.5↓), авлигын шууд бус тохиолдол (28.9↓), хариуцлагатай байдал (15.8↓) гэсэн үзүүлэлтийг өмнөх оноос багаар үнэлжээ. Жижиг,

Агентлаг тус бүрээр ГШБҮ, ДШБҮ ба БОҮ-ний нэгж асуултуудын үнэлгээ ба өөрчлөлт, дүгнэлтийг харгалзах тайлангуудаас дэлгэрэнгүй харна уу. Хамгийн бага үнэлгээтэй хоёр агентлагийн дэлгэрэнгүйг 2.3 дэд хэсэгт танилцууллаа.

Аймаг, нийслэлийн нийт 22 ЗДТГ-ын ШБҮ нь 72.3 оноогоор үнэлэгдэж, өмнөх оноос 3.3 оноогоор өсжээ. 2015 оноос бусад ШБҮ-ний бүх оны судалгаанд эдгээр байгууллагын дундаж ШБҮ хамгийн бага үнэлгээтэй байсаар байна. Энэ онд аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын дундаж ГШБҮ өөрчлөлтгүй буюу 0.3 онооны бууралттай бол ДШБҮ ба БОҮ нь харгалзан 2.2 ба 7.9 оноогоор тус тус өмнөх оноос өсөлттэй байна (Зураг 8).

Year	Аймаг, нийслэлийн ЗДТГ (%)	Ерөнхий (%)
2015	72.9	73.8
2016	69	69.7
2018	66.1	68.7
2019	73.2	74.1
2021	71.4	72.9
2022	71.1	73.9
2023	72.7	76.6
2024	69	72.6
2025	72.3	74.9

Тус бүлгийн ГШБҮ-ний дэд үзүүлэлтүүдийн дундаж үнэлгээ өөрчлөлт бага буюу авлигын шууд тохиолдлын бууралт (2.3↓) ба авлигын талаарх төсөөллийн өсөлт (1.6↑) нь хамгийн их өөрчлөлттэй үзүүлэлт болж байна. Өмнөх хоёр төрлийн байгууллагаас ялгаатай нь доорх 5 дэд үзүүлэлт нийтлэгээр бага дүнтэй буюу 80-аас дээш үнэлгээ авсан үзүүлэлт байхгүй байна.

	Ил тод байдал	Хариуцлаг атай байдал	Авлигын эрсдэлийн индекс	Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс	ГШБҮ
2024	54.2	60.3	57.3	57.4	78.6	77.0	71.0	64.1
2025	54.0	61.1	57.6	58.9	76.3	75.2	70.1	63.9
Өөрчлөлт	-0.1	0.8	0.3	1.6	-2.3	-1.8	-0.8	-0.3

25

ил тод байдал (A1), төсөв-санхүү, худалдан авалтын ил тод байдал (A2), ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг (A6), бусдад хууль бусаар давуу байдал олгогдог (A7) зэрэг асуултуудад мөн адил бага үнэлгээтэй буюу 53.1-55.6 гэсэн оноотой байна. Харин бусад байгууллагаас ялгаатай нь “A11.1 үйлчилгээ авч байхдаа нэмэлт төлбөр өгсөн давтамж” болон “A12.1 шууд ба шууд бус байдлаар бэлэг өгсөн давтамж” зэрэг асуултуудад харгалзан 52 ба 49.2 онооны үнэлгээтэй байгаа явдал. Өөрөөр хэлбэл, үйлчлүүлэгчид нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн туслалцааг албан хаагчдад өгдөг давтамж аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд дээр онцгойлон өндөр байна. ЗДТГ бүрээр ГШБҮ-ний 20 нэгж асуултын үнэлгээ, өөрчлөлтийг “Судалгааны тайлан 1: Төрийн байгууллагын шударга байдлын талаар үйлчлүүлэгчдээс авах судалгааны тайлан”-аас дэлгэрэнгүй харна уу.

ДШБҮ-ний өөрчлөлтөд соёлын индексийн өсөлт нөлөөлсөн бол үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс өөрчлөлтгүй гарсан байна. Хамгийн их өөрчлөлттэй үзүүлэлт нь албан бус хэм хэмжээ буюу 7 оноогоор өсөж, 83.1 оноонд хүржээ. Хангалтгүй үнэлгээтэй үзүүлэлтүүд нь мөн л авлигын эсрэг тогтолцоо (69.7) ба удирдлагын хүсэл эрмэлзэл (72.9) зэрэг байна. Энэхүү үр дүн байгууллагын төрөл ба судалгааны жилүүдэд адилхан хандлагатай байна.

Хүснэгт 15. Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын ДШБҮ-ний дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ, өөрчлөлт

	Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Соёлын индекс	Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	ДШБҮ
2024	76.0	67.9	71.9	97.0	95.4	86.5	96.1	73.6	89.7	80.8
2025	83.1	69.7	76.4	96.6	93.0	86.7	99.2	72.9	89.7	83.0
Өөрчлөлт	7.0	1.8	4.4	-0.5	-2.4	0.2	3.1	-0.6	0.0	2.2

ДШБҮ-ний нэгж асуултуудаас хамгийн бага үнэлгээтэй нь “A9. Танай байгууллагад авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрэлдсэн гэдэгтэй та санал нийлэх үү?” асуулт 65.6 оноо, “A7. Танай байгууллага авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан гэдэгтэй та санал нийлэх үү?” асуулт 69.4 оноотой байна. Хавсралт 3-аас харахад аймаг, нийслэлийн ЗДТГ-ын асуултуудын дундаж үнэлгээний шинж чанар нь бусад төрийн байгууллагуудтай адил буюу судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудад үнэлгээ бага эсвэл өндөр үзүүлэлт нийтлэг адил байна. ЗДТГ бүрээр ДШБҮ-ний нэгж асуултуудын үнэлгээ ба өөрчлөлтийг “Судалгааны тайлан 2: Төрийн байгууллагын шударга байдлын талаар албан хаагчдаас авах судалгааны тайлан”-аас дэлгэрэнгүй харна уу.

БОҮ-ний дэд үзүүлэлтүүд бусад төрлийн төрийн байгууллагуудтай харьцуулахад өсөлт харьцангуй өндөр байна. Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 9.4 оноогоор өссөн ч 65.3 үнэлгээтэй, авлигыг хянах механизм дөнгөж 49 гэсэн үнэлгээтэй тус тус байна.


Хүснэгт 16. Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын БОҮ-ний дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ, өөрчлөлт

	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	БОҮ
2024	64.1	44.8	83.9	55.9	62.2
2025	74.0	49.0	92.0	65.3	70.1
Өөрчлөлт	9.9	4.2	8.1	9.4	7.9

Хавсралт 3-аас харахад БОУ-ний 16 нэгж асуултаас “А.10 дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог гэдэгтэй санал нийлэх үү” асуултад 44.6 оноо, “А11. Авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэгчийг бүрэн хамгаалсан гэдэгтэй санал нийлэх үү” асуултад 44.1 оноо, “А8. Төрийн үйлчилгээг үзүүлэхдээ бусдаас шан харамж авсан эсхүл өгсөн гэдэгтэй санал нийлэх үү” асуултад 51.9 оноог тус тус өгсөн нь бага үнэлгээтэй асуултууд байна. ЗДТГ тус бүрээр БОУ-ний нэгж асуултууд, түүний өөрчлөлтийг “Судалгааны тайлан 3: Төрийн байгууллагын шударга байдлын талаар бодлогод оролцогч, шинжээчдийн судалгааны тайлан”-аас дэлгэрэнгүй харна уу.

Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ШБҮ-ний үр дүнг жагсааж харвал өмнөх онтой харьцуулахад 14 байгууллагын үнэлгээ өсөж, 7 байгууллагын үнэлгээ буурсан ба 1 байгууллагын үнэлгээ өөрчлөлтгүй байна. Төв аймгийн ЗДТГ өмнөх онтой адилаар энэ онд мөн эрэмбийн эхний байранд жагссан бол Говьсүмбэр аймаг 10.9 онооны өсөлттэй удаалжээ. Энэхүү өсөлтөөрөө тус аймгийн ЗДТГ нь хамгийн өндөр өсөлттэй 10 байгууллагад багтсан байна (Зураг 9). Дорнод аймгийн ШБҮ 2 оноогоор буурснаар энэ оны хамгийн бага үнэлгээ бүхий ЗДТГ болсон байна. Өмнөх оны хамгийн сүүлийн эрэмбийн Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын ШБҮ 9.1 оноогоор өсөж, 7 байр урагшилжээ.

Зураг 15. Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын ШБҮ, 2024 ба 2025 оныг харьцуулсан байдал, 2025 оны эрэмбээр



Өмнөх онтой харьцуулахад хамгийн их өөрчлөлттэй аймгийн ЗДТГ-ууд нь:

- Увс аймгийн ЗДТГ (12.4↑),
- Хөвсгөл аймгийн ЗДТГ (11.3↑),
- Говьсүмбэр аймгийн ЗДТГ (10.9↑),
- Сэлэнгэ аймгийн ЗДТГ (10.8↑)
- Дундговь аймгийн ЗДТГ (8.5↑)
- Өвөрхангай аймгийн ЗДТГ (6.1↓) зэрэг байгууллагууд хамгийн их өөрчлөлтийг үзүүлсэн байна.

Хамгийн их өсөлттэй Увс аймгийн ЗДТГ-ын хувьд ГШБҮ, ДШБҮ ба БОҮ нь харгалзан 19.9, 9.3 ба 8.1 оноогоор тус тус өссөн нь нөлөөлжээ. Үүнд, нэгдүгээрт, тус албаар үйлчлүүлэгч иргэд, ААНБ-ын төлөөлөл нь тухайн байгууллагын ил тод байдал (10.9↑), хариуцлагатай байдал (15.4↑), авлигын талаарх төсөөлөл (20.4↑), авлигын шууд тохиолдол (20.7↑), авлигын шууд бус тохиолдол (38.9↑) зэрэг үзүүлэлтүүдийг илүү үнэлсэн нь нөлөөлсөн

байна. Хоёрдугаарт, ДШБҮ-ний албан бус хэм хэмжээ (10.3↑), авлигын эсрэг тогтолцоо (21.3↑), удирдлагын хүсэл эрмэлзэл (8.3↑) үзүүлэлтүүдийн өсөлт нөлөөлжээ. Гуравдугаарт, бодлогод оролцогч, шинжээчид тус ЗДТГ-ын авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл үзүүлэлтүүдэд өмнөх оноос 13.5 ба 14.1 гэсэн оноогоор тус тус илүү үнэлгээ өгсөн байна.


ЗДТГ-уудаас хамгийн их бууралтыг Өвөрхангай аймгийн ЗДТГ үзүүлсэн байна. Энэхүү өөрчлөлтийг задалбал ГШБҮ ба БОҮ харгалзан 21.6 ба 0.8 оноогоор буурч, ДШБҮ 4.3 оноогоор өссөн байна. Төрийн үйлчилгээ авсан иргэд, ААНБ-ын төлөөлөл нь тус байгууллагын ил тод байдал (16.1↓), хариуцлагатай байдал (22.6↓), авлигын талаарх төсөөлөл (23.8↓), авлигын шууд тохиолдол (21.0↓), авлигын шууд бус тохиолдол (27.0↓) үзүүлэлтийг өмнөх оноос багаар үнэлжээ.

Аймаг, нийслэлийн ЗДТГ тус бүрээр ГШБҮ, ДШБҮ ба БОҮ-ний нэгж асуултуудын үнэлгээ ба өөрчлөлт, дүгнэлтийг харгалзах тайлангуудаас дэлгэрэнгүй харна уу. Хамгийн бага үнэлгээтэй ЗДТГ-уудын дэлгэрэнгүй дүгнэлтийг тайлангийн 2.3 дэд хэсэгт танилцууллаа.

2.2.4 Дүүргүүдийн ШБҮ-ний үр дүн

Энэ онд нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ-ын ШБҮ нь 76.5 буюу өмнөх оноос 4.4 оноогоор өссөн байна. Үүнийг төрийн бусад төрлийн 72 байгууллагын дундажтай харьцуулахад 1.6 оноогоор илүү байна⁵. 2024 оноос бусад оны судалгаанд дүүргийн дундаж ШБҮ нь төрийн бусад байгууллагын дунджаас өндөр үр дүнг үзүүлжээ.


Зураг 16. Дүүргүүдийн ШБҮ, 2022 – 2025



ШБҮ-ний бүрэлдэхүүн үнэлгээгээр задалж үзвэл, мөн л ДШБҮ нь илүү өндөр үнэлгээтэй байдаг нь харагдаж байна. Энэ онд дүүргүүдийн хувьд БОҮ хамгийн бага үр дүнг харуулсан байна. Өмнөх онтой харьцуулбал, ГШБҮ ба БОҮ нь харгалзан 8.1 ба 7.0 онооны өсөлтийг үзүүлсэн бол ДШБҮ нь 1.8 оноогоор буурсан байна.

⁵ Тайлангийн эхэнд дурдсанчлан төрийн байгууллагын ШБҮ-ний дундаж тооцоололд дүүргийн ЗДТГ-уудыг оруулаагүй буюу тусад нь тооцсон болно.

Зураг 17. Дүүргийн ЗДТГ-уудын ШБҮ, түүний бүрэлдэхүүн үнэлгээ, 2022-2025 он



ГШБҮ-ний бүх дэд үзүүлэлтүүд өмнөх оноос өссөнөөс авлигын шууд ба шууд бус тохиолдол харгалзан 14.8 ба 14.1 оноогоор өссөн байна. Бусад төрийн байгууллагад ажиглагдаж буй нөхцөлтэй адилаар ил тод байдал (61.1), авлигын талаарх төсөөлөл (68.8), хариуцлагатай байдлын (69.4) үзүүлэлтүүд хангалтгүй үнэлгээтэй байна.

Хүснэгт 17. Дүүргийн ЗДТГ-уудын ГШБҮ-ний дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ, өөрчлөлт

	Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын эрсдэлийн индекс	Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс	ГШБҮ
2024	58.6	64.2	61.4	60.5	75.6	78.9	71.7	66.5
2025	61.1	69.4	65.2	68.8	90.4	93.0	84.1	74.6
Өөрчлөлт	2.5	5.1	3.8	8.3	14.8	14.1	12.4	8.1

Хавсралт 3-аас харахад дүүргүүдийн дунджаар ГШБҮ-ний 20 нэгж асуултаас мөн л ил тод байдал, хариуцлагатай байдал ба авлигын талаарх төсөөллийн асуултууд 70 ба түүнээс доош үнэлгээтэй байна. Дүүрэг бүрийн ЗДТГ-ын нэгж асуултын үнэлгээ, өөрчлөлтийг “Судалгааны тайлан 1: Төрийн байгууллагын шударга байдлын талаар үйлчлүүлэгчдээс авах судалгааны тайлан”-аас дэлгэрэнгүй харна уу. Энэ хэсэгт дүгнэхэд яамдын ГШБҮ-ний А1-А10 асуултуудын дундаж нь бүгд 70-аас доош буюу 58-66-ийн хооронд үнэлгээтэй байна.

Дүүргийн ЗДТГ-уудын ДШБҮ нь өөрчлөлт бага буюу 1.8 оноогоор буурч, хамгийн их бууралттай үзүүлэлтүүд нь үүрэг даалгаврын шударга байдал (4.5↓) ба удирдлагын хүсэл эрмэлзэл (4.6↓) зэрэг байна. Хамгийн бага үнэлгээтэй үзүүлэлтүүд нь авлигын эсрэг тогтолцоо (70.1) ба удирдлагын хүсэл эрмэлзэл (2.1) гэсэн үзүүлэлтүүд байлаа. Өмнөх онд ч эдгээр үзүүлэлтүүд мөн хамгийн бага үнэлгээтэй байсан.

Хүснэгт 18. Дүүргийн ЗДТГ-уудын ДШБҮ-ний дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ, өөрчлөлт

	Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Соёлын индекс	Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	ДШБҮ
2024	82.0	70.7	76.4	98.4	94.7	89.5	99.6	76.6	91.8	84.1
2025	80.0	70.1	75.1	97.8	92.9	84.9	99.1	72.1	89.4	82.2
Өөрчлөлт	-1.9	-0.6	-1.3	-0.6	-1.8	-4.6	-0.6	-4.5	-2.4	-1.8

ДШБҮ-г тооцоход 27 нэгж асуултыг ашигладаг ба эдгээрээс “А9. Танай байгууллагад авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрэлдсэн гэдэгтэй та санал нийлэх үү?” асуултад 67.6 оноо, “А7. Танай байгууллага авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан гэдэгтэй та санал нийлэх үү?” асуултад 68.9 оноог яамдын алба хаагчид өгсөн байгаа нь ДШБҮ-ний хамгийн бага үнэлгээ бүхий асуултууд байна (Хавсралт 3-д яамдын дунджаар). Яам бүрээрх ДШБҮ-ний нэгж асуултуудын үнэлгээ ба өөрчлөлтийг “Судалгааны тайлан 2: Төрийн байгууллагын шударга байдлын талаар алба хаагчдаас авах судалгааны тайлан”-аас дэлгэрэнгүй харна уу.

БОҮ-ний дэд үзүүлэлтүүд бусад төрлийн төрийн байгууллагуудтай харьцуулахад өсөлт харьцангуй өндөр байна. Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 7.6 оноогоор өссөн ч 66.4 үнэлгээтэй, авлигыг хянах механизм 53.2 гэсэн үнэлгээтэй тус тус байна.

Хүснэгт 19. Дүүргийн ЗДТГ-уудын БОҮ-ний дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ, өөрчлөлт


	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	БОҮ
2024	64.7	50.2	88.6	58.7	65.6
2025	75.8	53.2	94.9	66.4	72.6
Өөрчлөлт	11.1	3.0	6.3	7.6	7.0

Хавсралт 3-аас харахад БОҮ-ний 16 нэгж асуултаас “А.10 дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог гэдэгтэй санал нийлэх үү” асуултад 48.8 оноо, “А11. Авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэгчийг бүрэн хамгаалсан гэдэгтэй санал нийлэх үү” асуултад 48.6 оноо, “А8. Төрийн үйлчилгээг үзүүлэхдээ бусдаас шан харамж авсан эсхүл өгсөн гэдэгтэй санал нийлэх үү” асуултад 59.5 оноог тус тус өгсөн нь бага үнэлгээтэй асуултууд байна. Яам бүрийн БОҮ-ний нэгж асуултууд, түүний өөрчлөлтийг “Судалгааны тайлан 3: Төрийн байгууллагын шударга байдлын талаар бодлогод оролцогч, шинжээчдийн судалгааны тайлан”-аас дэлгэрэнгүй харна уу. Дүүрэг бүрээр ЗДТГ-ын БОҮ-ний нэгж асуултууд, түүний өөрчлөлтийг “Судалгааны тайлан 3: Төрийн байгууллагын шударга байдлын талаар бодлогод оролцогч, шинжээчдийн судалгааны тайлан”-аас дэлгэрэнгүй харна уу.

Дүүргийн ЗДТГ-ын ШБҮ-ний үр дүнг жагсааж харвал 9 дүүргийн үнэлгээ бүгд өмнөх оноос эерэг өөрчлөлттэй байгаа нь онцлог байна. Өмнөх онд эхний байранд жагсаж байсан Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын ШБҮ энэ онд 4 оноогоор өсөж, өмнөх байраа хадгалж үлдсэн байна. Баянгол дүүргийн ЗДТГ-ын ШБҮ хамгийн ихээр (7.1↑) өсөж удаалжээ. Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын ШБҮ 3.4 оноогоор өссөн ч энэ оны сүүлийн байранд орсон байна.

Шалтгаан нь өмнөх онд сүүлийн эрэмбэд байсан Чингэлтэй дүүргийн ШБҮ 6.9 оноогоор өссөнтэй холбоотой.

Зураг 18. Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын ШБҮ, 2024 ба 2025 оныг харьцуулсан байдал, 2025 оны эрэмбээр



Баянгол дүүргийн ШБҮ-ний өсөлт дүүргийн ЗДТГ-ууд дундаа хамгийн их дүнтэй нь байна. Үүнд, ДШБҮ 6.8 оноогоор буурсан, ГШБҮ ба БОҮ харгалзан 1.3 ба 26.8 оноогоор өссөн нь тус тус нөлөөлсөн байна. БОҮ-ний өөрчлөлтийг задлан харвал 4 дэд үзүүлэлт бүгд 20-оос дээш оноогоор өссөн байна. Удаах өндөр өөрчлөлттэй дүүрэг нь Чингэлтэй дүүргийн ЗДТГ байна. Тус байгууллагын ШБҮ 6.9 оноогоор өсөхөд БОҮ 18.6 оноогоор өссөн нөлөөлжээ. Үүнийг задлан харвал авлигын бодит тохиолдол (33.8↑), авлигыг хянах механизм (16.9↑), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл (15.5↑) үзүүлэлтүүдэд бодлогод оролцогч, шинжээчид өмнөх оноос өндөр үнэлгээ өгсөн байна.

Дүүргийн ЗДТГ тус бүрээр ГШБҮ, ДШБҮ ба БОҮ-ний нэгж асуултуудын үнэлгээ ба өөрчлөлт, дүгнэлтийг харгалзах тайлангуудаас дэлгэрэнгүй харна уу.

2.3 ШБҮ-ээр хамгийн бага үнэлгээтэй байгууллагуудын үр дүн

2025 оны судалгаанд ШБҮ-ээр хамгийн бага үнэлгээ авсан 10 байгууллагыг дэд үзүүлэлт тус бүрээр дэлгэрэнгүй авч үзье. Хавсралт ...-... д эдгээр 10 байгууллагын нэгж асуултуудын 2025 оны үнэлгээ ба өмнөх онтой харьцуулсан өөрчлөлтийг оруулсан.

1. Боловсролын яам

Боловсролын яамны хувьд ШБҮ нь 2024 онтой харьцуулахад 3.8 оноогоор буурч, 60.2 оноогоор үнэлэгдэж байна. Үр дүнд нь тус яам өмнөх оны 64 дүгээр байрнаас энэ онд 72

дугаар байранд жагссан байна. Бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг харвал, ГШБҮ ба БОҮ харгалзан 9 ба 5 оноогоор буурсан бол ДШБҮ 2.6 оноогоор өссөн байна. Тус яамны хувьд ШБҮ-ний оноо өмнөх онд ч төдийлөн өндөр үр дүнг үзүүлээгүйн дээр энэ онд цаашид буурсан байна. Дараах хүснэгтээс харахад төрийн үйлчилгээ авагчдын авлигын бодит тохиолдол ба бодлогод оролцогчдын авлигын бодит тохиолдлын үнэлгээ ихээр буурсан буюу авлигын давтамж, тохиолдол олон гарсан гэж хариулсан байгаа нь анхаарал татаж байна. Түүнчлэн энэ оны БОҮ-ээр хамгийн бага үнэлгээтэй байгууллага болсон байна.

Хүснэгт 20. Боловсролын яамны ШБҮ ба түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

	Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
	ШБҮ	64.0	60.2	-3.8
1	ГШБҮ	61.4	52.4	-9.0
1.1	Авлигын эрсдэлийн индекс	55.8	45.6	-10.2
	Ил тод байдал	54.0	43.5	-10.5
	Хариуцлагатай байдал	57.6	47.8	-9.8
1.2	Авлигын индекс	67.0	59.1	-7.9
	Авлигын талаарх төсөөлөл	54.8	48.1	-6.7
	Авлигын шууд тохиолдол	82.2	53.7	-28.5
	Авлигын шууд бус тохиолдол	64.1	75.6	11.5
2	ДШБҮ	81.4	84.0	2.6
2.1	Соёлын индекс	72.4	78.7	6.3
	Албан бус хэм хэмжээ	80.7	83.0	2.3
	Авлигын эсрэг тогтолцоо	64.0	74.3	10.3
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	90.4	89.4	-1.1
	Хүний нөөц	98.2	88.3	-9.9
	Төсвийн зарцуулалт	93.5	97.9	4.3
	Үүрэг даалгаврын шударга байдал	85.4	86.7	1.3
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100.0	100.0	0.0
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	75.1	74.0	-1.1
3	БОҮ	49.2	44.2	-4.9
	Авлигын талаарх төсөөлөл (БОҮ)	35.3	47.0	11.6
	Авлигыг хянах механизм	34.1	30.0	-4.1
	Авлигын бодит тохиолдол	92.3	61.9	-30.4
	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	35.0	38.1	3.1

ГШБҮ буурч үнэлэгдэхэд авлигын эрсдэлийн индекс 10.2 оноогоор буурч 45.6, авлигын индекс 7.9 оноогоор буурч 59.1 оноо авсан нь нөлөөлжээ (Хавсралт 6). Үүнд:

- Ил тод байдал, хариуцлагатай байдлын үзүүлэлтүүд харгалзан 10.5 ба 9.8 гэсэн оноогоор буурч 50 оноо ч хүрэхгүй түвшинд үнэлэгдсэн байна. Энэхүү дэд үзүүлэлтүүдэд хамаарах 4 асуулт бүгд 50-аас доош үнэлгээтэй (Хавсралт 6). Тухайлбал, тус яамыг үнэлсэн 180 хүний 36% нь хүний нөөцийн ил тод байдлыг, 32% нь төсөв санхүүгийн ил тод байдлыг хангалттай гэдэгтэй санал нийлэхгүй болон огт санал нийлэхгүй байна.
- Авлигын төсөөллийн үзүүлэлтүүд дунджаар 6.7 оноогоор буурсан ба түүнд хамаарах 6 асуултын тав нь 50 -аас доош үнэлгээтэй, нэг нь 53.3 гэсэн үнэлгээг авсан байна. Тухайн байгууллагын алба хаагчдыг төрийн үйлчилгээг үзүүлэхдээ гаргаж буй шударга бус үйлдлийн талаарх асуултуудад судалгаанд оролцогчид дараах хувийн жинтэй хариултуудыг өгсөн байна. Үүнд, нийт хариулагчдын 26% нь төрийн албан хаагчдыг бусдад дарамт, шахалт үзүүлдэг, 30% нь ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг, 32 хувь нь хууль бусаар давуу байдал олгодог, 29% нь бусдаас шан харамж авсан эсхүл өгсөн гэх зэргээр хариулт өгчээ.
- Тус яамны авлигын шууд тохиолдлын дундаж үнэлгээ 53.7 ба өмнөх оноос 28.5 оноогоор буурсан. Сүүлийн 12 сарын хугацаанд алба хаагчид төрийн үйлчилгээг

үзүүлэхдээ дараах авлигын шинжтэй тохиолдлууд гаргасан эсэхийг иргэд хэрхэн үнэлсэнийг харвал:

- Нэмэлт төлбөр авсан байдал 88.6 (4.3↓) оноо, нэмэлт төлбөр өгсөн давтамж 58.1 (9.7↓), мөнгөн дүн 53.6 (25.2↓) зэрэг оноогоор үнэлсэн байна.
- Шууд болон шууд бус байдлаар өгсөн байдлын үнэлгээ 6.5 оноогоор буурч 87.2 үнэлгээтэй байна. Бэлэг өгсөн давтамжийн тоо өмнөх оноос өндөр буюу 27.4 (40.3↓) үнэлгээтэй, бэлэгний мөнгөн дүнгийн хэмжээ 31.9 (64.2↓) үнэлгээтэй тус тус байна.
- Хандив, туслалцаа авсан байдалд 84.8 (8.8↓) оноо, өмнөх оноос өөрчлөлтгүй. Түүний давтамж 29.8 (48.4↓), мөнгөн дүнгийн хэмжээ 21.9 (48.9↓) гэсэн үнэлгээтэй байна.
- Авлигын шууд бус тохиолдолд тухайн байгууллагад үнэлгээ өгсөн төлөөллийн 17% нь найз нөхөд, хамаатан садан нь нэмэлт төлбөр өгсөн гэж хариулсан ба үнэлгээ нь 11.5 оноогоор өсч, 75.6 оноогоор үнэлэгдсэн байна.

ДШБҮ нь бусад хоёр бүрэлдэхүүн үзүүлэлтээс нэлээд их дүнгээр зөрүүтэй буюу ГШБҮ-ээс 31.6 оноогоор, БОҮ-ээс 50 орчим оноогоор илүү байна. Өөрөөр хэлбэл, тус яамны дотоод албан хаагчдын үнэлгээ гадаад талуудын үнэлгээнээс ялгаа их байна. Үүнд:

- 7 дэд үзүүлэлтээс 4 үзүүлэлт үнэлгээ өсөж, 2 үзүүлэлт үнэлгээ буурч, нэг нь өөрчлөлтгүй. Авлигын эсрэг тогтолцоо ба удирдлагын хүсэл эрмэлзэл үзүүлэлтүүд хамгийн бага буюу 74 орчим онооны үнэлгээтэй, бусад үзүүлэлтүүд бүгд 80-аас дээш үнэлгээтэй.
- Албан бус хэм хэмжээний 6 асуултаас үүргээ гүйцэтгэхдээ ил тод байдаг эсэх, хувийн ашиг сонирхлоо тавьдаг эсэх асуултууд харгалзан 75.5 ба 76.1 байгаа нь тухайн бүлэгтээ хамгийн бага үнэлгээтэй байна.
- Авлигын эсрэг тогтолцоонд хамаарах 3 асуулт бүгд өмнөх оноос өссөн ч албан хаагчид өөрсдийн байгууллагын мэдээлэгчийг хамгаалсан байдал, хяналтын дотоод механизм бүрдсэн байдал зэрэгт 70 орчим онооны үнэлгээ өгсөн байна.
- Хүний нөөцийн шударга байдалд албан тушаал ахих, дэмжлэг авах зорилгоор удирдах албан тушаалтанд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгсөн давтамжийн тоо олон байсны улмаас тухайн бүлэг үзүүлэлтэд 9.9 онооны бууралт гарсан байна. Бусад нэгж асуултуудад төдийлөн өөрчлөлтгүй
- Төсвийн зарцуулалт ба Гадаад орчин дахь авлигатай тэмцэх дэд үзүүлэлтүүдийн асуултууд бүгд 95 ба түүнээс дээш үнэлгээтэй.
- Дотоод албан хаагчид үүрэг даалгаврын шударга байдал үүн дотроо “байгууллагын удирдах алба хаагчдын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдол хэр түгээмэл байдаг вэ?” асуултад 71.8 оноо буюу нийт 50 хүнээс 14 нь заримдаа, түгээмэл, ихээхэн түгээмэл гэж хариулсан байна.
- Авлига, шударга байдал зөрчигдөхийн эсрэг дээд ба дунд түвшний удирдлагын хүсэл эрмэлзэлд харгалзан 75.7 ба 74.3 оноог тус тус өгсөн байна.

БОҮ-ний 4 дэд үзүүлэлтээс авлигын бодит тохиолдол 30.4 оноогоор буурсан байгаа нь анхаарал татаж байна. Хэдийгээр авлигын талаарх төсөөлөл, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл үзүүлэлтүүд өссөн боловч үнэлгээ хангалтгүй буюу харгалзан 47 ба 38.1 гэсэн үнэлгээтэй байна. Авлигыг хянах механизм 4.1 оноогоор үнэлгээ буурч дөнгөж 30 гэсэн үнэлгээг бодлогод оролцогч, шинжээчдээс авчээ (

Хавсралт 8. Хамгийн бага ШБҮ бүхий байгууллагуудын ДШБҮ-ний нэгж асуултуудын үр дүн, өөрчлөлт (сүүлийн 5 эрэмбийн байгууллага)

Индекс	Дэд үзүүлэлтүүд	Нэгж асуултууд	Боловсролын яам		Дорнод аймгийн ЗДТГ	
			2025 оны үнэлгээ	Өөрчлөлт	2025 оны үнэлгээ	Өөрчлөлт
Соёлын индекс	Албан бус хэм хэмжээ	A1. Танай байгууллагын алба хаагчид албан үүргээ ил тод байдлаар гүйцэтгэдэг гэдэгтэй Та санал нийлэх үү?	75.5	-2.0	73.3	0.8
		A2. Танай байгууллагын алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг гэдэгтэй та санал нийлэх үү?	76.1	2.2	76.8	4.5
		A3. Танай байгууллагын алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг гэдэгтэй та санал нийлэх үү?	79.4	5.5	78.4	6.9
		A4. Танай байгууллагын алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг гэдэгтэй та санал нийлэх үү?	83.3	7.3	76.9	3.5
		A5. Танай байгууллагын алба хаагчид албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал хэр байдаг гэж та үзэх вэ?	87.1	2.3	90.9	8.6
		A6. Танай байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй холбоотой этгээдээс нэмэлт төлбөр, бэлэг, хандив, бусад санхүүгийн тусламж авдаг гэдэгт	96.4	-1.8	92.4	3.0
	Авлигын эсрэг	A7. Танай байгууллага авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан гэдэгтэй Та санал нийлэх үү?	70.5	8.5	69.3	10.3
		A8. Танай байгууллага авлигын зөрчил гаргасан алба хаагчдад холбогдох хариуцлагыг хүлээлгэдэг гэдэгтэй та санал нийлэх үү?	81.7	8.8	73.9	9.9
		A9. Танай байгууллагад авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрэлдсэн гэдэгтэй та санал нийлэх үү?	70.8	13.7	63.1	7.9
Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	Хүний нөөц	A10. Танай байгууллагад шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал хэр түгээмэл байдаг вэ?	93.8	2.8	83.0	-4.5
		A11. Сүүлийн 12 сарын хугацаанд та албан тушаал ахих дэмжлэг авах, өөр ажилд шилжих, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд өөрийн удирдах албан тушаалтанд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгсөн тохиолдол бий юу?	98.0	-2.0	100.0	0.0
		A11.1 Хэрэв тийм бол сүүлийн 12 сарын хугацаанд нийтдээ хэдэн удаа өгсөн вэ?	50.0	-50.0	100.0	0.0
		A11.2 Хэрэв тийм бол нийтдээ хэдий хэмжээний үнэ өртөгтэй байсан бэ?	99.6	-0.4	100.0	0.0
		A13. Сүүлийн 12 сарын хугацаанд Таны хамтран ажиллагч болон удирдах албан тушаалтан албан тушаал ахих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэх зорилгоор мөнгө, үнэ бүхий зүйлс өгч байсан уу?	100.0	0.0	100.0	0.0
	Төсвийн зарцуулалт	A14. Танай байгууллагад төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал хэр түгээмэл байдаг вэ?	95.7	12.5	78.8	-6.3
		A15. Сүүлийн 12 сарын хугацаанд Танай байгууллагад төсвийг зориулалтын бусаар зарцуулсан тохиолдол бий юу?	98.0	4.0	96.7	-3.3
		A15.1 Хэрэв тийм бол сүүлийн 12 сарын хугацаанд нийтдээ хэдэн удаа тохиолдсон бэ?	99.7	2.6	99.5	-0.5
		A15.2 Хэрэв тийм бол нийтдээ хэдий хэмжээтэй үнэ, өртөгтэй байсан бэ?	98.1	-1.8	99.8	-0.2
	Үүрэг даалгаврын шударга байдал	A17. Танай байгууллагын удирдах алба хаагчдын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдол хэр түгээмэл байдаг вэ?	71.8	3.0	66.0	-2.5
		A18. Танай байгууллагын удирдах алба хаагчид хууль бус үүрэг даалгавар өгөх явдал хэр түгээмэл вэ?	87.2	6.0	79.2	-5.3
		A19. Сүүлийн 12 сарын хугацаанд Таныг албан үүргээ гүйцэтгэж байхад таны удирдах албан тушаалтан танд хууль бус үүрэг даалгавар өгч байсан уу?	94.0	0.0	100.0	3.3
		A19.1 Хэрэв тийм бол сүүлийн 12 сарын хугацаанд хууль бус үүрэг даалгавар өгөх явдал хэр олон удаа тохиолдсон бэ?	93.9	-3.7	100.0	2.7
	Гадаад орчин	A20. Сүүлийн 12 сарын хугацаанд Танай байгууллагад хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдад та болон таны хамтран ажиллагч, удирдагч вэ?	100.0	0.0	100.0	0.0
		A21. Сүүлийн 12 сарын хугацаанд Таны хамтран ажиллагч, удирдах албан тушаалтан албан үүрэгтэйгээ холбоотой бусад талуудаас мөнгө, үнэ бүхий зүйлс авч байсан уу?	100.0	0.0	100.0	0.0
	Удирдлагын хүсэл, хүснэгт	A22. Танай байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг та хэрхэн үнэлэх вэ?	75.7	1.3	70.8	-0.3
		A23. Танай байгууллагын дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг Та хэрхэн үнэлэх вэ?	74.3	-0.7	72.1	-0.1
		A24. Өмнөх жилийнхтэй харьцуулахад танай байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдсөн гэж та үзэх вэ?	72.0	-3.9	76.8	6.8

Хавсралт 9. Хамгийн бага ШБҮ бүхий байгууллагуудын ДШБҮ-ний нэгж асуултуудын үр дүн, өөрчлөлт (63-67-р эрэмбийн байгууллагууд)

Индекс	Дэд үзүүлэлтүүд	Нэгж асуултууд	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам		Баян-Өлгий аймгийн ЗДТГ	
			2025 оны үнэлгээ	Өөрчлөлт	2025 оны үнэлгээ	Өөрчлөлт
Соёлын индекс	Албан бус хэм хэмжээ	A1. Танай байгууллагын алба хаагчид албан үүргээ ил тод байдлаар гүйцэтгэдэг гэдэгтэй Та санал нийлэх үү?	70.4	1.53	70.3	-3.9
		A2. Танай байгууллагын алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг гэдэгтэй та санал нийлэх үү?	67.3	-7.2	70.2	10
		A3. Танай байгууллагын алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг гэдэгтэй та санал нийлэх үү?	69.2	-4.6	62.5	2.9
		A4. Танай байгууллагын алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг гэдэгтэй та санал нийлэх үү?	68.6	-5.3	63.3	-13
		A5. Танай байгууллагын алба хаагчид албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал хэр байдаг гэж та үзэх вэ?	83.3	-1.1	74	2.1
		A6. Танай байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй холбоотой этгээдээс нэмэлт төлбөр, бэлэг, хандив, бусад санхүүгийн тусламж авдаг гэдэгт	92.2	-0.6	90	4.1
	Авлигын эсрэг	A7. Танай байгууллага авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан гэдэгтэй Та санал нийлэх үү?	54.9	-8.3	55.4	-2.2
		A8. Танай байгууллага авлигын зөрчил гаргасан алба хаагчдад холбогдох хариуцлагыг хүлээлгэдэг гэдэгтэй та санал нийлэх үү?	65	-5.5	71.2	-1
		A9. Танай байгууллагад авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрэлдсэн гэдэгтэй та санал нийлэх үү?	56.7	1.4	54.8	-6.1
Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	Хүний нөөц	A10. Танай байгууллагад шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал хэр түгээмэл байдаг вэ?	89	-2.2	82.3	-4.7
		A11. Сүүлийн 12 сарын хугацаанд та албан тушаал ахих дэмжлэг авах, өөр ажилд шилжих, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд өөрийн удирдах албан тушаалтанд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгсөн тохиолдол бий юу?	100	0	100	0
		A11.1 Хэрэв тийм бол сүүлийн 12 сарын хугацаанд нийтдээ хэдэн удаа өгсөн вэ?	100	0	100	0
		A11.2 Хэрэв тийм бол нийтдээ хэдий хэмжээний үнэ өртөгтэй байсан бэ?	100	0	100	0
		A13. Сүүлийн 12 сарын хугацаанд Таны хамтран ажиллагч болон удирдах албан тушаалтан албан тушаал ахих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэх зорилгоор мөнгө, үнэ бүхий зүйлс өгч байсан уу?	98	-2	96.9	-3.1
	Төсвийн зарцуулалт	A14. Танай байгууллагад төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал хэр түгээмэл байдаг вэ?	70.7	-14	64.8	-15
		A15. Сүүлийн 12 сарын хугацаанд Танай байгууллагад төсвийг зориулалтын бусаар зарцуулсан тохиолдол бий юу?	94	0	96.9	10
		A15.1 Хэрэв тийм бол сүүлийн 12 сарын хугацаанд нийтдээ хэдэн удаа тохиолдсон бэ?	97.7	74.7	75.6	-14
	Үүрэг даалгаврын шударга байдал	A15.2 Хэрэв тийм бол нийтдээ хэдий хэмжээтэй үнэ, өртөгтэй байсан бэ?	69.3	4.07	99.8	0.2
		A17. Танай байгууллагын удирдах алба хаагчдын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдол хэр түгээмэл байдаг вэ?	57.4	-9.7	57.8	-16
		A18. Танай байгууллагын удирдах алба хаагчид хууль бус үүрэг даалгавар өгөх явдал хэр түгээмэл вэ?	71.7	-3.8	59.5	-19
		A19. Сүүлийн 12 сарын хугацаанд Таныг албан үүргээ гүйцэтгэж байхад таны удирдах албан тушаалтан танд хууль бус үүрэг даалгавар өгч байсан уу?	92	0	78.1	-12
		A19.1 Хэрэв тийм бол сүүлийн 12 сарын хугацаанд хууль бус үүрэг даалгавар өгөх явдал хэр олон удаа тохиолдсон бэ?	96.6	23.4	24.1	-73
	Гадаад орчин	A20. Сүүлийн 12 сарын хугацаанд Танай байгууллагад хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдад та болон таны хамтран ажиллагч, удирдагч вэ?	100	2	100	0
		A21. Сүүлийн 12 сарын хугацаанд Таны хамтран ажиллагч, удирдах албан тушаалтан албан үүрэгтэйгээ холбоотой бусад талуудаас мөнгө, үнэ бүхий зүйлс авч байсан уу?	100	0	100	0
	Удирдлагын хүсэл, амьдрал	A22. Танай байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг та хэрхэн үнэлэх вэ?	64.6	1.46	56.5	-18
		A23. Танай байгууллагын дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг Та хэрхэн үнэлэх вэ?	64.6	-1.9	58.3	-13
		A24. Өмнөх жилийнхтэй харьцуулахад танай байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдсөн гэж та үзэх вэ?	70.5	5.02	58.8	-21

Хавсралт 10). Үүнд:

- Авлигын талаарх төсөөллийн 9 нэгж асуулт бүгд эерэг өөрчлөлттэй буюу 6.1-19.5-ийн хооронд өсөлттэй боловч үнэлгээ 40-51.5-ийн хооронд байна. Эдгээрээс хамгийн бага үнэлгээтэй нь “албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар давуу байдал олгогдог” гэсэн асуулт байна. Тухайлбал, бодлогод оролцогчдын үнэлгээнд орсон 25 хүний 9 нь энэ байдлыг түгээмэл ба ихээхэн түгээмэл гэж үзсэн байна.
- Авлигыг хянах механизм дэд үзүүлэлтийн 3 асуултын 2 нь дөнгөж 23 орчим онооны үнэлгээтэй байна.Тухайлбал, “дотоод хяналтын механизмаар авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал”-ыг судалгаанд оролцогчийн 14 нь санал нийлэхгүй ба огт нийлэхгүй гэж үзсэн бол “ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан” гэдэгтэй 11 хүн санал нийлэхгүй ба огт нийлэхгүй гэжээ.
- Авлигын бодит тохиолдол үзүүлэлтэд хамаарах хоёр асуулт харгалзан 33.3 ба 27.5 оноогоор тус тус буурсан буюу төрийн албан хаагчид албан үүрэгтэй нь холбоотой хандив, бэлэг, санхүүгийн тусламжийг өгсөн ба авсан байдлын давтамж нэмэгдсэн гэж хариулжээ.
- Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэлд багахан өөрчлөлт гарч үүнд бодлогод оролцогчид нь дунд түвшний менежерүүдийн хүсэл эрмэлзэл нэмэгдсэн гэж хариулсан нь нөлөөлсөн байна.
- Бодлогод оролцогчдын үнэлгээнд харьцангуй цөөн субъект ордог бөгөөд нэгж асуултуудаас харахад мэдэхгүй/хариулахаас татгалзсан хариултын тоо олон байна. Хамгийн багадаа таваас хамгийн ихдээ 13 хүн тухайн асуултад хариулаагүй тохиолдлууд байна.

2. Дорнод аймгийн ЗДТГ

Дорнод аймгийн ЗДТГ-ын ШБҮ өмнөх оноос 2 оноогоор өссөн боловч 4 байр ухарч энэ онд 71-р эрэмбэд жагсаж байна. Бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг харвал, ГШБҮ төдийлөн өөрчлөлтгүй, ДШБҮ ба БОҮ харгалзан 3.3 ба 3.4 онооны өсөлттэй.

Хүснэгт 21. Дорнод аймгийн ЗДТГ-ын ШБҮ ба түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

	Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		60.5	62.5	2
1	ГШБҮ	50.2	49.2	-0.9
1.1	Авлигын эрсдэлийн индекс	41.3	41	-0.3
	Ил тод байдал	41.3	34.9	-6.4
	Хариуцлагатай байдал	41.3	47.1	5.7
1.2	Авлигын индекс	59	57.5	-1.5
	Авлигын талаарх төсөөлөл	42.3	44.5	2.1
	Авлигын шууд тохиолдол	70.3	75.2	4.8
	Авлигын шууд бус тохиолдол	64.3	52.8	-11.5
2	ДШБҮ	79.2	82.5	3.3
2.1	Соёлын индекс	68.2	75.1	6.9
	Албан бус хэм хэмжээ	76.9	81.4	4.5
	Авлигын эсрэг тогтолцоо	59.4	68.8	9.4
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	90.3	90	-0.4
	Хүний нөөц	97.5	96.6	-0.9
	Төсвийн зарцуулалт	96.3	93.7	-2.6
	Үүрэг даалгаврын шударга байдал	86.7	86.3	-0.4
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100	100	0.0
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	71.1	73.2	2.1
3	БОҮ	52.2	55.6	3.4
	Авлигын талаарх төсөөлөл (БОҮ)	47.2	49.5	2.3
	Авлигыг хянах механизм	32.1	31.5	-0.6
	Авлигын бодит тохиолдол	86.4	87.3	0.9

Тус ЗДТГ-ын ГШБҮ-ний үр дүнд авлигын эрсдэлийн индекс 0.3-аар, авлигын индекс 1.5-аар тус тус буурсан явдал нөлөөлжээ (Хавсралт 6). Үүнд:

- Ил тод байдал 6.4 оноогоор буурсан ч хариуцлагатай байдал 5.7 оноогоор өссөн нь эцсийн үр дүнд нөхөгдөх шинжтэй нөлөө үзүүлж байна. Хавсралт 6-аас харахад ил тод байдлын хоёр асуулт 40-аас бага үнэлгээтэй, хариуцлагатай байдлын хоёр асуулт 50 ба түүнээс бага үнэлгээтэй тус тус байна. Тухайлбал, судалгаанд орсон 180 хүний 18 хувь нь хүчин чармайлт гаргаж ажилладаг байдалтай санал нийлнэ, бүрэн санал нийлнэ гэсэн бол ёс зүйгүй үйлдэл гаргадаг байдалтай 24 хувь нь санал нийлэхгүй болон огт нийлэхгүй гэж үзжээ.
- Авлигын төсөөллийн үзүүлэлтүүд дунджаар 2.1 оноогоор өссөн ч дундаж үнэлгээ 44 байна. Тус дэд үзүүлэлтэд хамаарах 6 асуултаас 5 нь 50-аас доош оноотой, үүнээс нэг нь 34.7 гэсэн үнэлгээг авсан байна. Тухайн бага үнэлгээтэй асуулт нь алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг гэсэн асуулт ба нийт судалгаанд оролцсон 180 хүний 52 хувь нь санал нийлж болон бүрэн санал нийлж байна гэж хариулжээ.
- Авлигын шууд тохиолдлын дундаж үнэлгээ 82.4 ба өмнөх оноос 12 оноогоор өсчээ. Үүнд сүүлийн 12 сарын хугацаанд алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ
 - Нэмэлт төлбөр авсан байдал 80.9 (6↓) оноо, нэмэлт төлбөр өгсөн давтамж 47.4 (12.5↑), мөнгөн дүн 90.4 (12.5↑) зэрэг оноогоор үнэлсэн байна.
 - Шууд болон шууд бус байдлаар өгсөн байдлын үнэлгээ 3.1 оноогоор өсөж 92.5 үнэлгээтэй байна. Бэлэг өгсөн давтамжийн тоо өмнөх оноос бага гэж хариулсан учир 61.7 (61.7↑)⁶ үнэлгээтэй, бэлэгний мөнгөн дүнгийн хэмжээ 92.4 (0.2↓) үнэлгээтэй тус тус байна. Өмнөх онд тус байгууллага нь сүүлийн 12 сард шууд ба шууд бус бэлэг авсан давтамжийн тоогоор хамгийн өндөр нь байжээ.
 - Хандив, туслалцаа авсан байдалд 93.6 оноо, өмнөх оноос өөрчлөлтгүй. Түүний давтамж, мөнгөн дүнгийн хэмжээ өмнөх оноос бага байснаар харгалзан 20.6 ба 3.5 оноогоор тус тус өссөн байна.
 - Авлигын шууд бус тохиолдолд тухайн байгууллагад үнэлгээ өгсөн төлөөллийн 33% нь найз нөхөд, хамаатан садан нь нэмэлт төлбөр өгсөн гэж хариулсан ба 11.5 оноогоор буурч, 52.8 оноогоор үнэлэгдсэн.

ДШБҮ нь бусад хоёр бүрэлдэхүүн үзүүлэлтээс нэлээд их дүнгээр зөрүүтэй буюу ГШБҮ-ээс 33.3 оноогоор, БОҮ-ээс 27 орчим оноогоор илүү байна. ДШБҮ-ний 7 дэд үзүүлэлтээс 3 үзүүлэлт үнэлгээ өсөж, 1 үзүүлэлт үнэлгээ буурч, 3 нь төдийлөн өөрчлөлтгүй байна. Авлигын эсрэг тогтолцоо ба удирдлагын хүсэл эрмэлзэл үзүүлэлтүүд хамгийн бага буюу харгалзан 68.8 ба 73.2 гэсэн үнэлгээтэй, бусад үзүүлэлтүүд бүгд 80-аас дээш үнэлгээтэй.

⁶ Өмнөх онд 0 үнэлгээ авч байсан байна.

Хавсралт 8-аас харахад:

- Албан бус хэм хэмжээний 6 асуулт бүгд өсөлттэй боловч түүний 4 нь 80-аас доош үнэлгээтэй. Эдгээрээс үүргээ гүйцэтгэхдээ ил тод байдаг эсэх, хувийн ашиг сонирхлоо тавьдаг эсэх асуултууд харгалзан 73.3 ба 76.8 байгаа нь тухайн бүлэгтээ хамгийн бага үнэлгээтэй байна.
- Авлигын эсрэг тогтолцоонд хамаарах 3 асуулт мөн л өмнөх оноос өссөн ч 80-аас доош үнэлгээтэй. Эдгээрээс албан хаагчид өөрсдийн байгууллагын мэдээлэгчийг хамгаалсан байдал, хяналтын дотоод механизм бүрдсэн байдал зэрэгт харгалзан 69.3 ба 63.1 гэсэн үнэлгээг өгсөн байна.
- Хүний нөөцийн шударга байдлын 5 асуултаас зөвхөн А10 буюу хүний нөөцтэй холбоотой шийдвэрт мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал түгээмэл эсэх асуулт 83 гэсэн үнэлгээтэй бусад асуултууд бүгд бүрэн оноотой байна.
- Төсвийн зарцуулалт дэд үзүүлэлтээс төсвийг зориулалтын бусаар зарцуулах явдалд 78.8 оноог албан хаагчид өгсөн бол бусад 3 асуулт бүгд 95 ба түүнээс дээш үнэлгээтэй.
- Үүрэг даалгаврын шударга байдалд “байгууллагын удирдах алба хаагчдын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдол хэр түгээмэл байдаг вэ?” болон “байгууллагын удирдах алба хаагчид хууль бус үүрэг даалгавар өгөх явдал хэр түгээмэл вэ?” асуултуудад харгалзан 66 ба 79.2 оноог өгсөн байна.
- Авлига, шударга байдал зөрчигдөхийн эсрэг дээд ба дунд түвшний удирдлагын хүсэл эрмэлзэлд харгалзан 70.8 ба 72.1 онооны үнэлгээ өгчээ. Эдгээр нь өмнөх оноос өөрчлөлтгүй гэж үзэж болохоор байна.

БОУ-ний 4 дэд үзүүлэлтээс хоёр үзүүлэлт өсөлттэй, үлдсэн хоёр нь төдийлөн өөрчлөлтгүй. Хэдийгээр буурсан үзүүлэлт байхгүй боловч авлигыг хянах механизм 31.5 оноо, авлигын талаарх төсөөлөл 49.5, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл 54.2 гэсэн үнэлгээтэй байна.

Хавсралт 10-аас харвал:

- Авлигын талаарх төсөөллийн 9 нэгж асуулт эерэг, сөрөг харилцан адилгүй өөрчлөлттэй ба 30 – 57.7 хооронд үнэлгээтэй байна. Эдгээрээс хамгийн бага үнэлгээтэй нь “албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шаардах явдал” гэсэн асуулт байна. Тус асуултад судалгаанд оролцогч 15 хүний тав нь мэдэхгүй/хариулахаас татгалзах сонголтыг хийсэн бол үлдсэн 10 хүн нь дунд зэрэг, ил тод бус, огт ил тод бус гэсэн сөрөг хариултуудыг сонгосон байна.
- Авлигыг хянах механизм дэд үзүүлэлтийн 3 асуултын үнэлгээ 12.5 – 47.9-ийн хооронд байна. Үүнээс авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдалд өмнөх оноос 20 орчим оноогоор бага үнэлгээ өгсөн нь нэгж асуултууд дунд хамгийн бага үнэлгээ авахад хүргэжээ. Энэ асуултад 15 оролцогчийн 10 нь санал нийлэхгүй, санал огт нийлэхгүй хэмээн хариулж, үлдсэн 5 нь мэдэхгүй/хариулахаас татгалзах сонголтыг тус тус хийсэн байна.
- Авлигын бодит тохиолдол үзүүлэлтэд хамаарах хоёр асуулт харгалзан 88.9 ба 85.7 байна.
- Дээд түвшний ба дунд түвшний удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг энэ онд өмнөх оноос өндрөөр үнэлсэн ч хамаарах хоёр асуулт харгалзан 56.3 (13.1↑) ба 52.1 (8.9↑) гэсэн үнэлгээтэй байна.
- Тус ЗДТГ-ын бодлогод оролцогчдын үнэлгээнд 15 субъект хамарсан ба тухайн нэгж асуултад мэдэхгүй/хариулахаас татгалзсан хариултын тоо багадаа 2 ихдээ 8 хүртэл байна.

3. Ховд аймгийн ЗДТГ

Ховд аймгийн ЗДТГ-ын ШБҮ энэ онд өмнөх оноос 2.1 оноогоор өссөн боловч 68 дугаар байрнаас 70 дугаар байр хүртэл ухарсан үр дүнтэй байна. ШБҮ-ний бүрэлдэхүүнээр авч үзвэл ГШБҮ (13.4↓), ДШБҮ (17.3↑), БОҮ (2.6↑) гэсэн өөрчлөлттэй байна. Хэдийгээр ДШБҮ өндөр өсөлтийг үзүүлсэн ч, гадаад хамааралтай талууд эсрэг үзэл бодолтой байсан байна.

Хүснэгт 22. Ховд аймгийн ЗДТГ-ын ШБҮ ба түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

	Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		60.5	62.6	2.1
1	ГШБҮ	65.0	51.6	-13.4
1.1	Авлигын эрсдэлийн индекс	58.4	44.7	-13.7
	Ил тод байдал	52.5	39.2	-13.3
	Хариуцлагатай байдал	64.3	50.3	-14.0
1.2	Авлигын индекс	71.6	58.5	-13.2
	Авлигын талаарх төсөөлөл	59.3	47.4	-12.0
	Авлигын шууд тохиолдол	79.4	70	-9.3
	Авлигын шууд бус тохиолдол	76.2	58	-18.2
2	ДШБҮ	62	79.3	17.3
2.1	Соёлын индекс	44.6	70.9	26.3
	Албан бус хэм хэмжээ	37.6	79.4	41.9
	Авлигын эсрэг тогтолцоо	51.7	62.4	10.7
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	79.4	87.7	8.3
	Хүний нөөц	89.1	95.3	6.1
	Төсвийн зарцуулалт	89.1	88.5	-0.6
	Үүрэг даалгаврын шударга байдал	79.5	85.4	6.0
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	73.3	100	26.7
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	65.8	69.4	3.5
3	БОҮ	54.4	57	2.6
	Авлигын талаарх төсөөлөл (БОҮ)	53.7	65.9	12.3

Авлигыг хянах механизм	44.6	38	-6.6
Авлигын бодит тохиолдол	70.3	73.1	2.7
Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	48.9	51	2.1

Ховд аймгийн ЗДТГ-ын ГШБҮ-ний үр дүнд авлигын эрсдэлийн индекс (13.7↓), авлигын индекс (13.2↓) гэсэн өөрчлөлтүүд нөлөөлжээ. Үүнд:

- Хүснэгт 22-оос харахад ил тод байдал ба хариуцлагатай байдлын дэд үзүүлэлт аль аль 13 ба түүнээс дээш оноогоор буурсан. Хавсралт 6-аас харахад ил тод байдлын хоёр асуулт 40-аас бага үнэлгээтэй, хариуцлагатай байдлын хоёр асуулт харгалзан 46.4 ба 54.2 гэсэн үнэлгээтэй тус тус байна. Дурдсан 4 асуулт бүгд 9 ба түүнээс дээш оноогоор буурсан байна. Тухайлбал, тус ЗДТГ-ыг үнэлсэн 180 хүний 48% нь хүний нөөцийн ил тод байдлыг, 44% нь төсөв санхүүгийн ил тод байдлыг хангалттай гэдэгтэй санал нийлэхгүй болон огт санал нийлэхгүй байна.
- Авлигын төсөөллийн үзүүлэлтүүдийн дундаж нь 12 оноогоор буурч 47.4 гэсэн үр дүнтэй. Тус дэд үзүүлэлтэд хамаарах 6 асуултын үнэлгээ 35.3-аас 52.1-ийн хооронд байгаа ба хамгийн бага үнэлгээ нь “алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг” гэсэн асуултад хамаарч байна. Энэ асуултад нийт судалгаанд оролцсон 180 хүний 52 хувь нь санал нийлж болон бүрэн санал нийлж байна гэж хариулжээ.
- Ховд аймгийн ЗДТГ-ын авлигын шууд тохиолдлын дундаж үнэлгээ 79.4 ба өмнөх оноос төдийлөн өөрчлөлтгүй байна. Сүүлийн 12 сарын хугацаанд алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ дараах авлигын шинжтэй тохиолдлуудыг иргэд хэрхэн үнэлсэнийг харвал:
 - Нэмэлт төлбөр авсан байдал 84.3 (9.6↓) оноо, нэмэлт төлбөр өгсөн давтамж 25.6 (48↓), мөнгөн дүн 59.2 (59.2↑)⁷ зэрэг оноогоор үнэлсэн байна.
 - Шууд болон шууд бус байдлаар өгсөн байдлын үнэлгээ 2.8 оноогоор буурч 93.8 үнэлгээтэй байна. Бэлэг өгсөн давтамжийн тоо өмнөх нэмэгдсэн буюу 59.1 (23.7↓) үнэлгээтэй, бэлэгний мөнгөн дүнгийн хэмжээ 94.5 (2.4↑) үнэлгээтэй тус тус байна.
 - Хандив, туслалцаа авсан байдалд 93.9 (2.7↓) оноо, өмнөх оноос өөрчлөлтгүй. Түүний давтамж 39.4 (49.3↓), мөнгөн дүнгийн хэмжээ 80.6 (9.4↓) гэсэн үнэлгээтэй байна.
- Авлигын шууд бус тохиолдолд тухайн байгууллагад үнэлгээ өгсөн төлөөллийн 31% нь найз нөхөд, хамаатан садан нь нэмэлт төлбөр өгсөн гэж хариулсан ба үнэлгээ нь 18.2 оноогоор буурч, 58 оноогоор үнэлэгдсэн.

Тус аймгийн ЗДТГ-ын ДШБҮ нь 17.3 оноогоор өсөж, ГШБҮ ба БОҮ-нээс харгалзан 28 ба 25 оноогоор илүү үнэлгээтэй байна. ДШБҮ-ний 7 дэд үзүүлэлтээс 6 нь өсөлттэй, нэг нь өөрчлөлтгүй гэсэн үр дүнтэй. Албан бус хэм хэмжээ (41.9↑), гадаад орчин дахь авлигатай тэмцэх (26.7↑) гэсэн дэд үзүүлэлтүүд өндөр өсөлттэй.

⁷ Өмнөх онд өгсөн нэмэлт төлбөрийн дундаж дүн хамгийн өндөр байгууллага буюу тус нэгж асуултад 0 үнэлгээ авч байсан.

Хавсралт 8-аас харахад:

- Албан бус хэм хэмжээний 6 асуултын өөрчлөлт 25.2 – 53.6-ийн хооронд байгаа нь огцом өсөлтийг илэрхийлж байна. Үр дүнд нь 75 – 86.9-ийн хооронд үнэлгээтэй гарсан байна.
- Авлигын эсрэг тогтолцоонд хамаарах 3 асуулт мөн л өмнөх бүгд өссөн ч 70-аас бага үнэлгээтэй. Эдгээрээс албан хаагчид өөрсдийн байгууллагад дотоод хяналтын механизм бүрдсэн байдалд 57.6 оноо өгчээ. Тухайлбал, судалгаа өгсөн 30 албан хаагчийн 8 нь үүнтэй санал нийлэхгүй ба огт нийлэхгүй, 7 нь мэдэхгүй/хариулахаас татгалзсан гэсэн сонголтыг хийсэн байна.
- Хүний нөөцийн шударга байдлын 5 асуултаас зөвхөн А10 буюу хүний нөөцтэй холбоотой шийдвэрт мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал түгээмэл эсэх асуулт 76.3 (30.6↑) гэсэн үнэлгээтэй бусад асуултууд бүгд бүрэн оноотой байна.
- Төсвийн зарцуулалт дэд үзүүлэлтээс төсвийг зориулалтын бусаар зарцуулах явдалд 75.0 (18.8↑) оноог албан хаагчид өгсөн бол бусад 3 асуулт бүгд 90 ба түүнээс дээш үнэлгээтэй.
- Үүрэг даалгаврын шударга байдалд “байгууллагын удирдах алба хаагчдын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдол хэр түгээмэл байдаг вэ?” болон “байгууллагын удирдах алба хаагчид хууль бус үүрэг даалгавар өгөх явдал хэр түгээмэл вэ?” асуултуудад харгалзан 68.8 (25.9↑) ба 72.9 (2.1↓) оноог өгсөн ба үлдсэн хоёр асуулт 100 гэсэн үнэлгээтэй.
- Авлига, шударга байдал зөрчигдөхийн эсрэг дээд ба дунд түвшний удирдлагын хүсэл эрмэлзэлд харгалзан 69.0 ба 68.2 онооны үнэлгээ өгсөн ба өмнөх оноос өөрчлөлтгүй гэж үзэж болохоор байна.

БОУ-ний 4 дэд үзүүлэлтээс авлигыг хянах механизм (6.6↓) гэсэн хүчин зүйл л бууралттай бусад нь өсөлттэй байна.

Хавсралт 10-с хамаарах нэгж асуултуудын үнэлгээ, өөрчлөлтийг харвал:

- Авлигын талаарх төсөөллийн 9 нэгж асуулт бүгд өмнөх оноос өссөн дүнтэй ба 50– 75-ийн хооронд үнэлгээтэй байна. Эдгээрээс хамгийн бага үнэлгээтэй нь “албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шаардах явдал” гэсэн асуулт байгаа нь өмнөх Дорнод аймгийн ЗДТГ-тай адил байна. Тус асуултад судалгаанд оролцогч 15 хүний 4 нь мэдэхгүй/хариулахаас татгалзах сонголтыг хийсэн бол 9 хүн нь дунд зэрэг, ил тод бус, огт ил тод бус гэсэн сөрөг хариултуудыг сонгосон байна.
- Авлигыг хянах механизм дэд үзүүлэлтийн 3 асуултын үнэлгээ 31.3 – 41.7-ийн хооронд байна. Үүнээс авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдалд 6.3 оноогоор бага үнэлгээ өгсөн нь нэгж асуултууд дунд хамгийн бага үнэлгээ авахад хүргэжээ. Энэ асуултад 15 оролцогчийн 6 нь санал нийлэхгүй, санал огт нийлэхгүй хэмээн хариулж, 3 нь мэдэхгүй/хариулахаас татгалзах сонголтыг тус тус хийсэн байна.
- Авлигын бодит тохиолдол үзүүлэлтэд хамаарах хоёр асуулт харгалзан 69.2 (0.0) ба 76.9 (5.5↑) байна.
- Дээд түвшний ба дунд түвшний удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг энэ онд харгалзан 50 (8.9↑) ба 51.9 (4.7↓) гэж үнэлсэн байна.
- Тус ЗДТГ-ын бодлогод оролцогчдын үнэлгээнд 15 субъект хамарсан ба тухайн нэгж асуултад мэдэхгүй/хариулахаас татгалзсан хариултын тоо 1-3-ийн хооронд буюу харьцангуй бага байна.

4. Эрүүл мэндийн яам

Эрүүл мэндийн яам энэ онд ШБҮ нь 8 оноогоор буурч өмнөх оны 46 дахь байрнаас энэ онд 69 дүгээрт жагссан байна. Бүрэлдэхүүн үнэлгээнүүд бүгд бууралттай буюу ГШБҮ (14.7↓), ДШБҮ(6.5↓), БОҮ (2.7↓) тус тус байна. Өмнө шинжилсэн гурван байгууллагаас ялгаатай нь ШБҮ нь их бууралттайн улмаас доод эрэмбэд шилжжээ.

Хүснэгт 23. Эрүүл мэндийн яамны ШБҮ ба түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

	Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
	Шударга байдлын үнэлгээ	71.2	63.2	-8
1	ГШБҮ	67.8	53	-14.7
1.1	Авлигын эрсдэлийн индекс	59.2	49	-10.0
	Ил тод байдал	60.3	47	-13.4
	Хариуцлагатай байдал	58	51	-6.6
1.2	Авлигын индекс	76.4	57	-19.4
	Авлигын талаарх төсөөлөл	53.2	51	-2.0
	Авлигын шууд тохиолдол	88.9	38	-50.7
	Авлигын шууд бус тохиолдол	87.2	82	-5.5
2	ДШБҮ	77.9	71	-6.5
2.1	Соёлын индекс	68.5	61	-7.0
	Албан бус хэм хэмжээ	76.3	71	-4.9
	Авлигын эсрэг тогтолцоо	60.6	51	-9.2
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	87.3	81	-6.1
	Хүний нөөц	96	96	0.1
	Төсвийн зарцуулалт	95.8	84	-11.7
	Үүрэг даалгаврын шударга байдал	79	71	-8.0
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	99	98	-1.0
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	66.8	57	-9.8
3	БОҮ	67.8	65.1	-2.7
	Авлигын талаарх төсөөлөл (БОҮ)	70.4	57.1	-13.2
	Авлигыг хянах механизм	44.7	37.8	-7.0

Авлигын бодит тохиолдол	100	97.6	-2.4
Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	56.1	67.8	11.7

Тус яамны ГШБҮ-ний үр дүнд авлигын эрсдэлийн индекс (10.0↓), авлигын индекс (19.4↓) гэсэн өөрчлөлтүүд нөлөөлжээ. Үүнд:

- Хүснэгт 23-с харахад ил тод байдал ба хариуцлагатай байдлын дэд үзүүлэлтүүд хоёулаа бууралттай. Хавсралт 6-аас харахад ил тод байдлын хоёр асуулт 50-аас бага үнэлгээтэй, хариуцлагатай байдлын хоёр асуулт 51 оноо орчимд үнэлгээтэй байна. Дурдсан 4 асуулт бүгд буурсан байна. Тухайлбал, тус яамыг үнэлсэн үнэлсэн 120 хүний 30% нь хүний нөөцийн ил тод байдлыг, 22.5% нь төсөв санхүүгийн ил тод байдлыг хангалттай гэдэгтэй санал нийлэхгүй болон огт санал нийлэхгүй байна.
- Авлигын төсөөллийн үзүүлэлтүүдийн дундаж нь 2 оноогоор буурсан, түүнд хамаарах 6 асуултын үнэлгээ 50.5 – 53.2-ийн хооронд байна.
- Эрүүл мэндийн яамны авлигын шууд тохиолдлын дундаж үнэлгээ маш ихээр буюу 51 орчим оноогоор буурсан нь анхаарал татаж байна. Сүүлийн 12 сарын хугацаанд алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ дараах авлигын шинжтэй тохиолдлуудыг иргэд хэрхэн үнэлсэнийг харвал:
 - Нэмэлт төлбөр авсан байдал 77.1 (16.7↓) оноо, нэмэлт төлбөр өгсөн давтамж 23.3 (54.5↓), мөнгөн дүн 24.5 (74.8↓) зэрэг оноогоор үнэлсэн байна. Өмнөх онтой харьцуулахад давтамж, мөнгөн дүнгийн хэмжээнд их хэмжээний өсөлт гарсан гэж хариулжээ.
 - Шууд болон шууд бус байдлаар бэлэг өгсөн байдал 77.1 (17.8↓) үнэлгээтэй байна. Бэлэг өгсөн давтамжийн тоо 0.0 (74.2↓) ба мөнгөн дүнгийн хэмжээ өмнөх оноос бага буюу 9.7 (89.0↓) үнэлгээтэй тус тус байна. Тус яам нь энэ оны судалгаанд нийт төрийн байгууллагууд дундаас шууд ба шууд бус байдлаар бэлэг өгсөн давтамж хамгийн өндөр байсан байна. Үүнийгээ дагаад бэлэгний мөнгөн дүн бас их өсөлттэй гэсэн үр дүн гарчээ. Тухайлбал, 120 хүний 19 нь бэлэг өгсөн гэж хариулсан ба нэг удаа гэдэгт 8 хүн, 2 удаа гэдэгт 7 хүн, 3 удаа гэдэгт 3 хүн хариулт өгсөн байна. Мөнгөн дүнгийн хувьд 500 мянгаас бага дүнд 17 хүн, 2.1 саяас дээш дүнгүүдэд 2 хүн хариулт өгсөн байлаа.
 - Хандив, туслалцаа өгсөн байдалд 79.0 (15.8↓) оноо. Түүний давтамж 25.7 оноо (42.9↓), мөнгөн дүнгийн хэмжээ 28.1 (70.5↓) гэсэн үнэлгээтэй байна.
- Авлигын шууд бус тохиолдолд тухайн байгууллагад үнэлгээ өгсөн төлөөллийн 15% нь найз нөхөд, хамаатан садан нь нэмэлт төлбөр өгсөн гэж хариулсан ба үнэлгээ нь 5.5 оноогоор буурч, 81.6 оноогоор үнэлэгджээ.

Тус яамны ДШБҮ нь 6.5 оноогоор буурч, ГШБҮ ба БОҮ-нээс харгалзан 18.2 ба 6.2 оноогоор илүү үнэлгээтэй байна. ДШБҮ-ний 7 дэд үзүүлэлтээс 6 нь бууралттай, нэг нь өөрчлөлтгүй гэсэн үр дүнтэй.

Хавсралт 8-аас харахад:

- Албан бус хэм хэмжээний 6 асуултын үнэлгээ нь 61.5– 83.9-ийн хооронд байна. Эдгээрээс 5 дэд үзүүлэлт 4.8 – 8.7-ийн хооронд бууралттай байна.
- Авлигын эсрэг тогтолцоонд хамаарах 3 асуулт бүгд бууралттай ба 50.7 – 52.9-ийн хооронд л үнэлэгджээ. Тухайлбал, мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал, зөрчилд хариуцлага тооцдог байдал, дотоод хяналтын механизм бүрдсэн байдалд судалгаа өгсөн 50 албан хаагчаас харгалзан 13, 14, ба 15 хүн санал нийлэхгүй ба огт нийлэхгүй гэж хариулсан.
- Хүний нөөцийн шударга байдлын 5 асуултаас зөвхөн А10 буюу хүний нөөцтэй холбоотой шийдвэрт мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал түгээмэл эсэх асуулт 84.4 (4.6↑) гэсэн үнэлгээтэй бусад асуултууд бүгд бүрэн оноотой байна.
- Төсвийн зарцуулалт дэд үзүүлэлтийн 4 асуулт бүгд өмнөх оноос буурч 75.0 – 94.0-ийн хооронд үнэлгээтэй. Үүнээс төсвийг зориулалтын бусаар зарцуулах явдалд 75.0 (8.1↓) оноог албан хаагчид өгсөн ба төсвийг зориулалтын бусаар ашиглах давтамж ба үнийн дүнгийн асуулт 83.9 (16.1↓) ба 83.5 (16.5↓) гэсэн үр дүнтэй байна.
- Үүрэг даалгаврын шударга байдалд “байгууллагын удирдах алба хаагчдын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдол хэр түгээмэл байдаг вэ?” болон “байгууллагын удирдах алба хаагчид хууль бус үүрэг даалгавар өгөх явдал хэр түгээмэл вэ?” асуултуудад харгалзан 52.8 (5.1↓) ба 68.6 (2.3↓) оноог өгсөн байна. Эдгээр нөхцөл өмнөх жилд ч хангалтгүй үнэлгээтэй байсан байна. Сүүлийн 12 сарын хугацаанд хууль бус үүрэг даалгавар өгөх явдлын давтамж нэмэгдсэн буюу 20.5 оноогоор буурч 76.8 оноог авсан байна.
- Гадаад орчин дахь авлигатай тэмцэх нөхцөл өмнөх байгууллагуудтай адил хангалттай үнэлгээтэй байгаа бол авлига, шударга байдал зөрчигдөхийн эсрэг дээд ба дунд түвшний удирдлагын хүсэл эрмэлзэлд харгалзан 60.0 (6.4↓) ба 56.9 (7.5↓) онооны үнэлгээ өгсөн байна. Яамны авлигатай тэмцэх үйл ажиллагааг буурсан буюу 15.4 оноогоор өмнөх оноос багаар үнэлсэн байна.

БОУ-ний 4 дэд үзүүлэлтээс удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (11.7↑) гэсэн хүчин зүйл өсөлттэй, бусад үзүүлэлт бууралттай байна.

Хавсралт 10-аас харвал:

- Авлигын талаарх төсөөллийн 9 нэгж асуултаас зөвхөн авлигын түгээмэл байдлын асуулт өсөлттэй ба их дүнгээр буурсан асуултууд олон байна. Тухайлбал, албан хаагчид үүргээ гүйцэтгэхдээ нэмэлт төлбөр, бэлэг авах явдал 41.0 (32.8↓), хууль тогтоомжоор олгогдсоноос илүү эрх эдлэх явдал 42.0 (33.0↓), хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал 53.0 (16.3↓), бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал 56.0 (15.9↓) зэрэг асуултууд ихээр буурсан нь анхаарал татаж байна. Дээр дурдсанаас эхний хоёр асуултад нийт 25 шинжээчээс тус бүр 10 нь түгээмэл ба ихээхэн түгээмэл гэж хариулсан байна.
- Авлигыг хянах механизм дэд үзүүлэлтийн 3 асуултын үнэлгээ 14.3 – 60.0-ийн хооронд байна. Дотоод хяналтын механизмаар авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдалд өгсөн үнэлгээ 14.3 (29.5↓) үр дүнтэй байгаа нь өмнөх оноос ч муудсан үзүүлэлт болжээ. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдлын үнэлгээ 39.0 (3.3↓) гэсэн үр дүнтэй.
- Авлигын бодит тохиолдол үзүүлэлтэд хамаарах хоёр асуултууд хангалттай үнэлгээтэй байгаа бол дээд түвшний ба дунд түвшний удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг энэ онд өмнөх оноос өндрөөр үнэлсэн ч хамаарах хоёр асуулт харгалзан 69.0 (9.0↑) ба 66.7 (14.5↑) гэсэн үнэлгээтэй байна.
- Тус яамны бодлогод оролцогчдын үнэлгээ 25 субъектийг хамарсан ба тухайн нэгж асуултад мэдэхгүй/хариулахаас татгалзсан хариултын тоо 1-4-ийн хооронд буюу харьцангуй бага байна.

5. Мал эмнэлгийн ерөнхий газар

Мал эмнэлгийн ерөнхий газар нь ШБҮ-ний хамгийн их бууралттай 10 байгууллагын нэг бөгөөд өмнөх онд 31-р эрэмбээс энэ онд 68 дугаар эрэмбэд жагссан байна. Бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн үр дүн ГШБҮ (0.5↓), ДШБҮ(20.5↓), БОҮ (9.8↓) тус тус өөрчлөлттэй ба тус байгууллага нь ДШБҮ хамгийн ихээр буурсан байгууллага байгаа нь онцлог байна.

Хүснэгт 24. Мал эмнэлгийн ерөнхий газрын ШБҮ ба түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

	Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		74.1	63.8	-10.3
1	ГШБҮ	69.4	68.9	-0.5
1	Авлигын эрсдэлийн индекс	57	54	-3.0
	Ил тод байдал	47.1	41.8	-5.3
	Хариуцлагатай байдал	66.9	66.2	-0.7
1	Авлигын индекс	81.8	83.9	2.0
	Авлигын талаарх төсөөлөл	59.5	64.7	5.2
	Авлигын шууд тохиолдол	89.4	98.1	8.7
	Авлигын шууд бус тохиолдол	96.6	88.9	-7.7
2	ДШБҮ	80.5	60	-20.5
2	Соёлын индекс	69.6	46.4	-23.3
	Албан бус хэм хэмжээ	76.4	56.5	-19.8
	Авлигын эсрэг тогтолцоо	62.9	36.2	-26.7
2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	91.3	73.6	-17.7
	Хүний нөөц	98.3	98.6	0.3
	Төсвийн зарцуулалт	98.3	76.4	-21.9
	Үүрэг даалгаврын шударга байдал	89.3	46.4	-43.0
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100	95	-5.0
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	70.5	51.7	-18.8
3	БОҮ	72.4	62.6	-9.8

Авлигын талаарх төсөөлөл (БОУ)	77.8	74.6	-3.3
Авлигыг хянах механизм	48.6	42.2	-6.4
Авлигын бодит тохиолдол	100	96.7	-3.3
Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	63.2	37	-26.2

Мал эмнэлгийн ерөнхий газрын ГШБҮ-ний үр дүнд авлигын эрсдэлийн индекс (3.0↓), авлигын индекс (2.0↑) гэсэн өөрчлөлтүүд нөлөөлжээ. Өмнөх байгууллагуудаас ялгаатай нь эдгээр хоёр индекс хоорондоо үнэлгээний зөрүү ихтэй буюу авлигын шууд ба шууд бус тохиолдол бусад байгууллагаас бага байгаатай холбоотой байна. Задлан харвал:

- Хавсралт 6-аас харахад ил тод байдлын хоёр асуулт 49.8 (4.2↓) ба 33.8 (6.4↓) үнэлгээтэй. Хариуцлагатай байдлын хоёр асуулт төдийлөн өөрчлөлтгүйгээр харгалзан 60.7 ба 71.7 гэсэн үнэлгээтэй тус тус байна. Ил тод байдлын асуултуудад тус газрыг үнэлсэн 120 хүний 70% нь хүний нөөцийн ил тод байдалтай заримдаа санал нийлнэ эсвэл санал нийлэхгүй гэж хариулсан байна. Харин 60% нь төсөв санхүүгийн ил тод байдлыг хангалттай гэдэгтэй санал нийлэхгүй болон огт санал нийлэхгүй байна.
- Авлигын төсөөллийн дэд үзүүлэлтэд хамаарах 6 асуултын үнэлгээ 53.3-аас 81.8-ийн хооронд байгаа ба хамгийн бага үнэлгээ нь “алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ бусдаас шан харамж авсан эсхүл өгсөн” ба “бусдад хууль бусаар давуу байдал олгогдог” гэсэн асуултуудад хамаарч байна.
- Тус газрын авлигын шууд тохиолдлын дундаж үнэлгээ ба өмнөх оноос 8.7 оноогоор өсч 98.1-д хүрсэн байна. Үүнд хамаарах 9 асуултын үнэлгээ бүгд 96 ба түүнээс дээш үнэлгээтэй байгаа нь сайшаалтай үзүүлэлт болжээ.
- Авлигын шууд бус тохиолдолд тухайн байгууллагад үнэлгээ харин 7.7 оноогоор буурч 88.9 болжээ.

Мал эмнэлгийн ерөнхий газрын ДШБҮ нь 20.5 оноогоор буурсан нь соёлын индекс (23.3↓), үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс (17.7↓)-ийн бууралтуудын үр дүн байна. Хүний нөөц ба гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдлаас бусад үзүүлэлтүүд өндөр дүнгээр буурсан ба тэдгээр үзүүлэлтүүдийг нарийвчлан

Хавсралт 8-аас харахад:

- Албан бус хэм хэмжээний 6 асуултын өөрчлөлт 17.1 – 30.1-ийн хооронд байгаа нь огцом бууралтыг илэрхийлж байна. Үр дүнд нь 50.0 – 67.3-ийн хооронд үнэлгээтэй гарсан байна. Тухайлбал, байгууллагын албан хаагчид үүргээ ил тод байдлаар гүйцэтгэдэг эсэхэд 20 хүний 12 нь заримдаа, санал нийлэхгүй, огт нийлэхгүй гэж хариулжээ.
- Авлигын эсрэг тогтолцоонд хамаарах 3 асуултын бууралт 20.9 – 32.4 онооны хооронд байна. Үр дүнд нь үнэлгээ 23.5 – 45.0-ийн хооронд байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт юм. Авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрэлдсэн гэдэгтэй санал нийлэх эсэхэд 20 хүнээс 14 нь санал нийлэхгүй ба санал огт нийлэхгүй гэжээ.
- Төсвийг зориулалтын бусаар зарцуулах явдал түгээмэл эсэхэд 70.8 (22.5↓) үнэлгээ өгсөн бол судалгаанд орсон 20 албан хаагчдаас 3 нь байгууллагад төсвийг зориулалтын бусаар зарцуулах явдал байна гэснээр уг асуултын үнэлгээ 100-аас 85-д хүрсэн. Улмаар зориулалтын бусаар зарцуулсан давтамж их учир 52.4 (47.6↓) үнэлгээтэй байна.
- Үүрэг даалгаврын шударга байдлын дундаж нь 43 оноогоор буурсан нь маш их өөрчлөлт байна. Хамаарах нэгж асуултуудын бууралт нь 15.9 – 94.6-ийн хооронд байна. Үүнээс сүүлийн 12 сарын хугацаанд хууль бус үүрэг даалгавар өгсөн тохиолдлын оноо 65 (35↓), тохиолдлын давтамж маш олон буюу 5.4 (94.6↓) зэрэг нь анхаарал татахаар байна. Бусад үүрэг даалгаврын шударга бус байдлын хоёр асуулт мөн л их дүнгээр бууржээ.
- Авлига, шударга байдал зөрчигдөхийн эсрэг дээд ба дунд түвшний удирдлагын хүсэл эрмэлзэлд харгалзан 50.0 (23.3↓) ба 48.3 (18.3↓) онооны үнэлгээтэй. Байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагааны өөрчлөлтийг өмнөх оноос буурсан гэж тус тус албан хаагчид хариулжээ.

БОҮ-ний 4 дэд үзүүлэлт бүгд буурснаас удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 26 оноогоор буурч 37.0 үнэлгээтэй, авлигыг хянах механизм өмнөх оны бага түвшнээс дахин буурч 42.2 зэрэг үзүүлэлтүүдийг онцлохоор байна.

Хавсралт 10-аас харвал:

- Авлигыг хянах механизм дэд үзүүлэлтийн 3 асуултын үнэлгээ 37.5 – 50-ийн хооронд байна. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдалд нийт судалгаанд оролцсон 20 шинжээчдийн 10 нь санал нийлэхгүй, 4 нь мэдэхгүй гэж хариулснаар 37.5 оноо (2.9↓) өгсөн бол дотоод хяналтын механизмаар авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдалд 20 хүний 8 нь санал нийлэхгүй ба огт нийлэхгүй, 4 нь мэдэхгүй гэж хариулснаар 39.1 (10.9↓) оноог тус тус өгчээ.
- Дээд түвшний ба дунд түвшний удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг харгалзан 35.7(26.8↓) ба 38.3(25.6↓) хэмээн өмнөх оноос ихээр буурсан үнэлгээ өгсөн байна.

6. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам нь мөн л ШБҮ хамгийн их бууралттай 10 байгууллагын нэг бөгөөд өмнөх оны 27-р эрэмбээс энэ онд 67 дугаар эрэмбэд жагссан байна. Бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг харвал ГШБҮ 7 оноогоор, БОҮ 24.2 оноогоор тус тус буурч ДШБҮ төдийлөн өөрчлөлтгүй байна. Тус байгууллага нь БОҮ-ний хамгийн их бууралттай байгууллага ба уг бүрэлдэхүүн үнэлгээний жагсаалтын сүүлээсээ хоёрт бичигдэж байна.

Хүснэгт 25. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ШБҮ, түүний үзүүлэлтүүдийн өөрчлөлт

	Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		74.7	64.7	-10
1	ГШБҮ	78.6	71.7	-7.0
1.1	Авлигын эрсдэлийн индекс	68.2	59.8	-8.4
	Ил тод байдал	62.7	54.2	-8.5
	Хариуцлагатай байдал	73.6	65.4	-8.3
1.2	Авлигын индекс	89.1	83.5	-5.5
	Авлигын талаарх төсөөлөл	74.4	63.9	-10.5
	Авлигын шууд тохиолдол	98.7	90.7	-8.0
	Авлигын шууд бус тохиолдол	94.1	96.1	1.9
2	ДШБҮ	75.9	76.1	0.3
2.1	Соёлын индекс	70.5	67	-3.5
	Албан бус хэм хэмжээ	78.1	75.2	-2.9
	Авлигын эсрэг тогтолцоо	63	58.9	-4.1
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	81.2	85.3	4.1
	Хүний нөөц	98.2	97.4	-0.8
	Төсвийн зарцуулалт	66.7	82.9	16.2
	Үүрэг даалгаврын шударга байдал	77	79.4	2.5
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	99	100	1.0
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	65	66.6	1.5
3	БОҮ	70.5	46.3	-24.2
	Авлигын талаарх төсөөлөл (БОҮ)	74.4	46.8	-27.6
	Авлигыг хянах механизм	53.4	36.8	-16.6
	Авлигын бодит тохиолдол	88	65.4	-22.6
	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	66.2	36	-30.2

Тус яамны ГШБҮ-ний үр дүнд авлигын эрсдэлийн индекс (8.4↓), авлигын индекс (5.5↓) гэсэн өөрчлөлтүүд нөлөөлжээ. Хүснэгт 25-оос харахад ил тод байдал ба хариуцлагатай байдлын дэд үзүүлэлт хоёулаа 8.4 орчим оноогоор буурсан байна. Үүнд:

- Хавсралт 7-с харахад ил тод байдлын хоёр асуулт 60-аас бага үнэлгээтэй, хариуцлагатай байдлын хоёр асуулт 70-аас доош үнэлгээтэй байна. Эдгээрээс үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдлын асуулт өмнөх оноос 18.3

оноогоор буурсан ба тус яамыг үнэлсэн 120 хүний 26% нь энэхүү ил тод байдалд санал нийлэхгүй болон огт санал нийлэхгүй гэж үзсэн байна.

- Авлигын төсөөллийн дэд үзүүлэлтэд хамаарах 6 асуултын үнэлгээ 61 – 66.8 -ийн хооронд, тэдгээрийн дундаж өөрчлөлт 10.5 оноо байна. Төрийн үйлчилгээ үзүүлэхдээ “бусдад хууль бусаар давуу байдал олгодог”, “бусдаас шан харамж авсан эсхүл өгсөн” зэрэг асуултуудад судалгаанд оролцогчдын харгалзан 16.7% болон 15% нь санал нийлнэ болон бүрэн нийлнэ гэж хариулсан байна.
- Авлигын шууд тохиолдлын дундаж үнэлгээ өмнөх оноос 8 оноогоор буурсан ч 90.7 гэсэн үнэлгээтэй байна. Тус дэд үзүүлэлтэд хамаарах гурван төрлийн авлигын шууд тохиолдлоос нэмэлт төлбөр өгсөн, авсан тохиолдол хамгийн их өөрчлөлттэй байна. Үүнд:
 - Нэмэлт төлбөр өгсөн байдал 93.3 (6.7↓) оноо, нэмэлт төлбөр өгсөн давтамж 68.6 (31.4↓), мөнгөн дүн 93.3 (6.7↓) зэрэг оноогоор үнэлсэн байна.
 - Шууд ба шууд бус байдлаар бэлэг өгөх, хандив-санхүүгийн туслалцаа өгсөн тохиолдлууд өөрчлөлт багатай хамаарх 6 асуултын үнэлгээ 90-ээс дээш үнэлгээтэй байна⁸.

Тус яамны ДШБҮ-ний дундаж нь бараг өөрчлөлтгүй боловч хамаарах 7 дэд үзүүлэлт өсөлт, бууралт харилцан адилгүй байна. Хавсралт 9-с харахад:

- Албан бус хэм хэмжээ дэд үзүүлэлтийн 6 асуултын үнэлгээ 67.3-92.2-ийн хооронд үнэлгээтэй байна. Эдгээрээс хамгийн бага үнэлгээтэй үзүүлэлтүүд нь албан хаагчид үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг, бусдад дарамт шахалт үзүүлдэг, ах дүү, танил талын нөлөөнд автдаг гэсэн зүйлс байна.
- Тус яамны албан хаагчид нь дотоодын авлигын эсрэг тогтолцоог дунджаар 59 оноогоор үнэлжээ. Үүнд, тус байгууллагын албан хаагчид нь мэдээлэгчийг хамгаалсан байдалд 54.9 (8.3↓), дотоод хяналтын механизмын бүрдэлд 56.7 (1.4↑) гэсэн онооны үнэлгээг өгсөн байна.
- Хүний нөөцийн шударга байдлын 5 асуултаас зөвхөн А10 буюу хүний нөөцтэй холбоотой шийдвэрт мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал түгээмэл эсэх асуулт 89 (2.2↓) гэсэн үнэлгээтэй бусад асуултууд бүгд бүрэн оноотой байна.
- Төсвийг зориулалтын бусаар зарцуулах явдал түгээмэл эсэхэд 70.7 (14↑) үнэлгээ өгсөн бол судалгаанд орсон 50 албан хаагчдаас 3 нь байгууллагад төсвийг зориулалтын бусаар зарцуулах явдал байна буюу өмнөх оны түвшинд байна. Зориулалтын бус зарцуулалтын давтамж 97.7 (74.7↑) буурсан боловч үнэ өртөгийн дүн 69.3 (4.1↑) гэж үзэж болохоор байна.
- Үүрэг даалгаврын шударга байдалд “байгууллагын удирдах алба хаагчдын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдол хэр түгээмэл байдаг вэ?” болон “байгууллагын удирдах алба хаагчид хууль бус үүрэг даалгавар өгөх явдал хэр түгээмэл вэ?” асуултуудад харгалзан 57.4 (9.7↓) ба 71.7 (3.8↓) оноог өгсөн байлаа.
- Авлига, шударга байдал зөрчигдөхийн эсрэг дээд ба дунд түвшний удирдлагын хүсэл эрмэлзэлд харгалзан 64.6 ба 64.6 онооны үнэлгээг тус тус өгсөн ба эдгээр нь өмнөх оноос өөрчлөлтгүй гэж үзэж болохоор байна.

⁸ А12-1 асуултаас бусад буюу тухайн асуулт нь 83.9 (16.1↓) гэсэн үнэлгээтэй

БОУ-ний 4 дэд үзүүлэлт бүгд хоёр оронтой тоогоор буурч 36-65-ийн хооронд үнэлгээтэй. Үүнд нөлөөлсөн нэгж асуултуудын үнэлгээ, өөрчлөлтийг Хавсралт 11-с харвал:

- Авлигын талаарх төсөөллийн 9 нэгж асуултуудын өөрчлөлт сөрөг 12.5 – 35.1-ийн хооронд буюу их дүнгээр нийтлэг буурсан. Бодлогод оролцогчдоос өгсөн дундаж үнэлгээ нь 39.5 – 55.3-ийн хооронд байгаа нь нэгж үзүүлэлтүүд бүгд хангалтгүй түвшинд байна. Эдгээрээс хамгийн бага үнэлгээтэй нь “тухайн байгууллагад авлига түгээмэл эсэх” 39.5 (31.6↓), “бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал” 42.2 (31.5↓), “бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал” 42.6 (34.7↓) зэрэг байна.
- Авлигыг хянах механизм дэд үзүүлэлтийн 3 асуултын үнэлгээ 33.9 – 39.1-ийн хооронд байна. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдалд нийт судалгаанд оролцсон 25 шинжээчдийн 6 нь санал нийлэхгүй болон огт нийлэхгүй, 13 нь мэдэхгүй гэж хариулснаар 37.5 оноо (17.9↓) өгсөн бол дотоод хяналтын механизмаар авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдалд 25 хүний 10 нь санал нийлэхгүй ба огт нийлэхгүй, 11 нь мэдэхгүй гэж хариулснаар 39.1 (22↓) оноог тус тус өгчээ.
- Авлигын бодит тохиолдол үзүүлэлтэд хамаарах хоёр асуулт харгалзан 69.2 (21.7↓) ба 61.5 (23.5↓) байна.
- Дээд түвшний ба дунд түвшний удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийн үнэлгээ маш их дүнгээр буурч харгалзан 36.7 (36.9↓), 35.3 (23.5↓) оноог тус тус үзүүлжээ.
- Тус яамны бодлогод оролцогчдын үнэлгээ нь 25 хүнийг хамарсан ба тухайн нэгж асуултад мэдэхгүй/хариулахаас татгалзсан хариултын тоо 6-13-ийн хооронд буюу харьцангуй их байна.

7. Баян-Өлгий аймгийн ЗДТГ

Баян-Өлгий аймгийн ЗДТГ өмнөх онд 61-р эрэмбээс энэ онд 66-р эрэмбэд орж ШБҮ нь 2.1 оноогоор буурч 65.2 гэсэн үнэлгээтэй байна. Бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг харвал ДШБҮ 6 оноогоор, БОУ 4 оноогоор тус тус буурч, ДШБҮ 3.9 оноогоор өссөн байна.

Хүснэгт 26. Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын ШБҮ, түүний үзүүлэлтүүдийн өөрчлөлт

	Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		67.3	65.2	-2.1
1	ГШБҮ	56.1	60.1	3.9
1.1	Авлигын эрсдэлийн индекс	49.0	52.5	3.5
	Ил тод байдал	44.6	52.8	8.2
	Хариуцлагатай байдал	53.5	52.2	-1.3
1.2	Авлигын индекс	63.2	67.6	4.4
	Авлигын талаарх төсөөлөл	56.8	50.8	-6.1
	Авлигын шууд тохиолдол	43.6	70.6	26.9
	Авлигын шууд бус тохиолдол	89.2	81.5	-7.8
2	ДШБҮ	78.3	72.3	-6.0
2.1	Соёлын индекс	67.4	66	-1.3
	Албан бус хэм хэмжээ	71.3	72	0.4
	Авлигын эсрэг тогтолцоо	63.5	60	-3.1
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	89.2	79	-10.7
	Хүний нөөц	97.4	96	-1.6
	Төсвийн зарцуулалт	89.0	84	-4.7
	Үүрэг даалгаврын шударга байдал	84.9	55	-30.0
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100.0	100	0.0
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	74.8	58	-17.0
3	БОУ	67.3	63.3	-4.0

Авлигын талаарх төсөөлөл (БОУ)	77.0	62.9	-14.1
Авлигыг хянах механизм	41.4	42.6	1.2
Авлигын бодит тохиолдол	100.0	84.5	-15.5
Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	51.0	63.1	12.2

Баян-Өлгий аймгийн ГШБҮ-ний үр дүнд авлигын эрсдэлийн индекс (3.5↑), авлигын индекс (4.4↑) гэсэн өөрчлөлтүүд нөлөөлжээ. Эцсийн дүнд эерэг өөрчлөлт гарах болсон нь авлигын шууд тохиолдлын өндөр өсөлт, ил тод байдлын өсөлтөөс тус тус хамаарч байна. Хавсралт 7-с харахад:

- Ил тод байдлын хоёр асуулт өмнөх оноос өсөж, харгалзан 53.9 ба 51.7 үнэлгээг харуулсан бол хариуцлагатай байдлын хоёр асуулт бага зэрэг буурч харгалзан 53.3 ба 51.1 гэсэн үнэлгээтэй тус тус байна. Тухайлбал, тус ЗДТГ-ыг үнэлсэн 180 хүний 17% нь төрийн үйлчилгээг үзүүлэхдээ хүчин чармайлт гаргасан байдалтай санал нийлэхгүй болон огт санал нийлэхгүй байна. 21% нь төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ёс зүйгүй үйлдэл гаргасан гэдэгтэй санал нийлнэ болон бүрэн санал нийлнэ гэж хариулжээ. Ил тод байдлын үзүүлэлтүүд өссөн ч үнэлгээний дүн хариуцлагатай байдлын адил сайжруулах шаардлагатай түвшинд байсаар байна.
- Авлигын төсөөллийн үзүүлэлтүүдийн дундаж нь 6.1 оноогоор буурч 50.8 гэсэн үр дүнтэй. Тус дэд үзүүлэлтэд хамаарах 6 асуултын үнэлгээ бүгд буурч 46.3 – 55.2-ийн хооронд буюу жигд доогуур үнэлгээтэй. Хамгийн бага үнэлгээ бүхий асуултууд нь “алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг” болон “бусдад хууль бусаар давуу байдал олгодог” зэрэг байна. Дурдсан хоёр асуултад нийт судалгаанд оролцсон 180 хүний харгалзан 33 ба 27 хувь нь санал нийлнэ болон бүрэн санал нийлнэ гэж хариулжээ. Авлига, ашиг сонирхлын шинжтэй үйлдлүүд гардаг талаарх төсөөлөл зүйл бүртээ бага үнэлгээтэй байгааг анхаарч ажиллах шаардлагатай.
- Авлигын шууд тохиолдлын дундаж үнэлгээ өмнөх оноос ихээр өсөж 70.6-д хүрсэн ба авлигын шинжтэй үйлдлийн давтамж, үнэ өртөг өмнөх оноос буурсан тохиолдлууд байснаар ийнхүү өсөлт үзүүлжээ. Тухайлбал, сүүлийн 12 сарын хугацаанд алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ дараах авлигын шинжтэй тохиолдлуудыг иргэд хэрхэн үнэлсэнийг харвал:
 - Нэмэлт төлбөр авсан байдал 92.2 (9.3↑) оноо, нэмэлт төлбөр өгсөн давтамж 72.1 (36.4↑), мөнгөн дүн 54 (4.5↑) зэрэг оноогоор үнэлсэн байна.
 - Шууд болон шууд бус байдлаар өгсөн байдлын үнэлгээ 2.9 оноогоор өсөж 91.0 үнэлгээтэй байна. Бэлэг өгсөн давтамжийн тоо өмнөх оноос бага гэж хариулсан буюу 35.5 (10.8↑) үнэлгээтэй, бэлэгний мөнгөн дүнгийн хэмжээ 86.7 (86.7↑) үнэлгээтэй тус тус байна. Тус аймгийн ЗДТГ өмнөх онд бэлэгний мөнгөн дүнгийн хэмжээний хувьд төрийн байгууллагууд дундаа хамгийн өндөр дүнг үзүүлж “0” үнэлгээг авч байсан байна.
 - Хандив, туслалцаа авсан байдалд 90.8 (7.5↑) оноо, түүний давтамжид 25.7 (25.7↑), мөнгөн дүнгийн хэмжээнд 87.2 (58.7↑) гэсэн үнэлгээ өгсөн. Энд мөн л өмнөх онд энэ төрлийн үйлдлийн давтамжаар тухайн байгууллага хамгийн өндөр тоо хэмжээтэй байснаар “0” гэсэн үнэлгээг авч байжээ.
 - Хэдийгээр авлигын шууд тохиолдлын үзүүлэлтүүд сайжирсан ч тохиолдол гарах явдал байсаар, түүний давтамж, мөнгөн дүнгүүд мөн л

өндөр хэвээр байгааг анхаарч шалтгааныг тодруулж ажиллах шаардлагатай.

- Авлигын шууд бус тохиолдол 7.8 оноогоор буурч 81.5-д хүрсэн буюу нийт 180 хүнээс 23 нь хүн шууд бус тохиолдол байсан гэж хариулжээ.

Тус аймгийн ЗДТГ-ын ДШБҮ нь 6 оноогоор буурч, ГШБҮ ба БОҮ-нээс харгалзан 20 ба 10 оноогоор илүү үнэлгээтэй байна. ДШБҮ-ний 7 дэд үзүүлэлтээс 5 нь буурч, хоёр нь өөрчлөлтгүй гэсэн үр дүнтэй. Голлох нөлөө үзүүлсэн дэд үзүүлэлт нь үүрэг даалгаврын шударга байдал 55 (33.0↓) байна. Хавсралт 9-с харахад:

- Албан бус хэм хэмжээний 6 асуулт өсөлт, бууралт харилцан адилгүй байна. Үнэлгээ нь 62.5 – 90-ийн хооронд, хамгийн бага үнэлгээ нь “албан хаагчид үүргээ гүйцэтгэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг”, “бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг” гэсэн хоёр асуулт байгаа нь ГШБҮ-ний авлигын төсөөллийн үр дүнтэй зарим талаар нийцтэй байна.
- Авлигын эсрэг тогтолцоонд хамаарах 3 асуулт өмнөх оноос бага зэргийн бууралтуудтай, 54.8 – 71.2 гэсэн үнэлгээтэй. Албан хаагчид өөрсдийн ажиллаж буй ЗДТГ авлигыг хянах дотоод механизм бүрдсэн, зөрчлийг мэдээлэгчийн бүрэн хамгаалсан зэрэг үзүүлэлтүүдэд төдийлөн итгэлгүй байна. Тухайлбал, судалгаа өгсөн 20 албан хаагчаас харгалзан 9 ба 14 нь өмнө дурдсан үзүүлэлтүүдтэй санал нийлэхгүй ба огт санал нийлэхгүй гэж хариулжээ.
- Хүний нөөцийн шударга байдлын 5 асуултаас зөвхөн А10 буюу хүний нөөцтэй холбоотой шийдвэрт мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал түгээмэл эсэх асуулт 82.3 (4.7↓) гэсэн үнэлгээтэй бусад асуултууд бүгд бүрэн оноотой байна.
- Төсвийн зарцуулалт дэд үзүүлэлтээс төсвийг зориулалтын бусаар зарцуулах явдал түгээмэл эсэхэд 64.8 (15.0↓) оноог албан хаагчид өгсөн байгаа бол сүүлийн 12 сарын хугацаанд ийнхүү зориулалтын бусаар зарцуулсан тохиолдол бий гэсэн хариултын тоо буурсан ч түүний давтамжийн тоо хэмжээ өндөр гэж үзсэн учир 75.6 (14.0↓) гэсэн үнэлгээг авчээ.
- Үүрэг даалгаврын шударга байдлыг илэрхийлэх 4 асуулт бүгд бууралттай ба өөрчлөлтийн дундаж нь -33.0 байна. Үүнийг задалбал:
 - Удирдах албан тушаалтан өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх явдалд 57.8 (16.0↓), удирдах албан тушаалтан хууль бус үүрэг даалгавар өгөх нь түгээмэл эсэхэд 59.5 (19.0↓) гэсэн үнэлгээтэй
 - Сүүлийн 12 сарын хугацаанд удирдах албан тушаалтан танд хууль бус үүрэг даалгавар өгсөн эсэх, тийм бол ямар давтамжтай талаар асуултуудад харгалзан 78.1 (12.0↓), 24.1 (73.0↓) гэсэн оноог авсан байна.
- Авлига, шударга байдал зөрчигдөхийн эсрэг дээд ба дунд түвшний удирдлагын хүсэл эрмэлзэлд харгалзан 56.5 ба 58.3 оноог тус тус өгсөн нь өмнөх оноос харгалзан 18 ба 13 оноогоор буурсан. Авлигатай тэмцэх үйл ажиллагаа энэ онд өмнөх оноос буурсан гэсэн хариулт олон буюу 58.8 (21.0↓) -д хүрч үнэлгээ ихээр буурсан байна.

БОҮ-ний 4 дэд үзүүлэлтээс хоёр нь өсөлттэй, хоёр нь бууралттай ба тэрхүү дэд үзүүлэлтүүд нь хоёр оронтой тоогоор сөрөг өөрчлөлттэй байгаа нь нийт БОҮ-г бууруулахад хүргэжээ. Хавсралт 11-с харвал:

- Авлигын талаарх төсөөллийн 9 нэгж асуултын 8 нь 3.7 – 32.7-ийн хооронд сөрөг өөрчлөлттэй. Бодлогод оролцогчид тухайн ЗДТГ-ын албан хаагчдыг албан

үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шаардах явдал их байна гэж үзсэнээр 42.3 (32.7↓) гэсэн үнэлгээг, авлига тухайн байгууллагад түгээмэл гэж үзсэнээр 45.8 (25.3↓) гэсэн үнэлгээг өгсөн байх жишээтэй.

- Тус ЗДТГ нь дотоод хяналтаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдалд 34.1 (4.9↑), зөрчлийг мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдалд 12.5 (19.6↓) оноог тус тус өгсөн байна.
- Авлигын бодит тохиолдол үзүүлэлтэд хамаарах хоёр асуулт харгалзан 88.9 (ба 85.7 байна).
- Дээд түвшний ба дунд түвшний удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг энэ онд өмнөх оноос өндрөөр үнэлсэн ч хамаарах хоёр асуулт харгалзан 56.3 (13.1↑) ба 52.1 (8.9↑) гэсэн үнэлгээтэй байна.

8. Архангай аймгийн ЗДТГ

Тус аймгийн ЗДТГ-ын ШБҮ энэ онд 4.8 оноогоор буурахад өмнөх оноос 20 эрэмбээр ухарч байна. Өөрчлөлтийн гол үүсвэр нь БОҮ-ний 17.4 онооны бууралт байна. ГШБҮ өөрчлөлтгүй ба ДШБҮ нь бага хэмжээний өсөлттэй. Тус ЗДТГ нь БОҮ-ээр хамгийн их бууралттай бөгөөд хамгийн бага үнэлгээтэй байгууллагуудын нэг байна.

Хүснэгт 27. Архангай аймгийн ЗДТГ-ын ШБҮ, түүний үзүүлэлтүүдийн өөрчлөлт

	Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		71.2	66.4	-4.8
1	ГШБҮ	60.5	60.4	-0.1
1.1	Авлигын эрсдэлийн индекс	53.3	51.1	-2.1
	Ил тод байдал	54.3	49.4	-4.9
	Хариуцлагатай байдал	52.3	52.8	0.6
1.2	Авлигын индекс	67.7	69.7	2.0
	Авлигын талаарх төсөөлөл	45.7	53.8	8.2
	Авлигын шууд тохиолдол	90.9	76.6	-14.3
	Авлигын шууд бус тохиолдол	66.5	78.6	12.1
2	ДШБҮ	84.5	87.6	3.1
2.1	Соёлын индекс	76.3	81	5.1
	Албан бус хэм хэмжээ	85.2	88	2.8
	Авлигын эсрэг тогтолцоо	67.4	75	7.3
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	92.7	94	1.2
	Хүний нөөц	97.1	99	2.3
	Төсвийн зарцуулалт	98.3	99	0.8
	Үүрэг даалгаврын шударга байдал	95.1	93	-1.9
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100.0	100	0.0
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	72.7	77	4.8
3	БОҮ	68.6	51.2	-17.4
	Авлигын талаарх төсөөлөл (БОҮ)	62.0	53.7	-8.3
	Авлигыг хянах механизм	55.8	31.6	-24.2
	Авлигын бодит тохиолдол	100.0	68.5	-31.5
	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	56.8	51.3	-5.5

Архангай аймгийн ЗДТГ-ын авлигын эрсдэлийн индекс ба авлигын индексийн өөрчлөлт харилцан нэгнээ нөхөх байдлаар өөрчлөгдсөн учир ГШБҮ-д өөрчлөлт харагдаагүй. Гэхдээ дэд үзүүлэлтүүд дээр өсөлт, бууралт харилцан адилгүй байна. Ил тод байдал, авлигын шууд бус байдал өмнөх оноос буурсан бол авлигын талаарх төсөөлөл, авлигын шууд бус тохиолдлын үнэлгээнүүд сайжирсан байна. Хавсралт 7-с харвал:

- Ил тод байдлын хоёр асуулт хоёул буурч 49.4 үнэлгээнд хүрсэн, хариуцлагатай байдлын асуултууд харгалзан 51.6 ба 54.1 гэсэн үнэлгээтэй байна. Ил тод

байдлын асуултуудад тус газрыг үнэлсэн 180 хүний 28.3% нь хүний нөөцийн ил тод байдалтай, 26.1% нь төсөв санхүүгийн ил тод байдлыг хангалттай гэдэгтэй санал нийлэхгүй болон огт санал нийлэхгүй байна. Ил тод ба хариуцлагатай байдлыг сайжруулах шаардлага байсаар байна.

- Авлигын төсөөллийн дэд үзүүлэлтэд хамаарах 6 асуултын үнэлгээ бүгд сайжирсан боловч 51.2 – 58.2-ийн хооронд үнэлүүлсэн байна. Хамгийн бага үнэлгээ бүхий асуултууд нь албан үүргээ гүйцэтгэхдээ “бусдад хууль бусаар давуу байдал олгох байдал” болон “бусдаас шан харамж авсан, эсхүл өгсөн байдал” зэрэг байна. Авлига, ашиг сонирхлын шинжтэй үйлдлүүд гардаг талаарх төсөөлөл зүйл бүртээ бага үнэлгээтэй байгааг анхаарч ажиллах шаардлагатай.
- Авлигын шууд тохиолдлын дундаж үнэлгээ өмнөх оноос 14.3 оноогоор буурч 76.6-д хүрсэн ба авлигын шинжтэй үйлдлийн давтамж, үнэ өртөг өмнөх оноос өссөн тохиолдлууд байснаар ийнхүү үнэлгээ муудсан байна. Тухайлбал, сүүлийн 12 сарын хугацаанд алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ дараах авлигын шинжтэй тохиолдлуудыг иргэд хэрхэн үнэлсэнийг харвал:
 - Нэмэлт төлбөр авсан байдал 85.3 (5.3↓) оноо, нэмэлт төлбөр өгсөн давтамж 46.5 (22.1↓), мөнгөн дүн 88.3 (9.3↓) зэрэг оноогоор үнэлсэн байна.
 - Шууд болон шууд бус байдлаар өгсөн байдлын үнэлгээ 8.2 оноогоор буурч 86.3 үнэлгээтэй байна. Бэлэг өгсөн давтамжийн тоо өмнөх оноос бага гэж хариулсан буюу 36.6 (33.3↓) үнэлгээтэй, бэлэгний мөнгөн дүнгийн хэмжээ 87.8 (9.5↓) үнэлгээтэй тус тус байна.
 - Хандив, туслалцаа авсан байдалд 91.1 (8.9↓) оноо, түүний давтамжид 75.2 (24.8↓), мөнгөн дүнгийн хэмжээнд 92.5 (7.5↓) гэсэн үнэлгээ өгсөн.
 - Хэдийгээр авлигын шууд тохиолдлын үзүүлэлтүүд бүгд өмнөх оноос буурч давтамж, үнийн дүнгийн хувьд нэмэгдэх хандлага харуулсан байгааг анхаарах шаардлагатай.

Тус аймгийн ЗДТГ-ын ДШБҮ 3.1 өсөлттэйгөөр 87.6 оноотой, ГШБҮ ба БОҮ-нээс харгалзан 27 ба 36 оноогоор илүү үнэлгээтэй байна. ДШБҮ-ний 7 дэд үзүүлэлтээс 4 нь өсөлттэй, хоёр нь өөрчлөлтгүй гэсэн үр дүнтэй. Аймгууд дундаа ДШБҮ хамгийн өндөр 5 аймгийн нэг боловч ШБҮ хамгийн бага байгаа нь онцлогтой буюу дотоод ба гадаад холбоотой талуудын төсөөлөл, туршлага их зөрүүтэй байна. Хавсралт 9-с харахад:

- Албан бус хэм хэмжээний 6 асуулт бүгд өссөн, үнэлгээ харьцангуй сайн буюу 80 – 98.1-ийн хооронд байна.
- Авлигын эсрэг тогтолцоонд хамаарах 3 асуулт өмнөх оноос мөн л сайжирсан үнэлгээтэй. Харин үнэлгээний дүнгийн хувьд 73 – 77.3 байгаа нь өмнөх байгууллагуудтай харьцуулахад өндөр ч цаашид сайжруулах хэрэгцээтэй байна.
- Хүний нөөцийн шударга байдлын 5 асуултаас зөвхөн А10 буюу хүний нөөцтэй холбоотой шийдвэрт мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал түгээмэл эсэх асуулт 97.3 (11.6↑) л өөрчлөлттэй бусад нь өмнөх оны түвшинд хэвээр буюу 100 гэсэн үнэлгээтэй.
- Төсвийн зарцуулалт дэд үзүүлэлтийн асуултууд 96.4 – 100-ийн хооронд үнэлгээтэй. Гадаад орчин дахь авлигатай тэмцэх явдал мөн үнэлгээ бүтэн оноотой.
- Үүрэг даалгаврын шударга байдлыг илэрхийлэх асуултуудаас удирдах албан тушаалтан өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх явдалд 79.6 (5.9↓), удирдах

албан тушаалтан хууль бус үүрэг даалгавар өгөх нь түгээмэл эсэхэд 93.1 (1.9↓) гэсэн үнэлгээг албан хаагчид өгсөн байна. Сүүлийн 12 сарын хугацаанд удирдах албан тушаалтан танд хууль бус үүрэг даалгавар өгсөн тохиолдол байхгүй гэж хариулжээ.

- Авлига, шударга байдал зөрчигдөхийн эсрэг дээд ба дунд түвшний удирдлагын хүсэл эрмэлзэлд харгалзан 77.9 ба 76 оноог тус тус өгсөн байна.

БОУ-ний 4 дэд үзүүлэлт бүгд бууралттай. Үүнээс авлигыг хянах механизм ба авлигын бодит тохиолдлын үнэлгээ буурсан явдал нь БОУ буурах гол үүсвэр болжээ. Хавсралт 11-с харвал:

- Авлигын талаарх төсөөллийн 9 нэгж асуултын 8 нь 3.3 – 13.3-ийн хооронд сөрөг өөрчлөлттэй ба 35 – 65-ийн хооронд үнэлгээтэй. Бодлогод оролцогчид тухайн ЗДТГ-ын албан хаагчдыг албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шаардах явдал их байна гэж үзсэнээр 35.0 (5.0↑) гэсэн үнэлгээг, авлига тухайн байгууллагад түгээмэл гэж үзсэнээр 41.7 (13.3↓) гэсэн үнэлгээг өгсөн байх жишээтэй.
- Мөн судалгаанд оролцогчид нь уг ЗДТГ-ын дотоод хяналтаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдалд 21.2 (36.3↓), зөрчлийг мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдалд 30.8 (16.7↓), шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдалд 42.9 (19.6↓), оноог тус тус өгсөн байна.
- Авлигын бодит тохиолдол үзүүлэлтэд хамаарах хоёр асуулт их дүнгээр буурч 73.3 (26.7↓) болон 63.6 (36.4 ↓) хэмээн үнэлэгджээ. Тухайлбал, шинжээч 15 хүн судалгаанд орсноос дурдсан хоёр асуулт тус бүрд 4 ба 4 нь бодит тохиолдол гарсан гэж хариулжээ.
- Дээд түвшний ба дунд түвшний удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг энэ онд харгалзан 42.5 (17.5↓) ба 60 (6.4↑) гэсэн үнэлгээтэй байна.

9. Баянхонгор аймгийн ЗДТГ

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ШБҮ 5.1 оноогоор өсөж, өмнөх оноос 1 байр урагшилсан байна. Бүрэлдэхүүний дундаж үнэлгээний үр дүнгээс харахад харахад ГШБҮ 0.2, ДШБҮ -4.0, БОУ 18.8 гэсэн өөрчлөлтүүдийг үзүүлжээ.

Хүснэгт 28. Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ШБҮ, түүний үзүүлэлтүүдийн өөрчлөлт

	Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		62.3	67.4	5.1
1	ГШБҮ	53.1	53.4	0.2
1.1	Авлигын эрсдэлийн индекс	49.0	47.7	-1.3
	Ил тод байдал	51.3	42.5	-8.7
	Хариуцлагатай байдал	46.8	52.9	6.2
1.2	Авлигын индекс	57.2	59.0	1.7
	Авлигын талаарх төсөөлөл	45.2	46.6	1.4
	Авлигын шууд тохиолдол	58.7	61.5	2.8
	Авлигын шууд бус тохиолдол	67.8	68.8	1.0
2	ДШБҮ	89.1	85.2	-4.0
2.1	Соёлын индекс	86.2	78	-8.6
	Албан бус хэм хэмжээ	89.3	85	-4.6
	Авлигын эсрэг тогтолцоо	83.0	70	-12.7
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	92.1	93	0.7
	Хүний нөөц	93.6	99	5.7
	Төсвийн зарцуулалт	90.6	96	5.4

	Үүрэг даалгаврын шударга байдал	92.3	92	-0.3
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	96.7	100	3.3
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	87.3	77	-10.6
3	БОУ	44.8	63.6	18.8
	Авлигын талаарх төсөөлөл (БОУ)	37.5	65.3	27.8
	Авлигыг хянах механизм	38.9	43.6	4.7
	Авлигын бодит тохиолдол	66.1	72.4	6.3
	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	36.8	73.0	36.2

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын авлигын эрсдэлийн индекс ба авлигын индексийн өөрчлөлт харилцан нэгнээ нөхөх байдлаар өөрчлөгдсөн учир ГШБҮ-д өөрчлөлт харагдаагүй. Харин авлигын эрсдэлийн индекс доторх ил тод байдал ба хариуцлагатай байдлын үзүүлэлтүүдэд эерэг ба сөрөг мэдэгдэхүйц үнэлгээний өөрчлөлт гарсан бол авлигын индексийн хувьд дэд үзүүлэлтүүд бага хэмжээний сайжралттай байна. Хавсралт 7-с харвал:

- Ил тод байдлын хоёр асуулт, тэр дундаа “төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдал”-ын үнэлгээ 16.5 оноогоор буурч 40.9 үнэлгээтэй байна. Үүнд, тус ЗДТГ-ын талаар үнэлгээний судалгаанд орсон 180 хүний 44% нь ил тод байдалтай санал нийлэхгүй болон огт санал нийлэхгүй гэж хариулжээ.
- Харин хариуцлагатай байдлын хоёр асуулт өмнөх оноос өссөн ч 51.3 ба 54.6 гэсэн үнэлгээтэй байна. Хариуцлагатай байдлын үзүүлэлтүүд тодорхой хэмжээгээр өссөн ч ил тод байдлын адил сайжруулах шаардлагатай түвшинд байсаар байна.
- Авлигын төсөөллийн 6 асуултуудын үнэлгээнд өсөлт, бууралт аль аль нь байгаа ба дундаж өөрчлөлт 1.4 оноо. Харин үнэлгээний дүнгийн хувьд 40.4 – 58.9-ийн хооронд ба 45-аас доош үнэлгээтэй 4 асуулт байна. Хамгийн бага үнэлгээ бүхий асуултууд нь “алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг” болон “бусдад хууль бусаар давуу байдал олгодог” зэрэг байна. Дурдсан хоёр асуултад нийт судалгаанд оролцсон 180 хүний харгалзан 44.4 ба 43.3 хувь нь санал нийлнэ болон бүрэн санал нийлнэ гэж хариулжээ. Авлига, ашиг сонирхлын шинжтэй үйлдлүүд гардаг талаарх төсөөлөл зүйл бүртээ бага үнэлгээтэй байгааг анхаарч ажиллах шаардлагатай.
- Авлигын шууд тохиолдлын дундаж үнэлгээ багахан өөрчлөлттэй боловч түүнд хамаарах авлигын шинжтэй үйлдлүүдийн хувьд өндөр дүнгээр өссөн ба буурсан савлагаа их байна. Тухайлбал, сүүлийн 12 сарын хугацаанд алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ дараах авлигын шинжтэй тохиолдлуудыг иргэд хэрхэн үнэлсэнийг харвал:
 - Нэмэлт төлбөр авсан байдал 80.9 (7.3↓) оноо, нэмэлт төлбөр өгсөн давтамж 16.3 (37.5↓), мөнгөн дүн 76.2 (19.1↓) зэрэг оноогоор үнэлсэн байна.
 - Шууд болон шууд бус байдлаар бэлэг өгсөн байдлын үнэлгээ 86.4 (1.1↑) үнэлгээтэй байна. Бэлэг өгсөн давтамжийн тоо өмнөх оноос бага гэж хариулсан буюу 37.6 (16.1↑) үнэлгээтэй, бэлэгний мөнгөн дүнгийн хэмжээ 88.3 (25.4↑) үнэлгээтэй тус тус байна.
 - Хандив, туслалцаа өгсөн байдалд 87.2 (2.5↑) оноо, түүний давтамжид 0.0 (32.3↓), мөнгөн дүнгийн хэмжээнд 80.3 (76.0↑) гэсэн үнэлгээ өгсөн. Энэ онд хандив, туслалцаа өгсөн давтамжаар Баянхонгор аймгийн ЗДТГ хамгийн өндөр байсны улмаас 0 оноог авсан байна.

- Авлигын шууд тохиолдлын давтамжийн тоо өндөр байгааг анхаарч шалтгааныг тодруулж ажиллах шаардлагатай.
- Авлигын шууд бус тохиолдолд өөрчлөлт бага, 68.8 үнэлгээтэй буюу нийт 180 хүнээс 180 хүнээс 39 нь хүн шууд бус тохиолдол байсан гэж хариулжээ.

Тус аймгийн ЗДТГ-ын ДШБҮ нь 4 оноогоор буурч, ГШБҮ ба БОҮ-нээс харгалзан 32 ба 22 оноогоор илүү үнэлгээтэй байна. ДШБҮ-ний 7 дэд үзүүлэлтээс 3 нь буурч, 3 нь өссөн үр дүнтэй. Хавсралт 9-с харахад:

- Албан бус хэм хэмжээний 6 асуултын 4 нь бууралттай, үнэлгээ нь 74 – 97.7-ийн хооронд, хамгийн бага үнэлгээ нь албан хаагчид үүргээ гүйцэтгэхдээ “ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг”, “хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг” гэсэн хоёр асуулт байна.
- Авлигын эсрэг тогтолцоонд хамаарах 3 асуултын хоёр нь өмнөх оноос их хэмжээгээр бууралттай. Эдгээр нь “зөрчил гаргасан албан хаагчдад хариуцлага хүлээлгэдэг байдал” 67.9 (21↓), “авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрэлдсэн байдал” 69.6 (16.0↓) гэсэн асуултууд байна.
- Хүний нөөцийн шударга байдлын 5 асуултууд энэ онд бүгд өсөлттэй 4 нь 100 үнэлгээтэй бол үлдсэн асуулт нь 96.7 гэсэн үнэлгээнд хүрч сайжирсан байна.
- Төсвийн зарцуулалт дэд үзүүлэлтийн асуултууд бүгд өсөлттэй ба 89.1 – 99.8 хооронд үнэлгээтэй болно.
- Үүрэг даалгаврын шударга байдлыг илэрхийлэх 4 асуултаас хоёр нь бууралттай ба үлдсэн хоёр нь сайжирч 100 үнэлгээнд хүрсэн байна. Удирдах албан тушаалтан өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх явдалд 79.0 (2.9↓), удирдах албан тушаалтан хууль бус үүрэг даалгавар өгөх нь түгээмэл эсэхэд 88.9 (4.4↓) гэсэн үнэлгээг албан хаагчид өгчээ.
- Авлига, шударга байдал зөрчигдөхийн эсрэг дээд ба дунд түвшний удирдлагын хүсэл эрмэлзэлд харгалзан 74 ба 76 оноог тус тус өгсөн нь өмнөх оноос харгалзан 14 ба 9.2 оноогоор буурсан.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын БОҮ-ний 4 дэд үзүүлэлт бүгд өсөлттэй, үүнээс авлигын талаарх төсөөлөл ба удирдлагын авлигатай тэмцэх хүсэл үзүүлэлтүүд их дүнгээр сайжирсан нь БОҮ-ний өөрчлөлтийн гол үүсвэр болжээ. Хавсралт 11-с харвал:

- Авлигын талаарх төсөөллийн 9 нэгж асуултууд 17.9 – 36.3-ийн хооронд эерэг өөрчлөлттэй буюу их дүнгээр огцом өсөлттэй байна. Асуултуудын үнэлгээ 55 – 75-ийн хооронд ба 60-аас доош дүнтэй 4 асуулт байна. Бодлогод оролцогчид тухайн ЗДТГ-ын албан хаагчдыг албан үүргээ гүйцэтгэхдээ нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал 56.3 (17.9↑) гэсэн үнэлгээг, авлига тухайн байгууллагад түгээмэл гэж үзсэнээр 55.0 (31.7↑) гэсэн үнэлгээг тус тус өгсөн байх жишээтэй.
- Тус ЗДТГ нь дотоод хяналтаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдалд 42.3 (14.0↑), зөрчлийг мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдалд 36.4 (0.2↓) оноог тус тус өгсөн байна. Энэ асуултад 15 оролцогчийн 5 нь санал нийлэхгүй, санал огт нийлэхгүй хэмээн хариулж, 4 нь мэдэхгүй/хариулахаас татгалзах сонголтыг тус тус хийсэн байна.
- Авлигын бодит тохиолдол үзүүлэлтэд хамаарах хоёр асуулт харгалзан 71.4 (3.6↓) ба 73.3 16.2↑ байна.

- Дээд ба дунд түвшний удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг энэ онд өмнөх оноос өндрөөр үнэлсэн ба хамаарах хоёр асуулт харгалзан 73.1 (35.6↑) ба 72.9 (36.8↑) гэсэн үнэлгээтэй байна.

10. Дархан-Уул аймгийн ЗДТГ

Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын ШБҮ өмнөх оноос 1.2 оноогоор буурснаар 55-р байрнаас энэ онд 63 дахь эрэмбэд бичигдэж байна. ГШБҮ нь 15.8 оноогоор буурч, ДШБҮ ба БОҮ харгалзан 6.7 ба 5.3-аар өссөн нь нийт ШБҮ-ний өөрчлөлтийн бүрэлдэхүүн болж байна. Уг байгууллага нь энэ онд ГБШҮ хамгийн ихээр буурсан 5 байгууллагын нэг болсон байна.

Хүснэгт 29. Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын ШБҮ, түүний үзүүлэлтүүдийн өөрчлөлт

	Индекс, дэд үзүүлэлтүүд	2024	2025	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		68.9	67.7	-1.2
1	ГШБҮ	69.6	53.9	-15.8
1.1	Авлигын эрсдэлийн индекс	61.9	54.5	-7.4
	Ил тод байдал	57.2	49.5	-7.7
	Хариуцлагатай байдал	66.6	59.6	-7.0
1.2	Авлигын индекс	77.4	53.2	-24.2
	Авлигын талаарх төсөөлөл	66.4	57.7	-8.7
	Авлигын шууд тохиолдол	79.4	61.3	-18.2
	Авлигын шууд бус тохиолдол	86.3	40.7	-45.6
2	ДШБҮ	80.8	87.5	6.7
2.1	Соёлын индекс	71.8	81	9.4
	Албан бус хэм хэмжээ	82.2	85	2.6
	Авлигын эсрэг тогтолцоо	61.3	78	16.2
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	89.9	94	4.0
	Хүний нөөц	99.1	99	-0.3
	Төсвийн зарцуулалт	97.6	99	1.3
	Үүрэг даалгаврын шударга байдал	87.0	93	5.6
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	95.0	100	5.0
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	70.6	79	8.3
3	БОҮ	56.4	61.7	5.3
	Авлигын талаарх төсөөлөл (БОҮ)	55.9	61.2	5.3
	Авлигыг хянах механизм	42.3	41.7	-0.6
	Авлигын бодит тохиолдол	75.6	95.5	19.8
	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	51.8	48.3	-3.5

Дархан-Уул аймгийн ГШБҮ-ний үр дүнд авлигын эрсдэлийн индекс (7.4↓), авлигын индекс (24.2↓) гэсэн өөрчлөлтүүд нөлөөлжээ. Дэд үзүүлэлтүүдээс хамгийн их өөрчлөлттэй авлигын шууд ба шууд бус тохиолдол ШБҮ-г буурах гол үүсвэр болсон. Хавсралт 7-с харахад:

- Ил тод байдлын хоёр асуулт аль аль нь буурч 49.3 ба 49.7 үнэлгээг тус тус үзүүлсэн байна. Хариуцлагатай байдлын асуултууд ч мөн буурч харгалзан 57.0 ба 62.2 гэсэн үнэлгээтэй тус тус байна. Ил тод байдлын асуултуудад тус газрыг үнэлсэн 180 хүний 37% нь хүний нөөцийн ил тод байдалтай, 28.3% нь төсөв санхүүгийн ил тод байдлыг хангалттай гэдэгтэй санал нийлэхгүй болон огт санал нийлэхгүй байна.
- Авлигын төсөөллийн дэд үзүүлэлтэд хамаарах 6 асуултын үнэлгээ бүгд буурч 51 – 64.8-ийн хооронд үнэлгээтэй ба эдгээрээс дөрөв нь 60-аас доош дүнтэй байна. Хамгийн бага үнэлгээ бүхий асуултууд нь алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ “ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг” болон “бусдад хууль бусаар давуу байдал олгодог” зэрэг байна. Дурдсан хоёр асуултад нийт судалгаанд оролцсон 180 хүний харгалзан 31 ба 34 хувь нь санал нийлнэ болон бүрэн санал нийлнэ гэж хариулжээ.
- Авлигын шууд тохиолдлын дундаж үнэлгээ өмнөх оноос 18.2 оноогоор буурсан. Сүүлийн 12 сарын хугацаанд алба хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэх үеийн дараах авлигын шинжтэй тохиолдлуудыг иргэд хэрхэн үнэлсэнийг харвал:
 - Нэмэлт төлбөр авсан байдал 89.3 (3.7↑) оноо, нэмэлт төлбөр өгсөн давтамж 48.8 (14.0↑), мөнгөн дүн 76.7 (18.8↓) зэрэг оноогоор үнэлсэн байна.
 - Шууд болон шууд бус байдлаар бэлэг өгсөн байдлын үнэлгээ 2.9 оноогоор буурч 89.9 үнэлгээтэй байна. Бэлэг өгсөн давтамжийн тоо өмнөх

оноос бага гэж хариулсан буюу 4.3 (57.0↓) үнэлгээтэй, бэлэгний мөнгөн дүнгийн хэмжээ 50.8 (44.8↓) үнэлгээтэй тус тус байна.

- Хандив, туслалцаа авсан байдалд 92.1 (1.9↑) оноо, түүний давтамжид 45.0 (24.4↓), мөнгөн дүнгийн хэмжээнд 54.3 (35.4↓) гэсэн үнэлгээ өгсөн.
- Хэдийгээр авлигын шууд тохиолдлын давтамж, үнийн дүнгийн үзүүлэлтүүд нэг бол их дүнгээр буурсан эсвэл хангалтгүй үнэлгээтэй байгааг анхаарч шалтгааныг тодруулж ажиллах шаардлагатай.
- Авлигын шууд бус тохиолдол 45.6 оноогоор буурч дөнгөж 40.7 гэсэн үнэлгээнд хүрсэн байна. Үүнд, судалгаанд хамарсан нийт 180 хүнээс 86 хүн шууд бус тохиолдол байсан гэж хариулсан нь нөлөөлжээ.

Тус аймгийн ЗДТГ-ын ДШБҮ нь 6.7 оноогоор өссөн ба ГШБҮ ба БОҮ-нээс харгалзан 34 ба 26 орчим оноогоор илүү үнэлгээтэй байна. Хавсралт 9-с харахад:

- Албан бус хэм хэмжээний 6 асуулт бүгд өссөн, үнэлгээ харьцангуй сайн буюу 78.3 – 94.0-ийн хооронд байна. Хамгийн бага үнэлгээтэй асуулт нь албан хаагч үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг эсэх гэсэн асуулт байна.
- Авлигын эсрэг тогтолцоонд хамаарах 3 асуулт өмнөх оноос өндөр дүнгээр сайжирсан үнэлгээтэй. Харин үнэлгээний дүнгийн хувьд 73.1 – 80 байгаа нь өмнөх байгууллагуудтай харьцуулахад өндөр ч цаашид сайжруулах хэрэгцээтэй байна.
- Хүний нөөцийн шударга байдлын 5 асуултаас зөвхөн А10 буюу хүний нөөцтэй холбоотой шийдвэрт мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал түгээмэл эсэх асуулт 93.8 (1.6↓) л өөрчлөлттэй бусад нь өмнөх оны түвшинд хэвээр буюу 100 гэсэн үнэлгээтэй.
- Төсвийн зарцуулалт дэд үзүүлэлтийн асуултууд 95.4 – 100-ийн хооронд үнэлгээтэй. Гадаад орчин дахь авлигатай тэмцэх явдал мөн үнэлгээ бүтэн оноотой.
- Үүрэг даалгаврын шударга байдлыг илэрхийлэх асуултуудаас удирдах албан тушаалтан өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх явдалд 79.6 (4.6↑), удирдах албан тушаалтан хууль бус үүрэг даалгавар өгөх нь түгээмэл эсэхэд 90.8 (8.7↑) гэсэн үнэлгээг албан хаагчид өгсөн байна. Сүүлийн 12 сарын хугацаанд удирдах албан тушаалтан танд хууль бус үүрэг даалгавар өгсөн тохиолдол байхгүй гэж хариулжээ.
- Авлига, шударга байдал зөрчигдөхийн эсрэг дээд ба дунд түвшний удирдлагын хүсэл эрмэлзэлд харгалзан 80.2 (4.2↑) ба 79.5 (9.5↑) оноог тус тус өгсөн байна.

Дархан-Уул аймгийн БОҮ-ний 4 дэд үзүүлэлтийн дундаж өөрчлөлт эерэг 5.3 оноотой. Үүнээс 2 үзүүлэлт өсөлттэй, 1 үзүүлэлт бууралттай, үлдсэн нь төдийлөн өөрчлөлтгүй байна.

Хавсралт 11-с нэгж асуултуудын үнэлгээ ба өөрчлөлтийг харвал:

- Авлигын талаарх төсөөллийн 9 нэгж асуултын 6 нь 2.6 – 34.3-ийн хооронд эерэг өөрчлөлттэй. Үлдсэн гурав нь 2.3 – 19.6-ийн хооронд сөрөг өөрчлөлттэй байна. Асуултуудын онооны хувьд 31.8 – 78.6-ийн хооронд буюу нэг бүлгийн 9 асуулт үнэлгээ ба өөрчлөлтийн хувьд хэлбэлзэл өндөр байна. Бодлогод оролцогчид тухайн ЗДТГ-ын албан хаагчдыг албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шаардах явдал их байна гэж үзсэнээр 31.8 (2.3↓)

гэсэн үнэлгээг, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах эсхүл бусдад дамжуулах явдалд 56.7 (6.7↑) гэсэн үнэлгээг өгсөн байх жишээтэй.

- Бодлогод оролцогчид цаашлаад тус ЗДТГ-ын дотоод хяналтаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдалд 33.3 (10.4↑), зөрчлийг мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдалд 40.0 (13.8↓) оноог тус тус өгсөн байна.
- Авлигын бодит тохиолдол үзүүлэлтэд хамаарах хоёр асуулт харгалзан 100 (15.4↑) ба 90.9 (24.2↑) байна.
- Дээд ба дунд түвшний удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг хангалтгүй буюу харгалзан 50 (3.6↑) ба 46.7 (10.5↓) хэмээн үнэлсэн байна.


БҮЛЭГ III. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Энэ бүлэгт 2025 онд ШБҮ-ний судалгаанд оролцогчдын Монгол улс дах авлига, түүний шалтгаан нөхцөл, авлигыг бууруулах, хэрхэн урьдчилан сэргийлэх, авлигын ирэх 2 жилийн төсөөлөл, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлсэн үр дүнг харууллаа.

3.1 Монгол улс дах авлигын өнөөгийн нөхцөл байдал

2025 оны ШБҮ-ний судалгаанд оролцогчдоос Монгол улсад авлига хэр түгээмэл байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 56.1 хувь нь ихээхэн түгээмэл, түгээмэл гэж хариулсан бол, 20.4 хувь нь дунд зэрэг, 6.2 хувь нь бага, 2,4 хувь нь огт байхгүй, 14.9 хувь нь мэдэхгүй, хариулахаас татгалзжээ. Энэ онд ихээхэн түгээмэл, түгээмэл гэж хариулсан оролцогчдын хувийг 2024 онтой харьцуулахад 1.5 пунктээр буурсан бол, дунд зэрэг ба бага гэж хариулсан оролцогчдын хувь харгалзан 1.0 ба 0.4 пунктээр өссөн байна. Авлига огт байхгүй гэж хариулсан оролцогчдын хувь 0.7 пунктээр буурч, мэдэхгүй/хариулаагүй оролцогчдын хувь 0.8 пунктээр тус өсжээ. Өмнөх онтой харьцуулахад авлигын түгээмэл байдлын төсөөлөлд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна. Хэрэв авлигын төсөөллийн хариултуудын дундаж оноог 0-100 хүртэлх үнэлгээнд шилжүүлбэл 32.2 оноотой буюу авлигын түгээмэл байдлын талаарх иргэдийн төсөөллийн оноо маш бага үнэлэмжтэй гэж дүгнэж болохоор байна⁹.

Зураг 19. Монгол улс дах авлигын өнөөгийн нөхцөл байдал, сүүлийн 5 жилээр



Монгол улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдлын төсөөлөл судалгаанд оролцогчдын хувьд ямар ялгаатай байгааг дараах хүснэгтээс харъя. Албан хаагчдын төлөөллийн хувьд түгээмэл гэсэн хариултын хувь бусад төрлийн оролцогчдоос өндөр бол дунд зэрэг гэсэн хариултад бодлогод оролцогчдын хариултын хувь давамгай байна. Харин бодлогод оролцогчдын хувьд мэдэхгүй/хариулаагүй гэсэн хариултын тоо нь бусад төлөөллүүдтэй харьцуулахад харьцангуй бага байна.

⁹ Ихээхэн түгээмэл - 0 оноо, Түгээмэл - 25 оноо, Дунд зэрэг - 50 оноо, Бага - 75 оноо, Огт байхгүй - 100 оноо гэж шилжүүлэв.

Хүснэгт 30. Монгол улс дах авлигын өнөөгийн нөхцөлийн төсөөлөл, судалгаанд оролцогчдын төрлөөр

Оролцогчид	Ихээхэн түгээмэл	Түгээмэл	Дунд зэрэг	Бага	Огт байхгүй	Мэдэхгүй/ хариулаагүй
Иргэд, ААН-ийн төлөөлөл	15%	40%	20%	6%	3%	16%
Албан хаагчдын төлөөлөл	16%	44%	19%	5%	2%	14%
Бодлогод оролцогчдын төлөөлөл	17%	40%	25%	7%	1%	10%

3.2 Монгол улс дах авлига хамгийн их тархсан институт

Монгол улсад авлига хамгийн их тархсан институтыг 2025 онд “Шүүх” тэргүүлж, “Газрын алба”, “Улс төрийн нам”, “Эрүүл мэндийн байгууллага”, “Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг” зэрэг институтүүд удаалсан байна. Өмнөх жил эдгээр институт мөн л хамгийн их авлига тархсан эхний 5 эрэмбэд жагссан бөгөөд гагцхүү эрэмбийн дараалал зөрүүтэй байсан байна.

Хүснэгт 31. Монгол улсад авлига хамгийн их тархсан институт, сүүлийн 5 жилээр, 2025 оны эрэмбээр, нийт оролцогчдоор, хувийн жингээр

№	Институтын нэр	2021	2022	2023	2024	2025
1	Шүүх	48.0	50.5	59.0	19.0	41.7
2	Газрын алба	41.8	48.9	55.0	14.7	41.2
3	Улс төрийн нам	30.5	34.2	44.5	14.7	37.2
4	Эрүүл мэндийн байгууллага	48.3	52.0	49.6	15.1	37.0
5	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	31.7	36.2	39.0	21.7	36.5
6	Гаалийн байгууллага	36.9	46.4	47.1	10.4	31.7
7	Цагдаагийн байгууллага	35.3	41.6	35.3	9.8	27.9
8	Прокурорын байгууллага	29.8	30.0	36.5	8.0	25.3
9	Боловсролын байгууллага	32.7	37.1	34.3	11.2	24.4
10	Нутгийн захиргааны байгууллага	22.2	26.1	28.0	10.9	23.1
11	Хэвлэл мэдээллийн байгууллага	16.1	22.8	27.2	7.9	21.1
12	Татварын байгууллага	26.5	28.8	23.2	7.3	20.4
13	Мэргэжлийн хяналтын байгууллага	33.4	39.7	18.4	6.7	15.5
14	Төрийн бус байгууллага	11.6	11.3	10.0	3.6	8.4
15	Хувийн хэвшил	10.5	9.9	11.0	3.4	6.8
16	Бусад	0.1	0.2	3.7	0.8	0.6

“Шүүхийн байгууллага”-ын хувьд 2023 онд мөн тэргүүлж байсан бол энэ онд дахин хамгийн их авлига тархсан гэсэн төсөөлөлтэй байна. Өмнөх жил “Төрийн захиргааны байгууллага, яам, агентлаг” тэргүүлж байсан бол энэ онд 5 дугаарт эрэмбэлэгджээ.

Монгол улсад авлига хамгийн их тархсан институтыг оролцогчдын төрлөөр авч үзвэл төрийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэд, ААН-ийн төлөөлөл болон бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд “Шүүх” институтэд хамгийн их авлига тархсан гэж үзсэн бол төрийн албан хаагчид “Газрын алба” гэж үзжээ.

Хүснэгт 32. Монгол улсад авлига хамгийн их тархсан институт, оролцогчдын төрлөөр

Иргэд, ААН-ийн төлөөлөл	№	Байгууллагын нэр	2025
	1	Шүүх	40.9
	2	Газрын алба	40.5
	3	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	39.0
	4	Улс төрийн нам	36.4
	5	Эрүүл мэндийн байгууллага	36.2
	6	Цагдаагийн байгууллага	28.7
	7	Гаалийн байгууллага	28.4
	8	Прокурорын байгууллага	25.7
	9	Боловсролын байгууллага	24.4
	10	Нутгийн захиргааны байгууллага	23.4

	11	Хэвлэл мэдээллийн байгууллага	19.8
	12	Татварын байгууллага	19.3
	13	Мэргэжлийн хяналтын байгууллага	14.9
	14	Төрийн бус байгууллага	9.3
	15	Хувийн хэвшил	7.3
Албан хаагчдын төлөөлөл	1	Газрын алба	44.6
	2	Шүүх	43.9
	3	Гаалийн байгууллага	43.4
	4	Эрүүл мэндийн байгууллага	41.5
	5	Улс төрийн нам	39.9
	6	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	26.8
	7	Татварын байгууллага	24.9
	8	Хэвлэл мэдээллийн байгууллага	24.2
	9	Цагдаагийн байгууллага	24.2
	10	Прокурорын байгууллага	23.8
	11	Боловсролын байгууллага	23.8
	12	Нутгийн захиргааны байгууллага	20.4
	13	Мэргэжлийн хяналтын байгууллага	18.5
	14	Төрийн бус байгууллага	5.8
	15	Хувийн хэвшил	5.6
Бодлогод оролцогчдын төлөөлөл	1	Шүүх	43.3
	2	Газрын алба	40.6
	3	Улс төрийн нам	38.6
	4	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	36.1
	5	Гаалийн байгууллага	35.2
	6	Эрүүл мэндийн байгууллага	34.4
	7	Цагдаагийн байгууллага	28.3
	8	Нутгийн захиргааны байгууллага	26.1
	9	Боловсролын байгууллага	26.1
	10	Хэвлэл мэдээллийн байгууллага	24.8
	11	Прокурорын байгууллага	24.8
	12	Татварын байгууллага	20.6
	13	Мэргэжлийн хяналтын байгууллага	15.2
	14	Төрийн бус байгууллага	6.7
	15	Хувийн хэвшил	5.7

3.3 Монгол улс дах авлигын шалтгаан

2025 оны байдлаар нийт судалгаанд оролцогчдоос авлигын шалтгааныг асуухад 15.7 хувь нь цалин хөлс бага, 9.8 хувь нь ажилгүйдэл, амьжиргааны түвшин доогуур байдал, 7.6 хувь нь хувь хүний хандлага, шуналтай байдал, ёс зүй дутмаг байдал, 7.4 хувь нь хүнд суртал их, 4.5 хувь нь төрийн албан дахь улс төрийн намуудын нөлөөлөл их гэсэн хариултууд нийт хариултад хамгийн их хувийг эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын үзэж байгаагаар Монгол улс дах авлигын шалтгааныг цалин хөлс бага байдал гэж тодорхойлсон бол өмнөх хоёр жилийн судалгаагаар харгалзан эрх мэдлээ урвуулан ашиглах, ашиг сонирхлын зөрчил болон хувь хүний хандлага, шуналтай, ёс зүй дутмаг байдал хамгийн их хариултын хувийг харуулж байсан. Өөрөөр хэлбэл, тэргүүлж буй хариулт сүүлийн 3 жилд харилцан адилгүй байна. Харин ажилгүйдэл, ядуурал, амьжиргааны түвшин доогуур байдал, хүнд суртал их зэрэг хариултууд голлох шалтгаанууд хэвээр байна.

Хүснэгт 33. Монгол улс дах авлигын үндсэн шалтгаан, судалгаанд нийт оролцогчдын хариултаар

№	Авлигын шалтгаан	2025
1	Цалин хөлс бага	15.7
2	Ажилгүйдэл, ядуурал, амьжиргааны түвшин, үнийн өсөлт	9.8
3	Хувь хүний хандлага, шунал, ёс зүй	7.6
4	Хүнд суртал их	7.4
5	Төрийн албан дахь улс төрийн намуудын нөлөөлөл их	4.5
6	Танил тал, хамаатан садны холбоо (уламжлалт хандлага)	4.4
7	Эрх мэдлээ урвуулан ашиглах, эрх мэдэл төвлөрөл бий болсон	3.6
8	Ажлаа хурдан бүтээх хүсэл	3.5
9	Улс төр, бизнесийн бүлэглэл холилдсон	3.5
10	Хяналт сул	3.2
11	Ил тод бус байдал	3.0
12	Шударга бус (ижил тэгш үйлчилдэггүй)	3.0
13	Хариуцлага тооцдоггүй байдал	2.8
14	Хууль тэгш үйлчилдэггүй, хуулиа мөрддөггүй	2.7
15	Ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүс тухайн салбарт төрийн албанд ажилладаг	2.4
16	Тогтолцооны гажуудал	2.1
17	Боловсрол, мэдлэг муу	2.1
18	Холбогдох хууль тогтоомж зөрчилтэй, олон янзаар тайлбарладаг	1.7
19	Төрийн үйлчилгээний ачаалал их	1.6
20	Гар цайлгах, уламжлал сэтгэлгээ	1.4
21	Төрийн албан хаагчид чадваргүй	1.3
22	Ажлын шат дамжлага олон (элдэв зөвшөөрөл маш их шаарддаг)	1.2
23	Эрх зүйн орчин муу	1.2
24	Сургалт мэдээллээр хангадаггүй	1.1
25	Иргэд өөрсдөө авлигал өгдөг	0.9
26	Төрийн алба хаагчийн хариуцлагагүй байдал	0.6
27	Татвар өндөр	0.5
28	Төрийн байгууллага хангалттай цахимжаагүй	0.5
29	Ажиллах орчин муу (удирдах албаны дарам шахалттай)	0.4
30	АТГ мэдээлэл өгөх боломжуудыг нэмэгдүүлж, нууцлах	0.4
31	Ажлын байрны чиг үүрэг тодорхойгүй	0.3
32	Төрийн албан хаагчид тухайн ажлын байрандаа маш олон жил ажилласан байдаг нь	0.2
33	АТГ-ын үйл ажиллагаа хангалтгүй	0.0
34	Мэдэхгүй	5.1

3.4 Авлигыг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай ажлын чиглэл

Судалгаанд оролцогчдын уг асуултад өгсөн хариултаас харахад, авлига болон ашиг сонирхлын зөрчлийн талаарх хууль эрх зүйн мэдээллээр хангах, соёл гэгээрүүлэх нь авлигаас урьдчилан сэргийлэхэд хамгийн чухал гэж үзсэн хариулт хамгийн олонтоо давтагдаж, нийт хариултын 16.6 хувийг эзэлсэн байна.

Харин өмнөх оны судалгаанд авлигаас урьдчилан сэргийлэх хамгийн чухал арга хэмжээгээр цалин хөлс, хангамжийг нэмэгдүүлж, хангалттай түвшинд байлгах асуудлыг хамгийн ихээр онцолж байв. Тэгвэл энэ онд уг хариулт нийт хариултын 12.5 хувийг эзэлж, авлигаас урьдчилан сэргийлэх хоёр дахь чухал арга хэмжээгээр эрэмбэлэгдсэн байна

Цаашлаад нийт хариултын 11.1 хувь нь төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах, 8.6 хувь нь хяналтыг сайжруулах, 4.9 хувь улс төрөөс бизнесийн бүлэглэлийг ангид байлгах, 4.3 хувь нь шударга бус байдлыг бууруулах, 4.2 хувь нь хууль дүрмийг баримтлах, хүн бүрд тэгш үйлчилдэг байх, 4.1 хувь нь хувь хүний хандлагыг өөрчлөх, ёс зүйг сахиулах гэсэн хариултаудын давтамж удаалж байна.

Хүснэгт 34. Авлигыг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх шаардлагатай ажлын чиглэл

№	Авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх шаардлагатай чиглэл	2025
1	Авлига ашиг сонирхлын талаар болон хуулийн мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх	16.6
2	Цалин хангамж, орлогыг нэмэгдүүлэх	12.5
3	Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах	11.1
4	Хяналтыг сайжруулах (байгууллагын дотоод хяналт, хараат бус хянал, аудиторын үйл ажиллагааг сайжруулах)	8.6
5	Улс төрөөс бизнесийн бүлэглэлийг ангид байлгах	4.9
6	Шударга бус байдлыг бууруулах	4.3
7	Хууль дүрмийг баримтлах, хүн бүрд тэгш үйлчилдэг байх	4.2
8	Хувь хүний хандлагыг өөрчлөх, ёс зүйтэй иргэдийг бий болгох	4.1
9	Цахим үйлчилгээ нэвтрүүлж, хүний оролцоог багасгах, ажлын шат дамжлагыг багасгах	4.3
10	Хариуцлага тооцдог байх	2.9
11	Хүнд суртлыг бууруулах	1.7
12	Холбогдох хууль тогтоомжийг сайжруулах	1.6
13	Төрийн байгууллагаар үйлчлүүлэгчид өөрсдөө авлига өгөхгүй байх, уламжлалт буруу жишгээсээ салах	1.9
14	Төрийн алба хаагч хариуцлагатай байх	1.3
15	ТАХ-ын ажлын ачааллыг бууруулж, бүтээмжийг нэмэгдүүлэх, ажиллах орчин сайжруулах	1.3
16	Төрийн албан хаагчдыг чадавхжуулах	1.2
17	Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, амьжиргааны түвшин сайжруулах	1.2
18	Эрх зүйн орчныг сайжруулах, шинэчлэх, хатуу чанга болгох	1.1
19	Төрийн байгууллагаас нам, улс төрийн оролцоо бууруулах	1.1
20	Тогтолцоо буруу (Улс төр, засаглал, авлигын сүлжээ зэргийг тогтолцооны хувьд засах)	0.9
21	АТГ мэдээлэл өгсөн хүнийг нууцлах, авсан хүнийг шийтгэх, мэдээлэл өгөх тогтолцоог бий болгох	0.9
22	Эрх мэдлээ урвуулан ашиглах явдлыг таслан зогсоох, эрх мэдлийн төвлөрлийг сааруулах	0.6
23	Танил тал, хамаатан садны холбоо	0.5
24	Татварыг бууруулах	0.5
25	Ажлын байрны чиг үүргийг тодорхой болгож давхардлыг бууруулах	0.5
26	Ашиг сонирхлын зөрчлийг арилгадаг байх	0.4
27	Удаан ажилласан хүмүүсийг өөрчилж байх	0.4
28	АТГ-ын үйл ажиллагааг сайжруулах	0.2
29	Ажилтантай ганцаарчилсан уулзалт, ярилцлага хийдэг болох	0.1
30	Төрийн албанд мерит зарчим баримтлах	0.1
31	Мэдэхгүй	9.0


Хэдийгээр судалгаанд оролцогчдоос тухайн байгууллага дахь авлигыг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд ямар ажил хийх шаардлагатай талаар тодруулж байгаа нь сайшаалтай ч, эдгээр ажлуудыг хэн зохион байгуулж, үйл ажиллагаандаа тусгаж, хэрэгжүүлж байгаа эсэх нь эргэлзээтэй. Судалгаанд оролцогчдоос гарсан нийтлэг хариултуудыг багцалж байгаа ч, цаашид судалгааны асуултад ямар байгууллага ямар үйл ажиллагааг хэрэгжүүлээд ямар үр дүнд хүрсэн талаар ороогүй байгаа нь эдгээр ажлуудыг асуусны үр дүн гарахгүй байна гэж үзэж байна. Тиймээс АТГ цаашид үүнийг анхаарч үзэх шаардлагатай байна.

3.5 Монгол улс дах авлигын түвшин ирэх 2 жилд хэрхэн өөрчлөгдөх талаар төсөөлөл

Монгол улс дах авлигын түвшний ирэх 2 жилийн өөрчлөлтийн төсөөллийг судалгаанд оролцогчдоос асуухад судалгаанд оролцогчдын 22 хувь нь их өснө, өснө гэж хариулсан бол, 32.7 хувь нь өөрчлөгдөхгүй хэмээн хариулжээ. Харин 15.1 хувь нь буурна гэж үзсэн бол, 1.9 хувь нь их буурна хэмээн хариулжээ. Мэдэхгүй, хариулаагүй оролцогчдын хувь 28.3 хувь байна. Ирэх 2 жилийн авлигын төсөөллийг өмнөх жилтэй харьцуулбал авлига өснө эсвэл өөрчлөгдөхгүй гэсэн төсөөлөл нэмэгдэж, буурна гэсэн хүлээлт багассаныг

харж болно. Харин 2024 оны судалгаанд гарсантай адил мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна.

Зураг 20. Монгол улс дах авлигын түвшин ирэх 2 жилд хэрхэн өөрчлөгдөх талаар төсөөлөл, сүүлийн 5 жилээр



Монгол улс дах авлигын ирэх 2 жилийн түвшний төсөөлөл судалгаанд оролцогчдын бүлгийн хооронд ялгаатай байна. Төрийн үйлчилгээ авсан иргэд, ААНБ-ын хувьд их өснө ба өснө хариултууд бусад хоёр бүлгээс их, нийлээд 24.5%-ийн жинтэй байгаа бол албан хаагчдын 13.9%, бодлогод оролцогчдын 18.8% нь байгаа нь нэлээд ялгаатай төсөөлөлтэй байна. Өөрчлөгдөхгүй, буурна, мэдэхгүй гэсэн хариултын хувиуд мөн гурван бүлэг хооронд ялгаа их байна. Харин ирэх 2 жилийн төсөөлөлд их буурна гэсэн хариултын хувьд ойролцоо үр дүнтэй байна.

Хүснэгт 35. Монгол улс дах авлигын түвшний ирэх 2 жилийн төсөөлөл, судалгаанд оролцогчдын төрлөөр

Оролцогчид	Их өснө	Өснө	Өөрчлөгдөхгүй	Буурна	Их буурна	Мэдэхгүй/Хариулаагүй
Иргэд, ААН-ийн төлөөлөл	5.4%	19.1%	32.8%	13.6%	1.9%	27.2%
Албан хаагчдын төлөөлөл	2.6%	11.3%	29.4%	18.7%	2.0%	36.0%
Бодлогод оролцогчдын төлөөлөл	3.6%	15.2%	38.0%	19.4%	1.8%	22.0%


Ирээдүйн авлигын түвшний хүлээлт судалгааны бүлгийн хооронд харилцан адилгүй, цаашлаад судалгаанд оролцогч ямар шалтгаанаар тухайн хариултыг өгч байгааг одоогийн асуулгын судалгаагаар тодруулах боломжгүй байна.

3.6 Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр дүн

Судалгаанд оролцогчдоос АТГ-ын үйл ажиллагааны үр дүн үр ашигтай байгаа талаар тодруулахад судалгаанд оролцогчдын 16.4 хувь нь ихээхэн үр ашигтай, үр ашигтай, 38.6 хувь нь дунд зэрэг, 14.4 хувь нь үр ашиггүй, 8.7 хувь нь огт үр ашиггүй, 21.9 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Эдгээр хариултыг 2024 онтой харьцуулахад ихээхэн үр ашигтай, үр ашигтай гэж хариулагчдын хувь 2.3 пунктээр, үр ашиггүй гэсэн хариултын хувь 1.7 пунктээр тус тус буурч үнэлэгдсэн байна. Харин дунд зэрэг гэж хариулагчдын хувь 2.3

пунктээр, огт үр ашиггүй гэж хариулагчдын хувь 1.4 пунктээр тус тус өссөн байна. Хэрэв хариултуудын дундаж оноог 0-100 хүртэлх онооны хэмжээст шилжүүлбэл АТГ-ын үйл ажиллагааны үр дүнг өмнөх онд 52.9 гэж үнэлсэн бол энэ онд 54.2 гэж үнэлж болохоор байна.

Зураг 21. АТГ-ын үйл ажиллагааны үр дүнгийн төсөөлөл, сүүлийн 5 жилээр



АТГ-ын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ оролцогчдын хувьд ялгаатай байгаа эсэхийг харахад иргэд, ААН-ийн төлөөлөл ба төрийн албан хаагчдын хувьд ялгаа бага байна. Харин бодлогод оролцогчдын хувьд мэдэхгүй гэсэн хариултын хувь нөгөө оролцогчидтой харьцуулахад нэлээд бага болж, ихээхэн үр ашигтай, үр ашигтай болон дунд зэрэг гэсэн хариултуудын хувь нэмэгдсэн байна.

Хүснэгт 36. АТГ-ын үйл ажиллагааны үр дүн, оролцогчдын төрлөөр

Оролцогчдын төрөл	Ихээхэн үр ашигтай	Үр ашигтай	Дунд зэрэг	Үр ашиггүй	Огт үр ашиггүй	Мэдэхгүй/хариулаагүй
Иргэд, ААН-ийн төлөөлөл	2.3%	13.2%	38.5%	14.4%	9.1%	22.5%
Төрийн албан хаагчид	1.9%	14.7%	38.0%	14.2%	7.8%	23.4%
Бодлогод оролцогч, шинжээчид	2.7%	19.2%	40.9%	14.3%	7.3%	15.6%

Харин огт үр ашиггүй гэж иргэд, ААН-ийн төлөөллүүд харьцангуй өндөр хариулсан байгаагаас харахад иргэдийн хувьд АТГ-ын үйл ажиллагаа чухал бус байж болох талтай байна. Бодлогод оролцогчдын хувьд огт үр ашиггүй гэж хариулсан хариултын хувь бусад оролцогчидтой харьцуулахад харьцангуй бага байгаа нь бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд АТГ-ын үйл ажиллагааны талаар харьцангуй мэдээлэл өндөр байж болох юм.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн дагуу Авлигатай тэмцэх газар нь төрийн байгууллагуудын шударга байдлыг үнэлж, олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээдэг. Энэ үүргийн хүрээнд тус газар нь 2015 оноос шударга байдлын үнэлгээний судалгааг эхлэн өдгөө 9 дэх удаагийн судалгааг зохион байгуулаад байна.

Шударга байдлын үнэлгээ нь гадаад болон дотоод шударга байдал, мөн бодлогод оролцогчдын үнэлгээнээс бүрддэг. 2025 оны Шударга байдлын үнэлгээний судалгаанд нийт 10,840 иргэн болон аж ахуйн нэгжийн төлөөлөл, 2,660 төрийн албан хаагчийн төлөөлөл, 1,530 бодлогод оролцогч, шинжээчийн төлөөлөл хамрагдсан бөгөөд судалгааны үр дүнд дараах дүгнэлтүүдийг гаргав.

- Төрийн байгууллагуудын ШБҮ 74.9 болж өмнөх оноос 2.3 оноогоор өссөн. ШБҮ-г анх эхэлснээс одоог хүртэл хамгийн багадаа 2018 онд 68.7 оноогоор, хамгийн ихдээ 2023 онд 76.6 оноогоор үнэлэгдэж байсан. Энэ хугацаанд дундаж ШБҮ нь 73 байгаа бол 2025 оны үнэлгээ энэхүү дунджаас өндөр гарсан. Гэсэн хэдий ч төрийн байгууллагуудын ШБҮ нь хангалттай түвшинд хүрээгүй хэвээр байна.
- ШБҮ-ний бүрэлдэхүүн болох ГШБҮ 1.6 оноогоор, ДШБҮ 0.8 оноогоор, БОҮ 4.5 оноогоор тус тус өссөнөөр ШБҮ-ний дундаж оноог нэмэгдүүлжээ. Өмнөх онд БОҮ хамгийн ихээр буурсан байсан бол энэ онд хамгийн их өсөлттэй үзүүлэлт болсон байна.
- Гурван бүрэлдэхүүний үнэлгээ харгалзан 70.7, 82.4 ба 71.7 оноотой тус тус байна. Өмнөх жилүүдтэй адил төрийн албан хаагчдын байгууллагынхаа шударга байдлыг үнэлэх үнэлэмж бусад оролцогчдоос өндөр хэвээр байлаа. Түүнчлэн үнэлгээнүүдийн хэлбэлзлийн коэффициентийг тооцож харвал ГШБҮ 14.4% , ДШБҮ 7.3%, БОҮ 12.7%-тай байна. Гадаад оролцогчдын төрийн байгууллагын шударга байдлын талаарх үнэлгээнд саналын ялгаатай байдал ДШБҮ-ээс өндөр байна.
- ГШБҮ-г тооцоход ашигладаг *авлигын эрсдэлийн индекс* ба *авлигын индекс* харгалзан 63.4 ба 77.9 гэсэн үнэлгээтэй өмнөх оноос 2.1 ба 2.6 оноогоор өссөн байлаа. Эдгээрт хамаарах 5 дэд үзүүлэлтээс ил тод байдал, хариуцлагатай байдал ба авлигын талаарх төсөөлөл зэрэг 3 дэд үзүүлэлт харгалзан 59.7, 67.0 ба 65.6 гэсэн үнэлгээтэй байгаа ба өмнөх жилүүдэд ч мөн л ийм хандлага хадгалагдсаар ирсэн. Үлдсэн хоёр дэд үзүүлэлт болох авлигын шууд ба шууд бус тохиолдлын хувьд дунджаар 84 орчим үнэлгээтэй байна. Ил тод байдлын хувьд хүний нөөц ба үйл ажиллагааны ил тод байдал, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг иргэд, ААНБ-ын төлөөлөл үнэлдэг ба хамгийн бага үнэлгээтэй дэд үзүүлэлт болсоор байдаг. Төрийн байгууллагуудын хувьд ил тод байдлыг дээшлүүлэх, шилэн данс, цахим хуудсаар мэдээллийг байршуулах, үйлчилгээний үйл явцыг цахимжуулах ажил хийсээр байгаа ч эдгээр мэдээллийн хувьд бага үнэлгээтэй хэвээр байгаа шалтгааныг тодруулах шаардлагатай. Хариуцлагатай байдлыг үйлчилгээ үзүүлэх үед гаргасан хүчин чармайлт болон ёс зүйгүй үйлдэл гаргасан эсэх гэсэн хоёр үзүүлэлтээр үнэлдэг ба хоёр үзүүлэлтийн дундаж үнэлгээ 66-67 онооны хооронд буюу ялгаагүй үнэлгээтэй байгаа юм. Авлигын талаарх төсөөллийг 6 төрлийн үзүүлэлтээр үнэлдэг бөгөөд эдгээрээс “ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг” болон “бусдад хууль бусаар давуу байдал олгодог” гэсэн нөхцөлүүд хамгийн бага үнэлгээг авсан байна.

Тиймээс ГШБ-аар дамжуулан төрийн байгууллагын шударга байдлыг бэхжүүлэхэд дээрх хүчин зүйлсийг харгалзан, шалтгааныг илрүүлэх, сайжруулах арга хэмжээг төлөвлөж ажиллавал зохистой нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

- ДШБҮ-ний дэд үзүүлэлтүүд болох *соёлын индекс* ба *үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс* нь харгалзан 75.6 ба 89.3 онооны үнэлгээтэй, +1.7 ба -0.7 гэсэн өөрчлөлтийг үзүүлсэн. Эдгээрт хамаарах 7 дэд үзүүлэлтээс *авлигын эсрэг тогтолцоо* ба *удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл* үзүүлэлтүүд бага үнэлгээтэй гардаг. Энэ онд харгалзан 69.5 ба 72.8 оноо гэсэн үр дүнг үзүүлсэн. Бусад 5 дэд үзүүлэлт 81.6 – 99.1 гэсэн онооны үнэлгээтэй бөгөөд төдийлөн өндөр өөрчлөлтгүй байлаа. Байгууллагын дотоод албан хаагчид нь *авлигын ба шударга байдал алдагдах зөрчлийг мэдээлэгчийг хамгаалсан байдал, дотоод хяналтын механизм бүрдсэн байдал* цаашлаад *дээд ба дунд түвшний удирдлагуудын авлигаас сэргийлэх хүсэл эрмэлзэл* зэрэг үзүүлэлтүүдэд бага үнэлгээ өгсөн ба энэ нь өмнөх оны үр дүнтэй адил байна. Үүнээс төрийн байгууллагын албан хаагчид шударга байдлыг бэхжүүлэх дотоод орчны хичээл чармайлтаа нэмэгдүүлэх, шаардагдах систем, дэд бүтцийг бий болгох, бэхжүүлэх хүсэлт, шаардлагатай байгааг харж болохоор байна.
- БОҮ нь 4 дэд үзүүлэлтээс бүрдэх ба энэ онд бодлогод оролцогчдын тухайн байгууллага дахь *авлигын талаарх төсөөлөл, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, авлигын бодит тохиолдол* гэсэн үзүүлэлтийн үнэлгээ ШБҮ-ний бүх 16 дэд үзүүлэлтээс хамгийн их өсөлттэй байсан. Нөгөө талаар *авлигыг хянах механизм* ба *удирдлагын авлигатай тэмцэх хүсэл* үзүүлэлтүүдийг бодлогод оролцогч, шинжээчид харгалзан 51.8 ба 64.8 оноогоор үнэлсэн байна. Судалгааны жилүүдэд тухайн субъектийн авлигыг хянах механизмд өгч буй үнэлгээ нь ШБҮ-ний хамгийн бага дүнтэй үзүүлэлт байсаар ирсэн. Мөн БОҮ-ний бага үнэлгээтэй энэхүү 2 дэд үзүүлэлт нь өмнө дурдсан ДШБҮ-ний хамгийн бага дүнтэй 2 дэд үзүүлэлттэй адил байгаа нь тухайн байгууллагын үйл ажиллагааг сайн мэдэх хоёр субъект хоёулаа ижил дүгнэлтэд хүрж байгааг харуулж байна. Тиймээс эдгээр үзүүлэлтүүдэд анхаарахад хоёр оролцогч талын төрийн байгууллагын талаарх шударга байдлын үнэлэмжийг нэмэгдүүлэх, цаашлаад байгууллагын шударга байдлыг бэхжүүлэхэд үр дүнтэй арга хэмжээ болохоор байна.
- Энэ онд ШБҮ-ний 16 дэд үзүүлэлтээс (өмнөх гурван хэсэгт дурдсан) 2 үзүүлэлт бага зэргийн бууралттай, нэг үзүүлэлт өөрчлөлтгүй, бусад нь өсөлттэй байсан нь эерэг үр дүн болсон. Гэсэн хэдий ч төдийлөн өндөр өсөлтгүй буюу хангалтгүй үнэлгээтэй үзүүлэлт байсаар байгааг өмнөх хэсгүүдэд дүгнэсэн билээ.
- Төрийн байгууллагын ШБҮ-ний үр дүнд төрийн байгууллагуудын төрлийн ШБҮ-ний гүйцэтгэл ямар нөлөөтэй байсныг дүгнэвэл яамдын ШБҮ 0.8 оноогоор буурч 72.8 дүнтэй, агентлагуудын үнэлгээ 3 оноогоор өсөж, 77.3 гэсэн дүнтэй, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ 3.3 оноогоор өсөж, 71.4 гэсэн үнэлгээг тус тус үзүүлсэн. ШБҮ-ний өөрчлөлтөд аймаг, нийслэлийн ЗДТГ их нөлөөтэй байгаа ч ерөнхий шударга байдлын түвшинд хамгийн бага үнэлгээтэй оролцогч хэвээр байна.
- Нийслэлийн 9 дүүргийг оруулахгүйгээр 72 төрийн байгууллагаас нийт 40 байгууллагын үнэлгээ өсөж, 24 байгууллагынх буурсан бол 8 байгууллагад үнэлгээ төдийлөн өөрчлөлтгүй гарсан. Хамгийн өндөр өсөлттэй 10 байгууллагын

онооны өөрчлөлт 10.8 – 24.2 байгаа бол хамгийн их бууралттай 10 байгууллагын онооны өөрчлөлт 5.5 – 12.3 байна.

- Энэ оны судалгаанд ШБҮ хамгийн өндөр 5 байгууллага нь Оюуны өмчийн газар, Боловсролын ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Онцгой байдлын ерөнхий газар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар байлаа. Оюуны өмчийн газар өмнөх оны байрыг хадгалж, 6.3 онооны өсөлттэйгөөр дахин тэргүүлсэн бол бусад 4 байгууллага 5.5 – 15.3 онооны хооронд өсөлтийг үзүүлж, олон байраар урагшилсан үр дүнтэй байсан.
- Хамгийн бага үнэлгээтэй 5 байгууллагыг дурдвал Мал эмнэлгийн ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Ховд аймгийн ЗДТГ, Дорнод аймгийн ЗДТГ, Боловсролын яам зэрэг байгууллага байсан. Эдгээрээс Мал эмнэлгийн газар ба Эрүүл мэндийн яамны ШБҮ харгалзан 10.3 ба 8 оноогоор буурч олон эрэмбэ ухарсан байсан бол бусад 3 байгууллага өөрчлөлт багатайгаар, өмнөх оны эрэмбээсээ ухарсан байв. Тайланд ШБҮ хамгийн бага 10 байгууллагын хувьд бүрэлдэхүүн, дэд үзүүлэлт ба нэгж асуултуудаар шинжилгээ хийж, нөлөөлсөн үзүүлэлтүүдийг тодруулсан ба тухайн байгууллага бүр бага оноо авсан эсвэл их бууралттай үзүүлэлтүүдийн шалтгааныг тодруулах, сайжруулах арга хэмжээг төлөвлөж ажиллах шаардлагатай. Түүнчлэн чиг үүргийн хувьд ойролцоо, тухайлбал ЗДТГ-ууд өндөр үнэлгээтэй байгууллагын сайн туршлагыг судлан хэрэгжүүлэх ч боломжтой юм.
- Яамдын ШБҮ нь 2025 онд 73.5 болж, өмнөх оноос дахин 0.8 оноогоор буурсан байна. Бууралтын гол шалтгаан нь ГШБҮ 3.2 оноогоор буурсантай холбоотой байв. Үүн дотроо ГШБҮ-ний 5 дэд үзүүлэлтээс авлигын шууд тохиолдол (7.2↓) ба ил тод байдал (4.0↓) зэрэг үзүүлэлтүүд хамгийн их бууралттай байгаа бол хамгийн бага үнэлгээтэй нь ил тод байдал (58.3), авлигын талаарх төсөөлөл (63.1), хариуцлагатай байдлын (64.5) үзүүлэлтүүд байна. Тиймээс яамд нь ил тод байдал, хариуцлагатай байдлыг хангаж буй тал дээр анхаарч, нягтлах, цаашлаад авлигын төсөөллийн үзүүлэлтүүдийн мөрөөр мөн нягтлах хэрэгтэй байна. Түүнчлэн авлигын шууд тохиолдол өмнөх оноос нэмэгдсэн байгааг анхаарч шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын чиглэлээр үр дүнтэй ажиллах тал дээр анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.
- Өмнөх онд буураад байсан агентлагуудын ШБҮ нь 2025 онд 3 оноогоор өсөж 77.3-д хүрсэн. Ийнхүү өсөхөд голчлон ГШБҮ 4.5 оноогоор өссөн, БОҮ 4 оноогоор өссөн явдал нөлөөлжээ. Хэдийгээр өмнөх оноос өсөлттэй байгаа нь эерэг үр дүн ч цаашид үнэлгээг нэмэгдүүлэх шаардлагатай үзүүлэлтүүд байсаар байна. Эдгээр нь ил тод байдал, хариуцлагатай байдал, авлигын эсрэг тогтолцоо буюу авлигыг хянах механизм, удирдлагын хүсэл эрмэлзэл зэрэг үзүүлэлтүүд байна. Яамдтай харьцуулахад авлигын шууд ба шууд бус тохиолдол бага гэж үнэлсэн байсан ч төсвийн зарцуулалт, үүргэ даалгаврын шударга байдал зэрэгт шударга байдал зөрчигдөх тохиолдлууд байгааг анхаарах хэрэгтэй.
- Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын ШБҮ хамгийн их өсөлттэй боловч хамгийн бага үнэлгээтэй бүлэг хэвээр байна. Хамгийн их өсөлттэй бүрэлдэхүүн нь БОҮ байсан ба тус бүлэг субъект нь авлигын талаарх төсөөлөл, авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл гэсэн 3 дэд үзүүлэлтэд өмнөх оноос өндөр дүнгээр сайжирсан оноог өгсөн байна. ГШБҮ-ний хувьд өмнө дурдсан ил тод байдал, хариуцлагатай байдал, авлигын талаарх төсөөллийн үнэлгээнээс гадна аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хувьд авлигын шууд тохиолдлууд нэлээд бага

үнэлгээг авсан. Ялангуяа төрийн үйлчилгээ авч байхдаа нэмэлт төлбөр хүлээн авах, шууд ба шууд бус байдлаар бэлэг хүлээн авах зэрэг үйл явдлын давтамж өндөр байгааг анхаарах шаардлагатай. Харин БОУ ба ДШБҮ дээр төрийн байгууллагын төрлөөс үл хамааран нийтлэгээр бага үнэлгээтэй байсаар байгаа үзүүлэлтүүдийг мөн л нягтлах, шалтгааныг тодруулах, арга хэмжээг төлөвлөх ажлыг хэрэгжүүлэхээр байна.

- Нийслэлийн 9 дүүргийн ШБҮ-г тусад нь нэгтгэн тайлагнасан. Дундаж ШБҮ нь өмнөх оноос 4.4 оноогоор өсөж, 76.5 хүрсэн ба бусад төрийн байгууллагуудын дундаж ШБҮ 74.9-ээс дээш үнэлгээтэй байгаа юм. Өмнөх онтой харьцуулахад ГШБҮ ба БОУ нь харгалзан 8.1 ба 7.0 оноогоор өсөж, ДШБҮ нь 1.8 оноогоор буурсан. 9 дүүргийн ШБҮ бүгд өмнөх оноос өссөн байна. Энэ оны судалгаанд Хан-Уул дүүрэг дахин тэргүүлсэн бол Сонгино хайрхан дүүрэг сүүлийн эрэмбэд жагссан байна.
- Асуулгын хүрээнд судалгаанд оролцогчдоос Монгол Улсын авлигын нөхцөл байдлын талаар асуултуудыг тавьдаг. Нийт 15030 оролцогчоос 56.1 хувь нь Монгол улсад авлига ихээхэн түгээмэл ба түгээмэл байна гэж хариулсан бөгөөд энэхүү үзүүлэлт нь өмнөх оноос 1.5 пунктээр буурсан бол, дунд зэрэг ба бага гэж хариулсан оролцогчдын хувь харгалзан 1.0 ба 0.4 пунктээр өссөн байна. Өмнөх онтой харьцуулахад авлигын түгээмэл байдлын төсөөлөлд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй бөгөөд 0-100 хүртэлх оноогоор дундаж үнэлгээнд шилжүүлбэл 32.2 буюу авлигын түгээмэл байдлын талаарх иргэдийн төсөөллийн оноо маш бага үнэлэмжтэй байна. Өмнөх оны судалгаанд авлигын энэхүү төсөөллийн асуулт их хэмжээний өөрчлөлтэй орж ирсэн бол энэ онд өмнөх оноос төдийлөн ялгаагүй байна.
- 2025 онд Монгол улсад авлига хамгийн их тархсан институтийг “Шүүх” тэргүүлж, “Газрын алба”, “Улс төрийн нам”, “Эрүүл мэндийн байгууллага”, “Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг” зэрэг институтүүд удаалсан байна. Өмнөх жил эдгээр институт мөн л хамгийн их авлига тархсан эхний 5 эрэмбэд жагссан бөгөөд гагцхүү эрэмбийн дараалал зөрүүтэй байсан байна. Шүүх, газрын алба, эрүүл мэндийн байгууллага нь нийгэмд хамгийн их хүртээмжгүй байдалтай, асуудал шийдвэрлэх үйл явц хугацаа их ордог, олон дахин ирж үйлчилгээ авах болдог зэрэг онцлогтой байна. Харин улс төрийн нам ба төрийн захиргааны байгууллага нь намын нөлөөлөл, хууль бусаар давуу байдал олгох явдал их зэрэг шүүмжлэл нийгэмд түгээмэл байдаг шинж чанартай.
- Монгол улс дахь авлигын шалтгааныг энэ онд эргээд цалин хөлс бага, амьжиргааны түвшин доогуур зэрэг үзүүлэлт тэргүүлж эхэлсэн. Тухайлбал, өмнөх онд хувь хүний хандлага, шуналтай байдал, ёс зүйн дутмаг байдал тэргүүлэх хүчин зүйл болсноор өмнөх жилүүдийн хэвшмэл хариулт эвдэгдээд байсан юм. Гэхдээ хувь хүний хандлага, шунал ёс зүй, хүн суртал их байдал, төрийн албан дахь улс төрийн намуудын нөлөөлөл зэрэг шалтгаанууд тэргүүн эгнээнд хадгалагдсан хэвээр байна.
- Судалгаанд оролцогчдын ирэх 2 жилийн авлигын төсөөллийг өмнөх жилтэй харьцуулбал авлига өснө эсвэл өөрчлөгдөхгүй гэсэн төсөөлөл нэмэгдэж, буурна гэсэн хүлээлт багассаныг харж болно. Гэхдээ 2024 оны судалгаанд гарсантай адил мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна. Өмнөх онд сонгуулийн жилийн

нөлөөллөөр Монгол Улсын авлигын нөхцөл байдлын талаарх судалгаанд оролцогчдын төсөөлөл нийтлэгээр мэдэгдэхүйц өөрчлөлттэй гарсан байж болзошгүй. Харин энэ оны судалгаанд өмнөх оноос их өөрчлөлттэй хүчин зүйл ажиглагдсангүй.

- Авлигыг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд нэн тэргүүнд хийх шаардлагатай байгаа ажлын чиглэлийг авлига ашиг сонирхлын талаар болон хуулийн мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх гэж тодорхойлсон нь өмнөх онуудад онцолдог цалин хангамжийг нэмэгдүүлэх гэсэн хариултаас ялгаатай байлаа. Нөгөө талаас цалин хангамжийг нэмэгдүүлэх, ил тод байдлыг хангах, хяналтыг сайжруулах зэрэг хариултууд олон давтамжтай хэвээр байна.

ЗӨВЛӨМЖ, САНАЛ

1. Энэхүү судалгаа нь тоон судалгааны хэлбэр буюу тухайн байгууллага нь шалгуур үзүүлэлтүүдэд ямар үнэлгээ авсан болон хэрхэн өөрчлөгдсөн талаарх мэдээллийг голчлон харуулдаг. Шударга байдал зөрчигдөж буй нөхцөл байдлын цөөн асуултуудад шалтгааныг тодруулах чанарын асуултуудыг дагуулж тодруулсан байдаг. Иймээс байгууллагууд бүрэлдэхүүн, дэд үзүүлэлт болон нэгж асуултын түвшинд үр дүн, өөрчлөлтийг шинжилж, анхаарах шаардлагатай талбаруудыг тодруулан, түүнд нөлөөлсөн хүчин зүйлс, шалтгааныг эрэлхийлэн, сайжруулах арга хэмжээг төлөвлөх боломжтой. Мөн ШБҮ-ний судалгааны аргачлал, үр дүнгийн талаар санал өгөх боломжтой.
2. Чухал ач холбогдол бүхий үзүүлэлтүүдэд шалтгаан, шийдлийг тодруулах нэмэлт асуултууд оруулах, шударга байдлыг бэхжүүлэхэд ач холбогдол бүхий үзүүлэлтүүдийг нэмэх зэрэг санал, санаачлалыг авч үзэн аргачлалд өөрчлөлт оруулах боломжтой.
3. Жил бүр авч буй ШБҮ-ний судалгааны үр дүнгээр төрийн байгууллагуудын хэрэгжүүлж буй арга хэмжээ нэг жилийн дотор үр дүн үзүүлэхгүй байж болох талтай тул судалгааг 2 жил тутамд нэг удаа авах боломжтой.
4. ШБҮ-ний судалгааны ач холбогдлыг байгууллагуудад таниулан, хангалтгүй үзүүлэлтийн шалтгаан нөхцөлийг дотооддоо тодруулах эргээд АТГ-т сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний хамт танилцуулах зэргээр санаачилгатай, эргэх холбоотой ажиллах зэрэг энэхүү судалгааны үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой.

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Түүврийн хэмжээ, бүтэц

№	Байгууллага	Иргэдээс авах	Албан хаагчдаас авах	Шинжээчдээс авах
	Яамд	1840	660	400
1	Байгал орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	120	50	25
2	Барилга хот байгуулалтын яам	120	30	25
3	Батлан хамгаалах яам	100	30	25
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	120	50	25
5	Гадаад харилцааны яам	120	50	25
6	Зам, тээвэр хөгжлийн яам	120	50	25
7	Сангийн яам	120	50	25
8	Соёлын яам	100	30	25
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	120	30	25
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	120	50	25
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	120	50	25
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	120	50	25
13	Эрүүл мэндийн яам	120	50	25
14	Эрчим хүчний яам	120	30	25
15	Эдийн засаг хөгжлийн яам	100	30	25
16	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	100	30	25
	Агентлаг	3720	1050	680
1	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	100	30	20
2	Онцгой байдлын ерөнхий газар	100	50	20
3	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	120	15	20
4	Стандарт, хэмжил зүйн газар	100	50	20
5	Цаг уур, орчны шинжилгээний газар	100	20	20
6	Гаалийн ерөнхий газар	120	30	20
7	Татварын ерөнхий газар	120	50	20
8	Цагдаагийн ерөнхий газар	120	50	20
9	Улсын бүртгэлийн ерөнхий газар	120	50	20
10	Архивын ерөнхий газар	120	30	20
11	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	120	50	20
12	Гадаадын иргэн харьяатын газар	100	50	20
13	Нийгмийн даатгалын ерөнхий газар	120	30	20
14	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	120	20	20
15	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	120	20	20
16	Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн газар	100	30	20
17	Биеийн тамир, спортын улсын хороо	100	30	20
18	Соёл урлагийн газар	100	10	20
19	Иргэний нисэхийн ерөнхий газар	100	50	20
20	Ашигт малтмал, газрын тосны газар	120	50	20
21	Мал эмнэлгийн ерөнхий газар	120	20	20
22	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	120	50	20
23	Оюуны өмчийн газар	100	30	20
24	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	120	15	20
25	Төрийн худалдан авах ажиллагааны газар	120	20	20
26	Усны газар	100	15	20
27	Үндэсний геологийн алба	100	15	20
28	Жижиг, дунд үйлдвэрийн газар	120	20	20
29	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	100	30	20
30	Боловсролын ерөнхий газар	100	30	20
31	Ойн газар	100	15	20
32	Шүүх шинжилгээний ерөнхий газар	100	30	20
33	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	100	30	20
34	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	100	15	20
	Аймгийн засаг даргын тамгын газар	5280	940	450
1	Архангай аймгийн ЗДТГ	180	30	15

2	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	180	30	15
3	Баянхонгор аймгийн ЗДТГ	180	30	15
4	Булган аймгийн ЗДТГ	180	30	15
5	Говь-Алтай аймгийн ЗДТГ	180	30	15
6	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	150	30	15
7	Дархан-Уул аймгийн ЗДТГ	180	30	15
8	Дорноговь аймгийн ЗДТГ	180	30	15
9	Дорнод аймгийн ЗДТГ	180	30	15
10	Дундговь аймгийн ЗДТГ	180	30	15
11	Завхан аймгийн ЗДТГ	180	30	15
12	Орхон аймгийн ЗДТГ	180	30	15
13	Өвөрхангай аймгийн ЗДТГ	180	30	15
14	Өмнөговь аймгийн ЗДТГ	180	30	15
15	Сүхбаатар аймгийн ЗДТГ	180	30	15
16	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	180	30	15
17	Төв аймгийн ЗДТГ	180	30	15
18	Увс аймгийн ЗДТГ	180	30	15
19	Ховд аймгийн ЗДТГ	180	30	15
20	Хөвсгөл аймгийн ЗДТГ	180	30	15
21	Хэнтий аймгийн ЗДТГ	180	30	15
1	Нийслэлийн ЗДТГ	180	80	20
2	Багануур дүүргийн ЗДТГ	150	20	5
3	Багахангай дүүргийн ЗДТГ	150	15	5
4	Баянгол дүүргийн ЗДТГ	150	30	15
5	Баянзүрх дүүргийн ЗДТГ	150	30	15
6	Налайх дүүргийн ЗДТГ	150	15	15
7	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	150	30	15
8	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	150	30	15
9	Хан-Уул дүүргийн ЗДТГ	150	30	15
10	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	150	30	15
	Нийт	10840	2660	1530

Хавсралт 2. ШБҮ-ний нэгж асуултуудын үнэлгээ, өөрчлөлт

ГШБҮ	Ил тод байдал		Хариуцлагатай байдал		Авлигын талаарх төсөөлөл						Авлигын шууд тохиолдол									АШБТ*
	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A11.1	A11.2	A12	A12.1	A12.2	A13	A13.1	A13.2	A16
2024	59	57.9	63	65.3	65.4	58.2	59.8	63	62.9	64.6	93.3	68.4	87.8	94.7	68.8	90.7	93.5	78.5	81.7	83.8
2025	60.6	58.9	66.6	67.5	69	61.8	62.8	65.7	65.6	68.7	93.1	73	82.9	94.7	69.6	82.7	95.6	77.6	85.8	84.3
Өөрчлөлт	1.5	0.9	3.6	2.2	3.6	3.6	3	2.7	2.7	4	-0.2	4.6	-4.9	0	0.8	-8.1	2.2	-0.9	4.1	0.5

ДШБҮ	Албан бус хэм хэмжээ						Авлигын эсрэг тогтолцоо			Хүний нөөц					Төсвийн зарцуулалт			
	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A11.1	A11.2	A13	A14	A15	A15.1	A15.2
2024	76	72.4	73	74.9	87.7	92.7	65.7	72.8	66.4	88.7	99.6	97.6	96.8	99.5	86.2	97.2	93.9	97.3
2025	76.1	76.9	77.4	78.2	87.8	93.3	68.2	74.1	66.1	91.8	99.3	95.6	96.7	98.8	86	95.9	93.6	93.5
Өөрчлөлт	0.1	4.5	4.4	3.3	0.1	0.7	2.6	1.4	-0.2	3.1	-0.3	-2	-0.1	-0.7	-0.2	-1.3	-0.3	-3.9

ДШБҮ	Үүрэг даалгаврын шударга байдал				Гадаад орчин дахь авлигатай тэмцэх		Удирдлагын хүсэл эрмэлзэл		
	A17	A18	A19	A19.1	A20	A21	A22	A23	A24
2024	73.1	84.3	95.6	92.7	98.2	97.7	72.4	71.8	71.5
2025	72.1	83.3	95	92.5	99.6	98.6	73	72.4	72.9
Өөрчлөлт	-0.9	-1.0	-0.6	-0.2	1.4	0.9	0.6	0.7	1.5

БОУ	Авлигын талаарх төсөөлөл									Авлигын хяналт			Авлигын бодит тохиолдол		Удирдлагын хүсэл эрмэлзэл	
	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A12	A13	A14	A15	A16
2024	67.6	73.1	69.2	70.8	72.6	72	72.2	49.2	73	44.9	45.8	58.5	90.6	89.4	60.4	59.5
2025	76.1	80.3	77.9	78.4	81.5	80.4	79.9	54.9	80	46.1	47.2	62.1	94.2	93.2	65	64.7
Өөрчлөлт	8.5	7.2	8.8	7.5	8.8	8.4	7.7	5.8	7	1.2	1.4	3.6	3.6	3.7	4.6	5.2

Тайлбар: АШБТ* - Авлигын шууд бус тохиолдол

Хавсралт 3. ШБҮ-ний нэгж асуултууд, байгууллагын төрлөөр, 2025 он

ГШБҮ	Ил тод байдал		Хариуцлагатай байдал		Авлигын талаарх төсөөлөл						Авлигын шууд тохиолдол								АШБТ*	
	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A11.1	A11.2	A12	A12.1	A12.2	A13	A13.1	A13.2	A16
Ерөнхий	60.6	58.9	66.6	67.5	69.0	61.8	62.8	65.7	65.6	68.7	93.1	73.0	82.9	94.7	69.6	82.7	95.6	77.6	85.8	84.3
Яам	58.1	58.5	64.5	64.4	65.3	59.8	60.7	63.3	63.8	65.8	92.1	69.6	76.0	93.9	65.9	69.6	94.8	79.2	75.2	84.8
Агентлаг	65.3	62.7	71.9	72.2	74.8	68.2	68.5	70.9	70.6	73.2	96.5	88.2	87.5	97.2	84.6	85.8	97.7	87.3	93.0	90.0
Аймаг, нийслэлийн	54.9	53.1	59.8	62.4	62.8	53.3	55.6	59.2	59.1	63.6	88.5	52.0	80.9	91.4	49.2	87.3	93.0	61.7	82.5	75.2
Дүүргийн ЗДТГ	62.5	59.6	70.0	68.8	70.7	65.6	66.1	69.9	69.7	70.8	95.7	85.1	85.2	97.4	81.5	92.5	97.6	86.3	92.4	93.0

ДШБҮ	Албан бус хэм хэмжээ						Авлигын эсрэг тогтолцоо			Хүний нөөц					Төсвийн зарцуулалт			
	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A11.1	A11.2	A13	A14	A15	A15.1	A15.2
Ерөнхий	76.1	76.9	77.4	78.2	87.8	93.3	68.2	74.1	66.1	91.8	99.3	95.6	96.7	98.8	86.0	95.9	93.6	93.5
Яам	75.9	75.4	77.1	77.3	87.7	92.8	68.9	73.8	67.6	91.4	98.8	85.9	97.5	98.9	84.3	96.1	97.0	95.6
Агентлаг	75.0	75.9	77.2	77.6	87.0	92.9	67.2	74.3	65.8	92.6	99.4	98.1	97.2	98.8	87.4	95.5	91.2	90.8
Аймаг, нийслэлийн	77.9	79.4	78.0	79.6	89.0	94.4	69.4	74.2	65.6	90.7	99.5	98.6	95.3	98.6	85.0	96.2	94.8	96.0
Дүүргийн ЗДТГ	75.0	75.1	73.0	76.5	86.8	93.9	69.7	74.6	66.1	94.5	99.3	97.5	100.0	97.8	83.8	95.9	95.4	96.5

ДШБҮ	Үүрэг даалгаврын шударга байдал				Гадаад орчин дахь авлигатай тэмцэх		Удирдлагын хүсэл эрмэлзэл		
	A17	A18	A19	A19.1	A20	A21	A22	A23	A24
Ерөнхий	72.1	83.3	95.0	92.5	99.6	98.6	73.0	72.4	72.9
Яам	70.2	82.3	95.0	93.6	99.8	98.6	73.3	73.0	71.6
Агентлаг	71.4	83.8	94.4	91.6	99.5	98.6	72.8	72.2	73.4
Аймаг, нийслэлийн	74.6	83.3	96.0	93.0	99.8	98.7	73.2	72.4	73.1
Дүүргийн ЗДТГ	72.5	80.8	95.9	90.5	98.9	99.3	72.5	71.0	72.9

БОУ	Авлигын талаарх төсөөлөл									Авлигын хяналт			Авлигын бодит тохиолдол		Удирдлагын хүсэл эрмэлзэл	
	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A12	A13	A14	A15	A16
Ерөнхий	76.1	80.3	77.9	78.4	81.5	80.4	79.9	54.9	80	46.1	47.2	62.1	94.2	93.2	65	64.7
Яам	73.3	77.0	75.6	73.9	77.7	75.6	76.8	57.0	75.3	42.3	43.2	60.0	95.7	92.9	61.4	61.9
